



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО

**МОНГОЛ УЛСЫН АШИГТ МАЛТМАЛ ХАЙХ,
АШИГЛАХ ЗОРИУЛАЛТААР ГАЗАР, ТҮҮНИЙ
ХЭВЛИЙГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛӨӨР ОЛГОХ,
ТӨЛБӨР, ТАТВАР НОГДУУЛАХ, ХУРААХТАЙ
ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН**

Улсын Их Хурлын 2024 оны 25 дугаар тогтоолоор байгуулагдсан/

Улаанбаатар хот
2024 он

ХУРААНГУЙ

- Хянан шалгах түр хорооны санал, дүгнэлт;
- Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос “Ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, төлбөр, татвар ногдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их хурлын тогтоолын төсөл;
- Монгол Улсын Их Хурлын 2024 оны 25 дугаар тогтоолоор байгуулагдсан Хянан шалгах түр хорооны тайлан.

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	5
ҮЙЛ ЯВДЛЫН ХУРААНГУЙ	6
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР	7
Хянан шалгах ажлын зорилт	7
Хяналт шалгалтын ажлын зарчим.....	8
Хянан шалгах ажлын арга зүй	8
Хянан шалгагч, шинжээчдийн бүрэлдэхүүн, ажилласан хугацаа.....	9
Хяналт шалгалтын цар хүрээ	9
НЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	10
ХОЁР.НОТЛОХ БАРИМТ ИРҮҮЛЭХ ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ	11
ГУРАВ.НОТЛОХ БАРИМТЫН ИЖ БҮРДЭЛД ХЯНАЛТ ХИЙХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	26
ДӨРӨВ.АШИГТ МАЛТМАЛ ХАЙХ, АШИГЛАХ ЗОРИУЛАЛТААР ГАЗАР, ТҮҮНИЙ ХЭВЛИЙГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛӨӨР ОЛГОХ, ТӨЛБӨР, ТАТВАР НОГДУУЛАХ, ХУРААХТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ҮҮРЭГ БҮХИЙ ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ	26
ТАВ.УИХ-ЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ	30
ЗУРГАА.ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ ТАЙЛАН	33
1.АШИГТ МАЛТМАЛ ХАЙХ, АШИГЛАХ ЗОРИУЛАЛТААР ГАЗАР, ТҮҮНИЙ ХЭВЛИЙГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛӨӨР ОЛГОХ, БҮРТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	33
1.1.Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн олголт, бүртгэлийн үйл ажиллагаа.....	33
1.2. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайн давхцал.....	55
1.3.Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөн	77
2.ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛӨӨР ОЛГОСОН ГАЗАР, ТҮҮНИЙ ХЭВЛИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ АШИГЛАЖ БАЙГАА ЭСЭХ	81
2.1.Ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр олгосон газар, түүний хэвлийг зориулалтын дагуу ашиглаж буй эсэх, зөрчил, дутагдал	92
Экспортод гаргаж буй уул уурхайн гаралтай бүтээгдэхүүнд гарал үүслийн гэрчилгээ олгож буй байдалд хийсэн дүн шинжилгээ	107
2.2. Уул уурхайн салбарын байгаль орчны нөхөн сэргээлт, уурхайн хаалт.....	109
3.НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГААС АШИГТ МАЛТМАЛ ХАЙХ, АШИГЛАХ ЗОРИУЛАЛТААР ОЛГОЖ БУЙ ЗӨВШӨӨРӨЛ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ	112
3.1.Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгож буй түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн асуудал	112
3.2.Бичил уурхайн асуудлууд	122
4.АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИД ТӨЛБӨР, ТАТВАР НОГДУУЛАХ, ТАЙЛАГНАХ, ТӨЛӨХ, ХЯНАХ, ХУРААХ ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	132
4.1. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах, төлөх, хянах, хураах үйл ажиллагаа.....	132
4.2.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн эрх зүйн зохицуулалт, төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо	154

5.СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ АШИГТ МАЛТМАЛЫН ОРДЫН АШИГЛАЛТ, ЭЗЭМШИЛ.....	158
СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ОРДТОЙ ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН ОРЧИН.....	158
СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ АШИГТ МАЛТМАЛЫН ОРДУУДЫН ХИЛ ЗААГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ	161
ХАВСРАЛТ.....	163
<i>Хавсралт 1.2.1.1.Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй газарт давхцалтай өмчлүүлсэн газрын тоон статистик мэдээлэл (оноор, байршлаар)\.....</i>	<i>163</i>
<i>Хавсралт 1.2.3.1.Улсын хамгаалалтын зэрэглэлд байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт</i>	<i>165</i>
<i>Хавсралт 3.1.2.2.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайтай зэрэгцүүлэн олгосон судалгааг байршлаар харуулсан зураг</i>	<i>172</i>

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
АМГТХЭГ	Ашигт малтмал, газрын тосны Хэрэг эрхлэх газар /хуучин нэрээр/
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АМТХ	Ашигт малтмалын тухай хууль
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОНБҮ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
БОХТХ	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
БХГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээ
ГЕГ	Гаалийн Ерөнхий газар
ГУУЯ	Геологи, уул уурхайн яам /хуучин нэрээр/
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗСБНХУ	Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс /хуучин нэрээр/
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОХУ	Оросын Холбооны улс
ӨНАМНАТ	Өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
УИХ	Улсын Их Хурал
УБҮ	Уулын баяжуулах үйлдвэр
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
УУХҮС	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
УУҮТХ	Уул уурхай, үйлдвэр техникийн хэлтэс
УУС	Уул уурхайн сайд /хуучин нэрээр/
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХШТХ	Хянан шалгах түр хороо
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ЭБМЗ	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл
ЭХГУУС	Эрчим хүч геологи, уул уурхайн сайд /Хуучин нэрээр/

ҮЙЛ ЯВДЛЫН ХУРААНГУЙ

2024.04.12	Монгол Улсын Их Хурлын 25 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хороог байгуулав.
2024.04.15	Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооноос “Хянан шалгах түр хорооны даргыг сонгох тухай” 01 дүгээр тогтоолыг батлав.
2024.04.19	Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооноос “Хянан шалгагчийг томилж, ажлын даалгавар батлах тухай” 02 дугаар тогтоолыг батлав.
2024.04.19	Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооноос “Шинжээч томилох тухай” 03 дугаар тогтоолыг батлав.
2024.04.19	Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооноос “Хянан шалгах түр хорооны ажлын ерөнхий төлөвлөгөө батлах тухай” 04 дүгээр тогтоолыг батлав.
2024.04.26	Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооноос “Шинжээч томилох тухай” 05 дугаар тогтоолыг батлав.
2024.04.26	Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооноос “Нотлох баримт гаргуулах тухай” 06 дугаар тогтоолыг батлав.
2024.04.26	Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооноос “Хянан шалгагчийн ажлын хөлс, шинжээчийн төлбөр, урамшуулалт цалингийн хэмжээг тогтоох, түр хорооны зардал батлах, зарцуулах эрх олгох тухай” 07 дугаар тогтоолыг батлав.
2024.05.16	Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооноос “Хянан шалгах түр хорооны сонсголыг товлон зарлах тухай” 08 дугаар тогтоолыг батлав.
2024.05.16	Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооноос “Сонсгол даргалагчийг томилох тухай” 09 дүгээр тогтоолыг батлав.
2024.05.16	Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооноос “Нотлох баримтыг шинжлэн судлах дараалал тогтоох тухай” 10 дугаар тогтоолыг батлав.
2024.05.16	Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооноос “Түр хорооны сонсголд гэрчээр дуудах тухай” 11 дүгээр тогтоолыг батлав.
2024.05.16	Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооноос 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр баталсан “Нотлох баримт гаргуулах тухай” 06 дугаар тогтоолд өөрчлөлт оруулж, “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” 12 дугаар тогтоолыг батлав.
2024.05.17	Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооноос 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр баталсан “Түр хорооны сонсголыг товлон зарлах тухай” 08 дугаар тогтоолд өөрчлөлт оруулж, “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 13 дугаар тогтоолыг батлав.
2024.05.21	Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооноос “Шинжээчийг чөлөөлөх тухай” 14 дүгээр тогтоолыг батлав.
2024.05.21	Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооноос “Хянан шалгагчийг чөлөөлөх тухай” 15 дугаар тогтоолыг батлав.
2024.05.27	Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооноос “Түр хорооны сонсголд гэрчээр дуудах тухай тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” 16 дугаар тогтоолыг батлав.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.2, 34.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, төлбөр, татвар ногдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх” үүрэг бүхий Хянан шалгах Түр хороог байгуулсан.

Хянан шалгах ажлын зорилт

Хянан шалгагч, шинжээч нар ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, төлбөр, татвар ногдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүнг Улсын Их Хурлаас байгуулсан Хянан шалгах түр хороо, бусад эрх бүхий байгууллага, албан тушаалтанд танилцуулахад хяналт шалгалтын зорилт чиглэсэн. Үүнд:

СЭДЭВ 1: Ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, бүртгэх үйл ажиллагаа:

- 1.1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн олголт, бүртгэл;
- 1.2. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайн давхцал;
- 1.3. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөн;

СЭДЭВ 2: Тусгай зөвшөөрлөөр олгосон газар, түүний хэвлийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэх:

- 2.1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр олгосон газар, түүний хэвлийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэх, зөрчил, дутагдал;
- 2.2. Уул уурхайн салбарын байгаль орчны нөхөн сэргээлт, уурхайн хаалт;

СЭДЭВ 3: Нутгийн захиргааны байгууллагаас ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар олгож буй зөвшөөрөл, түүний хэрэгжилт:

- 3.1. Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгож буй түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн асуудал;
- 3.2. Бичил уурхайн асуудлууд;

СЭДЭВ 4: Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчид төлбөр, татвар ногдуулах, тайлагнах, төлөх, хянах, хураах үйл ажиллагаа:

- 4.1. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах, төлөх, хянах, хураах, үйл ажиллагаа;
- 4.2. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн эрх зүйн зохицуулалт (гэрээний болон жишиг үнэ);

СЭДЭВ 5: Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудын ашиглалт, эзэмшил:

- 5.1. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудын ашиглалт, эзэмшил.

Хяналт шалгалтын ажлын зарчим

Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуульд заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг баримтлахын зэрэгцээ хууль дээдлэх, хараат бус, иж бүрэн мэдээлэлд тулгуурлах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, хууль бусаар нөлөөлөхийг хориглох, ил тод байх зэрэг зарчмыг баримтлан ажилласан бөгөөд Улсын Их Хурлаас баталсан тусгай шалгалтын сэдэв, хүрээ хязгаарын хүрээнд хянан шалгах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Хянан шалгах ажлын явцад хууль хяналтын байгууллагад холбогдох сэдвийн хүрээнд шалгагдаж байгаа болон хяналт тавин ажиллаж байгаа хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд нөлөөлөхгүй байх зарчмыг баримтлан ажилласан.

Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос баталсан нотлох баримт гаргуулах тухай тогтоолын хүрээнд хуульд заасан хязгаарлалтын хэм хэмжээг баримтлан цуглуулсан нотлох баримтад үндэслэн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргаж, энэхүү тайланг бэлтгэсэн.

Хянан шалгах ажлын арга зүй

Хяналт шалгалтаар Монгол Улсын Их хурлын Хяналт шалгалтын тухай хуулиар тогтоосон бүрэн эрх, Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос баталсан нотлох баримт гаргуулах тухай тогтоолын хүрээнд төрийн байгууллагаас нотлох баримт гаргуулж авах, нотлох баримт гаргах өгөхийг холбогдох хуулийн этгээдээс шаардах, хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаа, нөхцөл байдалтай газар дээр нь танилцах, тэмдэглэл үйлдэх, Хянан шалгагчийн ажлын даалгаварт тусгасан нотлох баримтыг бүрдүүлэх, холбогдох дэд сэдвийн дагуу нэмэлт нотлох баримт цуглуулах, гэрчээр дуудах, гэрчээс мэдүүлэг авах, асуулт тавих зэрэг аргуудыг ашиглан хяналт шалгалтын нотлох баримт бүрдүүлж, цуглуулсан нотлох баримтад дүн шинжилгээ хийн тайлан, санал, дүгнэлтийг боловсруулсан.

Хяналт шалгалтын явцад хуулийн этгээдээс бүрдүүлсэн ажлын баримт материалын Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан нотлох баримтын шаардлагыг хангасан байх, хуулийн зохицуулалтын дагуу баримтын иж бүрэн байдал, хуулийн хүчин төгөлдөр байдлыг хангуулахад анхаарч ажилласан.

УИХ-ын Хянан шалгах түр хорооны 2024 оны 6, 12 дугаар тогтоолоор батлагдсан нотлох баримтыг цуглуулах хүрээнд холбогдох төрийн байгууллага, хуулийн этгээдээс шаардлагатай баримтат мэдээллийг гаргуулан авч, түүнд түшиглэн үнэлэх ажлыг гүйцэтгэсэн болно.

Хянан шалгагч, шинжээч нар хяналт шалгалтыг нотлох баримтад үндэслэн тухайн асуудлын нөхцөл байдлын шалтгаан, бодит байдалд суурилсан санал, дүгнэлт гаргаж, олон нийтэд үнэн зөв, бодит нөхцөл байдлыг өгөхөд чиглэн Хянан шалгах түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах сонсголыг 2024 оны 05 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд зохион байгууллаа.

Хянан шалгах түр хорооны 2024 оны “Түр хорооны сонсголыг товлон зарлах тухай” 08 дугаар тогтоол, “Нотлох баримт шинжлэн судлах дараалал тогтоох тухай”

10 дугаар тогтоолоор сонсголыг явуулах дарааллыг тогтоож, нотлох баримтыг шинжлэн судлах сонсголын сэдэв агуулгыг батлан зохион байгуулсан.

Хянан шалгагч, шинжээчдийн бүрэлдэхүүн, ажилласан хугацаа

Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах Түр хорооны хянан шалгагч, шинжээч нар 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрөөс 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийг хүртэл 5 хянан шалгагч, 8 шинжээч, нийт 13 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилогдож ажилласан.

Мөн хянан шалгагч, шинжээчдийн 5 хүний бүрэлдэхүүн бүхий баг Хянан шалгах түр хорооноос баталсан удирдамжийн дагуу 2024 оны 05 дугаар сарын 07-11-ний өдрүүдэд Сэлэнгэ, Дархан-Уул, Төв, Дундговь, Дорноговь болон Говьсүмбэр аймгуудад томилолтоор газар дээр нь ажилласан.

Хяналт шалгалтын цар хүрээ

Улсын Их Хурлын 2024 оны 25 дугаар тогтоолд Хянан шалгах түр хорооны сэдэв, хүрээ хязгаарыг ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох үйл ажиллагаа, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийг бүртгэх үйл ажиллагаа, тусгай зөвшөөрлөөр олгосон газар, түүний хэвлийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэх болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчид төлбөр, татвар ногдуулах, тайлагнах, төлөх, хянах, хураах үйл ажиллагааг шалгах аар заасан.

Шалгагдагч болон хамрагдагч байгууллагуудаас ирүүлсэн зарим мэдээллүүд нь нотлох баримтын шаардлага, иж бүрэн байдал зэргийг бүрэн хангаагүй, цаасан суурьтай материалын архив бүрдүүлэлт, хадгалалтын үйл ажиллагаа хангалтгүй байсан нь шалгалтын явцад илэрсэн төдийгүй нотлох баримтын шаардлага хангуулсан байхаар ирүүлсэн зарим мэдээ, мэдээллүүд, бичиг баримтуудыг хугацаа хоцроож ирүүлсэн зэрэг нь нотлох баримтад суурилан дүн шинжилгээ хийхэд саад болсон, мөн иж бүрэн дүгнэлт өгөх боломжгүй байдалд хүргэж байлаа.

Хянан шалгалтын ажил нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын хууль тогтоомжийн хүрээнд хяналт шалгалтын ажлын зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай **48** байгууллага, 22 аймаг, нийслэлийн Засаг дарга, 4 хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг хамруулсан бөгөөд **7** байгууллагын баримт материал нотлох баримтын шаардлага хангаагүй байна.

Хяналт шалгалтын ажлын хэсэг нь дээрх хугацаанд нийт 11,112 гаруй хуудас баримт материалын хүрээнд хяналт шалгалт хийж, холбогдох асуудлыг нэгтгэн дүгнэсэн.

- Хянан шалгах түр хорооны нотлох баримт гаргуулах тухай тогтоолын хүрээнд 48 байгууллагаас 55 нотлох баримт ирүүлэхээр зааснаас 41 байгууллага нотлох баримтыг ирүүлсэн, 7 байгууллага ирүүлээгүй, 3 байгууллага нотлох баримтыг хугацаа хоцроож ирүүлсэн байна.

НЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын төсвийн орлогын бүрдүүлэлтэд уул уурхайн салбар голлох нөлөө үзүүлдэг бөгөөд 2019-2023 оны байдлаар улсын төсвийн нийт орлогын 30.1 хувийг ашигт малтмал, уул уурхайн салбарын орлого эзэлж байна

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого 2023 оны жилийн эцсийн байдлаар 24,387.1 тэрбум төгрөгт хүрснээс уул уурхай, газрын тосны бүтээгдэхүүний орлого 2023 онд 8,664.8 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд 2019 онтой харьцуулахад 4,709.8 тэрбум төгрөгөөр буюу 2.8 хувиар өссөн байна.

Монгол Улсын төсвийн нийт орлогын гүйцэтгэлд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 2019 онд 11.0 хувийг эзэлж 1,350.1 тэрбум төгрөг төвлөрүүлж байсан бол 2023 онд 17.3 хувийг эзэлж 4,2106.6 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлжээ.

Улсын төсөвт төвлөрүүлсэн татварын нийт орлогын хэмжээ 2023 оны жилийн эцсийн байдлаар 4,746.3 тэрбум төгрөгт хүрсэн ба үүнээс 43.2 хувь буюу 2,051.5 тэрбум төгрөгийн татварын орлогыг уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-үүд төвлөрүүлсэн байна.

Улсын хэмжээнд 2024 оны 4 дүгээр сарын байдлаар хүчин төгөлдөр ашигт малтмалын 2767 тусгай зөвшөөрөл бүртгэлтэй байгаагаас ашиглалтын 1731, хайгуулын 1036 байна. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг ашигт малтмалын төрлөөр авч үзвэл алт 39.9 хувь, нүүрс 21.4 хувь, жонш 12.2 хувь, төмөр 5.3 хувь, гянтболд 2.3 хувь, бусад ашигт малтмал 18.9 хувийг тус тус эзэлж байна.

Монгол Улсын газрын нэгдмэл санд ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлөөр олгогдсон газар 6,930.60 мян.га эзэлж байгаа бөгөөд 2019-2023 онд 336 /давхардсан тоо/ ААН жоншны хүдэр, баяжмал, төмрийн хүдэр, баяжмал, зэсийн хүдэр, баяжмал, цайрын хүдэр, баяжмал, чулуун нүүрс, газрын тос зэрэг нийт 12 нэр төрлийн ашигт малтмалын бүтээгдэхүүнийг экспортод гаргасан байна.

Экспортолсон эрдэс бүтээгдэхүүний нийт үнийн дүнгийн 46 хувийг нүүрс, 33 хувийг зэсийн хүдэр, баяжмал, 6 хувийг боловсруулаагүй нефть, 5 хувийг төмрийн хүдэр, 10 хувийг бусад ашигт малтмал тус тус эзэлж байна.

Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс улс болон орон нутгийн төсөвт 2018 онд төвлөрүүлсэн татварын орлогын хэмжээг 2017 оны мөн үетэй харьцуулахад алт 38.7 хувь, нүүрс 33.7 хувь, төмрийн хүдэр 27.6 хувь, цайр 17.7 хувиар тус тус өссөн байна.

Төсвийн орлого нэмэгдэхэд уул уурхайн салбарын сэргэлт болон түүнийг дагасан тээвэрлэлт, экспортлох үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулж, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тогтолцоог нэвтрүүлсэн нь голлон нөлөөлжээ.

ХОЁР.НОТЛОХ БАРИМТ ИРҮҮЛЭХ ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ

Хянан шалгах түр хорооны 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн “Нотлох баримт ирүүлэх” тухай 06, 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 12 дугаар тогтоолын дагуу холбогдох байгууллагуудаас ирүүлсэн нотлох баримтын иж бүрдэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 1. Нотлох баримтын бүрдүүлбэр

д/д	Нотлох баримт ирүүлэх байгууллага	ХШТХ-ны тогтоолын дагуу (агуулга)	Ирүүлсэн (хуудас)	Тайлбар
1	Монгол Улсын Их Хурлын тамгын газрын тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат	17.1.1994, 1997, 2006 онд батлагдсан Ашигт малтмалын тухай хуулийн хувийн хэрэг; 17.2.2006 онд батлагдсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан дараах хуулиудын хувийн хэрэг.	2024.04.30 ТГ-02/709 Хавсралт DVD-1	Хуулийн хувийн хэрэг, цахим хэлбэрээр. Үүнд: 1. Ашигт малтмалын тухай хууль 1994.09.30 2. Ашигт малтмалын тухай хууль 1997.06.05 3. Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль 2006.07.08 4. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2009.01.08 5. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль 2009.07.16 6. Ашигт малтмалын тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хууль 2009.10.15 7. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2010.07.01 8. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2010.11.25 9. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2014.01.24 10. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2014.07.01 11. Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль 2015.01.23 12. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль 2015.02.18 13. Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль 2015.06.04 14. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2019.03.26 15. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2019.11.22
2	Монгол Улсын ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа	18.1. Ашигт малтмалын тухай хуулийг дагаж гарсан журмууд, түүний өөрчлөлтүүд; 18.2. Ашигт малтмалын тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд гарсан Засгийн газрын тогтоолууд, хуралдааны тэмдэглэлүүд.	2024.05.08 х/492 Хавсралт 7 хуудас	Танаас ирүүлсэн хүсэлтийн дагуу АМ-ын тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд ЗГ-аас гарсан 171 баримтын хуулбарыг баталгаажуулан хавсралтаар хүргүүлж байна. Тухайн асуудлыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцсэн дэлгэрэнгүй тэмдэглэлтэй ЗГ-ын Нууцын архивт биечлэн ирж танилцах боломжтой болохыг мэдэгдье.

				Хавсралт: Баримтын жагсаалт 7 хуудас, 171 баримт 659 хуудас
3	Монгол Улсын Сангийн сайд Б.Жавхлан	<p>4.1.Уул уурхайн бүтээгдэхүүнийг борлуулснаас улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын дүн, тэрбум төгрөгөөр /2007-2024 он тус бүрээр/;</p> <p>4.2.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн ногдуулалт, төлөлт, өрийн үлдэгдэл /Цахим болон цаасан хэлбэрээр, 2007-2024 оноор/;</p> <p>4.3.Эрдэс баялгийн салбарын татварын ногдуулалтын судалгаа /2007-2024 он бүрээр/;</p> <p>4.4.Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-д заасан татвар төлөгчийн татварын өрийн мэдээлэл /2024 оны 01 дүгээр сарын байдлаар/;</p> <p>4.5.Уул уурхайн салбарын татварын ачааллын судалгаа, 2014-2024 он тус бүрээр /уурхай, баяжуулах үйлдвэр, ашигт малтмал экспортлогч хуулийн этгээд/;</p> <p>4.6.Экспортод гаргасан бүх төрлийн ашигт малтмалын бүтээгдэхүүний тоо хэмжээ, мянган тонноор /2007-2023 он, аж ахуйн нэгж, ашигт малтмалын төрлөөр, дэлгэрэнгүй/;</p> <p>4.7.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь, борлуулалтын үнэлгээг тооцох аргачлал, үндэслэл, холбогдох байгууллагаас хийсэн судалгаа;</p> <p>4.8.Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн эрх шилжүүлэхтэй холбоотой татварын тооцоолол, ногдуулалт, төлөлт, өр төлбөр, тоо хэмжээ, санал, гомдол, түүний шийдвэрлэсэн байдал /2019-2024 он тус бүрээр/;</p> <p>4.9.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөртэй холбоотой гомдол, түүнийг шийдвэрлэсэн байдал /2007-2024 он тус бүрээр/;</p> <p>4.10.Үндэсний аудитын газраас 2023 онд “Уул уурхайн салбарын төсвийн орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэл”-ийн байдалд хийсэн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний явцын тайлан, мэдээлэл;</p> <p>4.11.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөртэй холбоотой татварын хяналт шалгалт хийж нөхөн ногдуулсан татвар, алданги, торгуулийн талаарх дэлгэрэнгүй судалгаа, холбогдох мэдээлэл;</p> <p>4.12.Дагалдах ашигт малтмалд ногдуулж буй ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн талаарх судалгаа, мэдээлэл /2007-2024 оноор/.</p>	2024.05.02 01/3410 Хавсралт 13 хуудас	<p>1-р хавсралт:</p> <ol style="list-style-type: none"> Уул уурхайн салбараас улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн нийт орлого. АМНАТ-ийн өрийн үлдэгдэл Эрдэс баялгийн салбарын татварын ногдуулалтын судалгаа \2007-2024 оноор\ Уул уурхайн салбарын татварын ачааллын судалгаа Экспортод гаргасан бүх төрлийн АМ-ын бүтээгдэхүүний тоо, хэмжээ АМНАТ-ийн хувь, борлуулалтын үнэлгээг тооцох аргачлал, үндэслэл АМ-ын тусгай зөвшөөрлийн эрх шилжүүлэхтэй холбоотой татварын тооцоолол, ногдуулалт, төлөлт, өр төлбөр, тоо хэмжээ, санал, гомдол, түүний шийдвэрлэсэн байдал ТЕГ-ын АМНАТ-тэй холбоотой гомдол, түүнийг шийдвэрлэсэн байдал Үндэсний аудитын газраас 2023 онд “Уул уурхайн салбарын төсвийн орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэл”-ийн байдалд хийсэн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний явцын тайлан, мэдээлэл АМНАТ-тэй холбоотой татварын хяналт шалгалт хийж нөхөн ногдуулсан татвар, алданги, торгуулийн талаарх дэлгэрэнгүй судалгаа, холбогдох мэдээлэл АМ-д ногдуулж буй АМНАТ-ийн талаарх мэдээлэл \7 хуудас\ <p>Хавсралт 2: АМ-тай холбоотой үйл ажиллагаа явуулсан ААН-үүдийн төлсөн татварын борлуулалтын орлогод эзлэх хэмжээ, \Хүснэгт 1.АМТЗ-тэй эсэх ангиллаар, Хүснэгт 2.АМ баяжуулах үйлдвэртэй эсэх ангиллаар, Хүснэгт 3. Экспорт хийсэн эсэх ангиллаар, Хүснэгт 4. 1-3-р хүснэгтийг нэгтгэсэн ангиллаар\ \2 хуудас\</p> <p>Хавсралт 3: “Татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөө”, “Уул уурхайн салбарын төсвийн орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэл”, “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт” гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө \4 хуудас\</p>
4	Монгол Улсын Сангийн сайд Б.Жавхлан	<p>4.13.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлангийн ирц /2019-2023 он/;</p> <p>4.14.Жонш олборлох тусгай зөвшөөрөл эзэмшигч болон жонш экспортлогчдын тайлангийн дэлгэрэнгүй мэдээлэл /2019-2023 он/;</p>	2024.05.28 01/4343 Хавсралт 2 хуудас	Албан бичигт дурдсан асуудлын хүрээнд мэдээллийг бэлтгэн хавсралтаар хүргүүлж байна.
5	Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Чимидсүрэн		2024.05.03 01/1126 Хавсралт 455 хуудас	<p>... дараах баримт материалуудыг бэлтгэн хүргүүлж байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> ТЕГ-ын дэргэдэх Татварын маргаан таслах зөвлөлийн гишүүдийн нэрс, тушаалууд \8 хуудас\. АМНАТ төлөгчидтэй холбоотой Татварын маргаан таслах зөвлөлийн тогтоол, судалгаа \446 хуудас\.

		4.15.Жонш экспортолсон боловч тайлагнаагүй аж ахуйн нэгжүүдийн АМНАТ-ийн ногдлын тооцооллын дэлгэрэнгүй судалгаа /2019-2023 он/;		3. АМ-ын эцсийн бүтээгдэхүүн экспортолсон хуулийн этгээдүүдийн нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын судалгаа \1 хуудас\.
6	Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн	4.16.Татварын ерөнхий газрын Маргаан таслах зөвлөлийн гишүүдийн нэрс, анкет болон АМНАТ-тэй холбоотой маргааны шийдвэрүүд, түүнтэй холбоотой бусад материал (2019-2023 оны байдлаар); 4.17.Ашигт малтмалын эцсийн бүтээгдэхүүн экспортолсон хуулийн этгээдийн НӨАТ-ын буцаан олголтын дэлгэрэнгүй судалгаа; 4.18.Татварын ерөнхий газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлөөр 2019-2023 онд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөртэй холбоотой асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн талаарх судалгаа, мэдээлэл, холбогдох баримтууд;	2024.05.22 01/1256 Хавсралт CD 2ш	... Хянан шалгах нэр бүхий 3 шинжээч ТЕГ-т 2024.05.14-ний өдөр ажилласан. ... дараах тайлан, мэдээлэл, судалгааг хүргүүлж байна. Үүнд: 1. АМНАТ-ийн тайлангийн ирц 2019-2023 он 2. Жонш олборлох тусгай зөвшөөрөл эзэмшигч болон жонш экспортлогчдын тайлангийн дэлгэрэнгүй мэдээлэл 2019-2023 он 3. Жонш экспортолсон боловч тайлагнаагүй ААН-үүдийн АМНАТ-ын ногдлын дэлгэрэнгүй судалгаа 2019-2023
7	Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн	4.19.Ашигт малтмалын бүтээгдэхүүний 2018-2023 оны экспортын гаалийн мэдээ /татвар төлөгч, ашигт малтмалын бүтээгдэхүүний ангилалаар/; 4.20.Үндэсний аудитын газраас 2023 онд “Уул уурхайн салбарын төсвийн орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэл”, 2019 онд “Монгол Улсын алт олборлох салбарын өнөөгийн байдал, алтны нөөцийн бүрдүүлэлт, үр дүн”-д хийсэн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын биелэлтийн дэлгэрэнгүй мэдээлэл; 4.21.Монголын жонш олборлогч, үйлдвэрлэгч, экспортлогчдын холбооноос гаргасан гомдол, шийдвэрлэлтийн мэдээлэл; 4.22.“МоЭнко” ХХК-ийн татварын маргаантай асуудлын талаарх мэдээлэл, шийдвэрлэлтийн явцын талаар; 4.23.Татварын албанаас Мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтарч жонш олборлогч аж ахуйн нэгжийн 2019-2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын тайлан, шалгалтаар илэрсэн зөрчлийн шийдвэрлэлтийн талаарх мэдээлэл; 4.24.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулалт, төлөлттэй холбоотой асуудлыг хууль хяналтын байгууллагаар шалгуулахаар илгээсэн албан бичгүүд, тэдгээрийн хариу албан бичгийн хуулбарууд; 4.25.Тусгай шалгалтын сэдэвтэй холбоотой нотлох баримтаар гаргуулахад шаардагдах бусад мэдээлэл; 4.26.Аж ахуйн нэгжүүдийн 2019-2023 оны санхүүгийн тайлан;	2024.05.22 01/1255 Хавсралт 54 хуудас	1. ТЕГ-ын Маргаан таслах зөвлөлөөр 2019-2023 онд АМНАТ-тэй холбоотой асуудлыг шүүхийн шатанд хэрхэн шийдвэрлэсэн судалгаа, мэдээллийг файлаар (мэргэжилтэн Болормаад), холбогдох шүүхийн танилцуулга-2 х. 2. АМ-ын бүтээгдэхүүний 2018-2023 оны экспортын гаалийн мэдээ-12 х. 3. Үндэсний аудитын газраас 2023 оны “Уул уурхайн салбарын төсвийн орлого бүрдүүлэлт, гүйцэтгэл, 2019 онд “Монгол Улсын алт олборлох салбарын өнөөгийн байдал, алтны нөөцийн бүрдүүлэлт, үр дүн”-д хийсэн аудитын зөвлөмж, албан шаардлагын биелэлт-12 х. 4. Монголын жонш олборлогч, үйлдвэрлэгч экспортлогчдын холбооноос гаргасан хүсэлт, гомдол түүний шийдвэрлэлт - 3 х. 5. Мо-Энко ХХК-ийн татварын маргаантай асуудал, шийдвэрлэлт – тайлбар 1 х. 6. Татварын албанаас Мэргэж. Хяналтын байгууллагатай хамтарч жонш олборлогч ААН-ийн 2019-2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын тайлан, судалгаа – 2 х. 7. АМНАТ ногдуулалт, төлөлттэй холбоотой асуудлыг хууль, хяналтын байгууллагаар шалгуулахаар илгээсэн албан бичиг, тэдгээрийн хуулбар – 21 х (мэргэжилтэн Болормаад) 8. Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн 2023 оны татвар төлөлт, өрийн үлдэгдлийн мэдээлэл – 2 х.
8	Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд Б.Уянга	1.1.Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын хэрэгжилтийн тайлан, мэдээлэл /Тогтоолын заалт бүрээр, 2024 оны эхний улирлын байдлаар/; 1.2.Стратегийн ордуудын төрийн эзэмшлийн хувь хэмжээ, хил	2024.05.03 02/1025 Хавсралт 30 хуудас	1. УИХ-ын 2007 оны 27 дугаар тогтоолын хэрэгжилтийн тайлан, мэдээлэл (Тогтоолын заалт бүрээр, 2024 оны эхний улирлын байдлаар) 2. Стратегийн ордуудын төрийн эзэмшлийн хувь хэмжээ, хил заагийг

		заагийг хуулийн дагуу бүрэн тогтоож, баталгаажуулсан эсэх талаарх тайлан, мэдээлэл; 1.3.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөртэй холбоотой гомдол, түүнийг шийдвэрлэсэн байдал /2007-2024 он хүртэлх/; 1.4.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх шилжүүлэх татварын тооцоолол, түүнтэй холбоотой тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс ирүүлсэн санал, гомдол, шийдвэрлэлтийн байдал. 1.5.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмууд (2014–2024); 1.6.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах үүрэг бүхий сонгон шалгаруулалтын комиссын бүрэлдэхүүнийг томилсон тушаал шийдвэрүүд, бүрэлдэхүүнд ажилласан албан хаагчдын албан тушаалд томилогдсон шийдвэрүүд (2014-2024); 1.7.2022 оноос хойш ашигт малтмалын тусгай зөвшөөрөл авахаар хамгийн өндөр үнийн санал ирүүлсэн боловч уг зөвшөөрлийг зохих ёсоор аваагүй хуулийн этгээдийн нэрс, тэдгээрийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;		хуулийн дагуу бүрэн тогтоож, баталгаажуулсан эсэх талаарх тайлан, мэдээлэл
9	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар		2024.05.16 01/1118 Хавсралт 7 хуудас	Ховд аймгийн Дарви сумын нутагт орших “Хөшөөт”-ийн нүүрсний ордод үйл ажиллагаа явуулж байгаа “МоЭнКо” ХХК-ийн холбогдох мэдээллийг АМГТГ-аас гаргаж ирүүлснийг хавсралтаар хүргүүлж байгааг хүлээн авч танилцана уу. Мөн “МоЭнКо” ХХК-ийн олон улсын бирж дээр босгосон хөрөнгийн мэдээлэл болон МУ-д орж ирсэн хөрөнгийн мэдээлэл тус яаманд байхгүй байна.
10	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар		2024.05.16 01/1123 Хавсралт 111 хуудас	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмууд, АМ-ын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, үнэлгээ өгч дүгнэлт гаргах эрх үүрэг бүхий сонгон шалгаруулалтын комиссын гишүүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл болон бүрэлдэхүүнийг томилсон тушаал шийдвэрүүдийг нотлох баримтын шаардлага хангуулан хавсралтаар хүргүүлж байна.
11	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ	7.1.Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд эвдэгдсэн газрын тооллого, нөхөн сэргээлтийн мэдээлэл, танилцуулга /2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар/; 7.2.Тусгай хамгаалалттай газар, тусгай хэрэгцээний газруудын нөхцөл байдал, нөхөн сэргээлтийн талаарх дэлгэрэнгүй танилцуулга; 7.3.Хүчин төгөлдөр ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлүүд нь хориглосон, хязгаарласан газруудтай (Улс болон орон нутгийн тусгай хамгаалалт, тусгай хэрэгцээний газар, Нөөцөд авсан талбай, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газар гэх мэт) давхцалтай эсэх, түүний судалгаа, давхцалтай бол үйл ажиллагаа явуулж буй эсэх дэлгэрэнгүй мэдээлэл.	2024.05.10 01/2240 Хавсралт 38 хуудас	1. “Нөхөн сэргээлт-2024” нэгдсэн арга хэмжээний хүрээнд хийгдсэн нөхөн сэргээлтийн мэдээ (2020, 2021, 2022, 2023 онуудаар) \2 хуудас\ 2. УТХГН-тай давхцалтай тусгай зөвшөөрлийн жагсаалт \4 хуудас\ 3. Гол мөрний урсац бүрэлдэх эхтэй давхцалтай тусгай зөвшөөрлийн жагсаалт \4 хуудас\ 4. Ойн сан бүхий газартай давхцалтай АМ-ын ТЗ-ийн жагсаалт \12 хуудас\ 5. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүстэй давхцалтай АМ-ын ТЗ \13 х\ 6. Хориглосон, хязгаарласан газруудтай давхцалтай хүчин төгөлдөр хүчин төгөлдөр АМ-ын хайгуулын болон ашиглалтын ТЗ-үүдийн мэдээлэл \2 х\
12	Соёлын дэд сайд П.Баттөр	12.1.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан, хамгаалалтын зэрэглэл, хамгаалалтын бүс, байршил, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайтай давхцсан зөрчлийн талаарх мэдээлэл; 12.2.Ашигт малтмалын тухай хуулийн 40 ¹ , 40 ² дугаар зүйлд заасны дагуу соёлын өвийг хамгаалах үүргээ хэрэгжүүлж ажилласан тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл, хамтран хэрэгжүүлсэн	2024.05.14 2/1348 Хавсралт ... хуудас	... холбогдох мэдээллийг бэлтгэж хавсралтаар хүргүүлж байна. 41 хуудас хавсралт

		үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээ, мэдээлэл.		
13	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг	9.1.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөртэй холбоотой шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн хэрэг, маргааны судалгаа /2007-2024 он тус бүрээр/; 9.2.Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлохтой холбоотой шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн хэрэг, маргааны талаарх мэдээлэл, судалгаа /2007-2024 он тус бүрээр/; 9.3.Шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой хэрэг, маргааны судалгаа /2007-2024 он тус бүрээр/.	2024.05.03 01/860 Хавсралт 126 хуудас	1-р хавсралт: Монгол Улсын шүүхээс 2014-2023 оны байдлаар /2002 оны/ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 214 дүгээр зүйл, \2015 оны\ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.2 дугаар зүйлд заасан “Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох”-той холбоотой эрүүгийн шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн хэргийн тоон судалгаа \2 хуудас\ 2-р хавсралт: Монгол Улсын шүүхээс 2014-2024.4.23-ны өдрийн байдлаар Ашигт малтмал, газрын тосны газрыг хариуцагчаар татсан хэргийн судалгаа \124 хуудас\
14	Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дарга бөгөөд ХЗДХ-ийн сайд Б.Энхбаяр	15.1.Геологи, уул, уурхайн салбарт үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл, гэмт хэрэг, зөрчил гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажил, арга хэмжээний талаарх мэдээлэл, танилцуулга.	2024.05.02 01/184 Хавсралт 8 хуудас	“Геологи, уул уурхайн салбарт үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажил, арга хэмжээний мэдээлэл, танилцуулга”-ыг хавсралтаар хүргүүлж байна. Хүлээн авч танилцана уу.
15	Цагдаагийн ерөнхий газрын дарга Т.Сүхболд	8.1.Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд эвдэгдсэн газрын тооллого, нөхөн сэргээлтийн мэдээлэл, танилцуулга /2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар/; 8.2.Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, байгаль орчны нөхөн сэргээлттэй холбоотой гэмт хэрэг, зөрчил, авсан арга хэмжээ, дэлгэрэнгүй танилцуулга /2014-2024 он тус бүрээр/.	2024.05.03 01/353 Хавсралт 3 хуудас	Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд эвдэгдсэн газрын тооллого, нөхөн сэргээлтийн талаарх, хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, байгаль орчны нөхөн сэргээлттэй холбоотой гэмт хэрэг, зөрчил, авсан арга хэмжээний дэлгэрэнгүй танилцуулгыг тус тус гаргаж, хавсралтаар хүргүүлэв. \3 хуудас\
16	Цагдаагийн ерөнхий газрын дарга Т.Сүхболд	8.3.Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг зориулалтын бусаар ашигласан гэмт хэргийг шалган, шийдвэрлэсэн байдал, түүнтэй холбоотой баримт; 8.4.Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд олборлолт явуулсан гэмт хэргийг шалгаж, шийдвэрлэсэн байдал, түүнтэй холбоотой баримт; 8.5.Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлд заасан Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэргийг шалган, шийдвэрлэсэн байдал, түүнтэй холбоотой баримт;	2024.05.21 01/414 Хавсралт 5 хуудас	МУ-ын хэмжээнд 2014-2024 оны эхний 04 сарын байдлаар бүртгэгдсэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.2 дугаар зүйлд заасан хууль бусаар АМ хайх, ашиглах, олборлох гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан болон шийдвэрлэсэн талаарх судалгаа мэдээллийг нэгтгэж хүргүүлэв.
17	Үндэсний геологийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнхтөр	2.1.Ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн ордын нөөцийн хөдөлгөөн, балансын талаарх нэгдсэн мэдээлэл, тусгай зөвшөөрөл бүрээр /2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар, цахим болон цаасан хэлбэрээр/ 2.2.Сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоор батлагдсан талбайгаас тухайлсан сонгон шалгаруулалтад ямар журмаар харьяалагдах талбайг сонгож оруулдаг талаарх мэдээлэл;	2024.05.10 1/299 Хавсралт 184 хуудас	Хавсралт 1: Ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн ордуудын ашигт малтмалын төрөл болон нөөц бүртгэгдсэн тоо, хэмжээ \3 х\ Хавсралт 2: Металл ашигт малтмал (ордуудын нөөц) Хавсралт 3: Металл бус ашигт малтмал (ордуудын нөөц) Хавсралт 4: Шатах ашигт малтмал (ордуудын нөөц) Хавсралт 5: Түгээмэл тархацтай ашигт малтмал (ордуудын нөөц)
18	Монголбанк	23.1.Монголбанканд үнэт металл тушаасан хуулийн этгээдийн дэлгэрэнгүй мэдээлэл;	Хариу ирүүлэг үй	

		23.2.Монголбанкнд үнэт металл тушаасан иргэний дэлгэрэнгүй мэдээлэл;		
19	Стандарт, хэмжил зүйн газрын дарга С.Батбаатар	25.1.Үнэт металлын сорьц хийлгэсэн иргэн, хуулийн этгээдийн дэлгэрэнгүй мэдээлэл;	2024.05.28 н/01-09 Хавсралт 18 хуудас	Стандарт, хэмжил зүйн газрын Сорьцын хяналтын газрын Үнэт металлын сорьц тогтоох лабораторид 2018.01.01 - 2024.04.30-ны өдрийн хооронд сорьц тогтоолгосон үнэт металл олборлогч иргэн, хуулийн этгээдийн дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.
20	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа Б.Нандинболор	10.1.Геологи, уул, уурхай салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид холбогдох Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэсэн талаарх мэдээлэл, танилцуулгыг 2007-2024 он.	2024.05.02 01/1132 Хавсралт 3 хуудас	2007-2024 оны хооронд геологи, уул уурхай салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжид холбогдох захиргааны хэргийн шүүхийн шийдвэртэй гүйцэтгэх баримт бичгийн судалгаа 138 жагсаалт бүхий 3 хуудас\
21	Улсын бүртгэлийн ерөнхий газрын Улсын бүртгэлийн нэгдсэн архивын газрын дарга С.Оюунгэрэл	5.1.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч бүх хуулийн этгээд, тэдгээрийн хамаарал бүхий иргэн, хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа; 5.2.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн өөрчлөлтийг холбогдох татварыг төлсөн тухай татварын тодорхойлолтгүй бүртгэсэн бүртгэлийн мэдээ, судалгаа /аж ахуйн нэгжээр/; 5.3.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн эрх шилжүүлэхтэй холбоотой татвар ногдуулалт, төлөлт, тоо хэмжээ, холбогдох мэдээлэл /2019-2024 он тус бүрээр/; 5.4.Үндэсний аудитын газраас 2023 онд “Уул уурхайн салбарын төсвийн орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэл”-ийн байдалд хийсэн аудитаар өгсөн албан шаардлагын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний явцын тайлан, мэдээлэл. 5.5.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувийн хэрэг; 5.6.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч өөрчлөгдсөн бүртгэл;	2024.05.02 а/5855 Хавсралт 3225 хуудас	Албан бичгийн дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа, эцсийн өмчлөгчийн өөрчлөлтийг бүртгэхэд төлсөн татвар төлсөн талаарх судалгаа, Үндэсний аудитын газрын албан шаардлагын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хавсралтаар хүргүүлж байна. Хавсралт 3225 хуудастай.
22	Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Загджав	11.1.“Уул уурхайн салбарын төсвийн орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэл”-ийн байдалд 2023 онд хийсэн аудитын тайлан, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн талаарх нотлох баримтууд.	2024.05.02 1203 \39 хуудас\	УИХ-ын 2024.04.12-ны өдрийн 25 дугаар тогтоолоор байгуулагдсан “Ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, төлбөр, татвар ногдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх” үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны үйл ажиллагаанд шаардлагатай Үндэсний аудитын газраас 2023 онд гүйцэтгэсэн “Уул уурхайн салбарын төсвийн орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэл”-ийн байдалд хийсэн аудитын тайлан, аудитаар ирүүлсэн алдаа, зөрчилтэй холбоотой 39 хуудас баримтыг нотлох баримтын шаардлага хангуулан бэлтгэн цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлж байна. Хавсралт: Гүйцэтгэлийн аудитын тайлан

23	Гаалийн ерөнхий газрын дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Энхтайван	3.1.Экспортод гаргасан бүх төрлийн ашигт малтмалын бүтээгдэхүүний тоо хэмжээ, мянган тонноор /2007-2023 он, аж ахуйн нэгж, ашигт малтмалын төрлөөр, дэлгэрэнгүй хэлбэрээр/; 3.2.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгчийн судалгаа, гаалийн хяналт, бүрдүүлэлт, гэрээ бүртгэлийн нэгдсэн системийн судалгаа, дагалдах ашигт малтмалд ашигт малтмалын нөөц ашигласан төлбөр тооцдог аргачлалын талаарх мэдээлэл	2024.05.02 02/1750 Хавсралт 64 хуудас	Гаалийн мэдээллийн сангаас 2007-2023 онуудад хилээр гаргасан ашигт малтмалын бүтээгдэхүүний нэг төрөл, тоо хэмжээг экспортлогч нэг бүрээр Гаалийн ерөнхий газрын Статистик, дүн шинжилгээний хэлтсээр гаргуулан, хавсралтаар хүргүүлж байна. Хавсралт 64 нүүр
24	Ашигт малтмал, газрын тосны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Баярмандал	6.1.Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасан тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нутгийн захиргааны байгууллага хооронд байгуулсан гэрээ, түүний хэрэгжилтийн талаарх судалгаа, мэдээлэл; 6.2.Дагалдах ашигт малтмалд ногдуулж буй ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн талаарх судалгаа, мэдээлэл /2007-2024 оны эхний улирлын байдлаар/; 6.3.Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн эрх шилжүүлэхтэй холбоотой мэдээлэл /2019-2024 он тус бүрээр/; 6.4.Хүчин төгөлдөр ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөний талаарх мэдээлэл; 6.5.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтын хууль, эрх зүйн актын талаарх дэлгэрэнгүй танилцуулга; 6.6.Хүчин төгөлдөр ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн дэлгэрэнгүй жагсаалт, мэдээлэл, судалгаа; 6.7.Сонгон шалгаруулалтаар олгогдсон ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн танилцуулга, дэлгэрэнгүй мэдээлэл /он тус бүрээр/; 6.8.Хүчин төгөлдөр ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлүүд нь хориглосон, хязгаарласан газруудтай (Улс болон орон нутгийн тусгай хамгаалалттай, тусгай хэрэгцээний газар, Нөөцөд авсан талбай, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газар гэх мэт) давхцалтай эсэх, түүний судалгаа, давхцалтай бол үйл ажиллагаа явуулж буй эсэх дэлгэрэнгүй мэдээлэл; 6.9.Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан стратегийн ордуудад олгогдсон ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн дэлгэрэнгүй мэдээлэл, танилцуулга жагсаалт (шилжилт хөдөлгөөн), тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хамаарлын судалгаа; 6.10.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон түгээмэл тархацтай	2024.05.02 1/2003 Хавсралт 1 CD	Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.22 дахь заалтыг үндэслэн албан бичигт дурдсан мэдээллийг бэлтгэсэн бөгөөд цахим хэлбэрээр хавсралтаар хүргүүлж байна. Хүлээн авч танилцана уу. Хавсралт CD 1 ширхэг.
25	Ашигт малтмал, газрын тосны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Баярмандал	... дараах хариуг хүргүүлж байна. 1. ... хуулиар олгосон чиг үүргийн дагуу ТЗ олгох сонгон шалгаруулалтыг зохион явуулдаг. 2. ... хугацаанд төлөхгүй талбайн сонгон шалгаруулалтыг хүчингүй болгосон байна. Дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргав. (Хавсралт 1) 3. ... Сонгон шалгаруулалтад шалгарч шалгарч хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшсэн аж ахуйн нэгжийн мэдээллийг хавсаргав. (Хавсралт 2) 4. ... тусгай зөвшөөрөл олгох ЗГ-ын тогтоолуудын хэрэгжилтийг хангаж хайгуулын ТЗ-ийг олгосон. (Хавсралт 3) Хавсралт №1: Цахим сонгон шалгаруулалтад шалгарсан ч үнийн саналын зөрүүг төлөөгүй ААН-ийн жагсаалт \68 ААН, 3х\ Хавсралт №2: Сонгон шалгаруулалтаар олгогдсон хайгуулын ТЗ-ийн жагсаалт \659 ААН, 29 х\ Хавсралт №3: \37 ТЗ, 3 х\ гарчиггүй	2024.05.14 1/2170 Хавсралт 35 хуудас	... дараах хариуг хүргүүлж байна. 1. ... хуулиар олгосон чиг үүргийн дагуу ТЗ олгох сонгон шалгаруулалтыг зохион явуулдаг. 2. ... хугацаанд төлөхгүй талбайн сонгон шалгаруулалтыг хүчингүй болгосон байна. Дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргав. (Хавсралт 1) 3. ... Сонгон шалгаруулалтад шалгарч шалгарч хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшсэн аж ахуйн нэгжийн мэдээллийг хавсаргав. (Хавсралт 2) 4. ... тусгай зөвшөөрөл олгох ЗГ-ын тогтоолуудын хэрэгжилтийг хангаж хайгуулын ТЗ-ийг олгосон. (Хавсралт 3) Хавсралт №1: Цахим сонгон шалгаруулалтад шалгарсан ч үнийн саналын зөрүүг төлөөгүй ААН-ийн жагсаалт \68 ААН, 3х\ Хавсралт №2: Сонгон шалгаруулалтаар олгогдсон хайгуулын ТЗ-ийн жагсаалт \659 ААН, 29 х\ Хавсралт №3: \37 ТЗ, 3 х\ гарчиггүй

		<p>ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн мэдээлэл, судалгаа, танилцуулга;</p> <p>6.11.Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.6.3-д заасан уулын ажлын тайлангаар ирүүлсэн экспортод гаргасан ашигт малтмалын дэлгэрэнгүй мэдээ, мэдээлэл /2019-2023 он бүрээр, аж ахуй нэгжээр/;</p> <p>6.12.Тав болон түүнээс дээш ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшиж буй аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн дэлгэрэнгүй танилцуулга (анх олгосон нөхцөл байдал, олгосон шийдвэр, тусгай зөвшөөрлийн хуулбар), тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хамаарлын судалгаа;</p> <p>6.13.Хайгуулын тусгай зөвшөөрлийг 12 жил, түүнээс дээш хугацаагаар сунгагдсан эсэх судалгаа, танилцуулга;</p> <p>6.14.Соёлын өвийн бүртгэлтэй газар, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан зөрчлийн талаарх мэдээлэл, судалгаа;</p> <p>6.15.Бичил уурхайн дүгнэлт гаргасан талбайн мэдээлэл, талбайн ашиглалтын мэдээлэл, судалгаа.</p>		
26	Ашигт малтмал, газрын тосны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Баярмандал	<p>6.16.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн батлуулсан уулын ажлын төлөвлөгөө, ирүүлсэн уулын ажлын тайлангийн мэдээг 2009-2023 оны байдлаар аж ахуйн нэгжээр;</p> <p>6.17.Хүчин төгөлдөр ашиглалтын тусгай зөвшөөрөл тус бүрээр тайлбар, мэдээлэл (Нөөц,ТЭЗҮ-тэй эсэх, үйл ажиллагаа явуулж байгаа эсэх, үгүй бол шалтгаан);</p> <p>6.18.Говь-Алтай аймгийн Сутай хайрхан ууланд түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрлийн талбайн дүгнэлт гаргасан талаарх мэдээлэл;</p> <p>6.19.Сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоор батлагдсан талбайгаас тухайлсан сонгон шалгаруулалтад ямар журмаар харьяалагдах талбайг сонгож оруулдаг талаарх мэдээлэл;</p> <p>6.20.Сонгон шалгаруулалтаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл авахаар шалгарсан болон шалгараад үнийн санал өгөөгүй хуулийн этгээдийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;</p> <p>6.21.Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг зохион байгуулах комиссын үнэлгээний хуудас болон дүгнэлт гаргахад үйлдэгддэг баримт бичгүүдийг сонгон шалгаруулалтаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл авахаар шалгарсан аж ахуйн нэгжийн нэрс;</p>	2024.05.21 1/2268 Хавсралт т 285 хуудас	1. Хянан шалгах түр хорооны хянан шалгагч, шинжээч нарын бүрэлдэхүүн 2024.05.15-20-ны өдрүүдэд тус газарт ажиллалаа. Шалгалтын хүрээнд шаардлагатай мэдээлэл, бичиг баримтаар шуурхай хангаж ажилласан бөгөөд холбогдох баримтуудыг нотлох баримтын шаардлага хангуулан хавсралтаар хүргүүлж байна.
27	Ашигт малтмал, газрын тосны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Баярмандал	<p>6.19.Сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоор батлагдсан талбайгаас тухайлсан сонгон шалгаруулалтад ямар журмаар харьяалагдах талбайг сонгож оруулдаг талаарх мэдээлэл;</p> <p>6.20.Сонгон шалгаруулалтаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл авахаар шалгарсан болон шалгараад үнийн санал өгөөгүй хуулийн этгээдийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;</p> <p>6.21.Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг зохион байгуулах комиссын үнэлгээний хуудас болон дүгнэлт гаргахад үйлдэгддэг баримт бичгүүдийг сонгон шалгаруулалтаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл авахаар шалгарсан аж ахуйн нэгжийн нэрс;</p>	2024.05.29 1/2401 Хавсралт т 26 хуудас	<p>1. Эрдэнэ Монгол ХХК, Сэкер ресурс Монголиа ХХК-ийн эзэмшиж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдийн нөөцийн мэдээллийг нотлох баримтын шаардлага хангуулан хүргүүлж байна.</p> <p>2. Усны тухай хууль 2012.05.17-ны өдөр батлагдаж, хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш Кадастрын мэдээллийн сад бүртгэлтэй өргөдлөөр болон сонгон шалгаруулалтын журмаар олгогдсон</p>

		6.22.Сонгон шалгаруулалтгүйгээр олгогдсон ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн дэлгэрэнгүй мэдээлэл; 6.23.Тусгай зөвшөөрлийн хувийн хэрэг; 6.24.Сонгон шалгаруулалтын баримт; 6.25.Түгээмэл тархацтай ашигт малтмалын талбайн дүгнэлт гаргах үйл явцтай хамаарах баримт материалууд;		
28	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай	13.1.Тусгай зөвшөөрлийн талбайтай давхцалтай өмчилсөн болон тусгай хамгаалалттай газрын бүртгэл мэдээлэл; 13.2.Тусгай хамгаалалттай газрын бүртгэл мэдээллийн сангийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл; 13.3.Хүчин төгөлдөр ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлүүд нь хориглосон, хязгаарласан газруудтай (Улс болон орон нутгийн тусгай хамгаалалт, тусгай хэрэгцээний газар, Нөөцөд авсан талбай, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газар гэх мэт) давхцалтай эсэх, түүний судалгаа, давхцалтай бол үйл ажиллагаа явуулж буй эсэх дэлгэрэнгүй мэдээлэл; 13.4.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан, хамгаалалтын зэрэглэл, хамгаалалтын бүс, байршил, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайтай давхцсан зөрчлийн талаарх мэдээлэл; 13.5.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн судалгаа /аймаг тус бүрээр, зурган мэдээллийн хамт/.	2024.05.10 1/1207 Хавсралт ... хуудас \ 33\	1. Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй газартай давхцалтай газрын мэдээлэл 2. МУ-ын иргэнд өмчлүүлсэн газрын мэдээлэлтэй давхцуулсан байдал 3. Тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээлэлтэй давхцуулсан байдал 4. Ойн сан бүхий газартай давхцуулсан байдал 5. Усны сан бүхий газартай давхцуулсан байдал 6. Соёлын өвийн мэдээлэлтэй давхцуулсан байдал
29	Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын гүйцэтгэх захирал Т.Дүүрэн		2024.05.21 02/490 Хавсралт 98 хуудас	Шинжээчийн шаардлагын дагуу нотлох баримтаар олгосон мэдээлэл, холбогдох баримтыг Хавсралтаар хүргүүлэв. ... нэр бүхий 108 ААН-д 2021-2023 онд гарал үүслийн гэрчилгээ олгосон эсэх тухай баримтыг архиваас шүүж, нотлох баримтын шаардлага хангасан хэлбэрээр гаргаж өгөхөд боломжит богино хугацаа нь ажлын 10 хоног байх тул уг хугацаанд дурдсан мэдээллийг гаргаж өгөхийг үүгээр мэдэгдэж байна.
30	Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул	20.1.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зарласан талбайн мэдээлэл, нийт талбайн хэмжээнд тогтоосон үнийн санал, шалгаруулалтад оролцсон аж ахуйн нэгжүүдийн жагсаалт, дэлгэрэнгүй мэдээлэл.	2024.05.10 А-1/1975	МУ-ын ЗГ-ын 2022 оны 429 дүгээр тогтоолоор “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийг “Эрдэнэс Монгол” нэгдлийн бүрэлдэхүүнд ажиллуулах шийдвэр гарсан. Холбогдох баримт материалыг бүрдүүлэн түүгээрээ хүргүүлнэ үү гэж “Эрдэнэс Монгол” ХХК-д хүргүүлсэн албан бичгийн хувийг ирүүлсэн.

31	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл		2024.05.07 А-1/911 Хавсралт 18 хуудас	Худалдан авах ажиллагааны цахим системээр ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зарласан талбайн мэдээлэл, шалгаруулалтад оролцсон аж ахуй нэгжүүдийн мэдээллийг тус тус MS excel /.xlsx/ форматаар гарган дээрх албан бичигт дурдсан ... цахим шуудангаар болон хавсралтаар хүргүүлж байна.
32	Завхан аймгийн ЗД Т.Өнөрбаяр	14.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх 2018-2023 оны мэдээлэл, судалгаа, танилцуулга /сум, дүүрэг тус бүрээр, зурган мэдээллийн хамт/; 14.2.Бичил уурхай эрхлэгчдийн хүний нөөц, ашиглаж буй байдал, нөхөн сэргээлт, ашиглаж буй тоног төхөөрөмжийн мэдээлэл.	2024.05.01 1/420 Хавсралт 3 хуудас	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээлэл 1-р хуудас: 3 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүснэгтэн мэдээлэл 2-р хуудас: Байршлын зураг. 3-р хуудас: Давхаргын таних тэмдэг
33	Өмнөговь аймгийн ЗД Р.Сэддорж	14.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх 2018-2023 оны мэдээлэл, судалгаа, танилцуулга /сум, дүүрэг тус бүрээр, зурган мэдээллийн хамт/; 14.2.Бичил уурхай эрхлэгчдийн хүний нөөц, ашиглаж буй байдал, нөхөн сэргээлт, ашиглаж буй тоног төхөөрөмжийн мэдээлэл.	2024.05.03 01/1265 Хавсралт 147 хуудас	1-р хавсралт: 6 хуудас хүснэгтэн мэдээлэл, Засаг даргын 41 захирамж \121 хуудас\. 2-р хавсралт: Гурвансайхан бичил уурхай эрхлэгчдийн холбооны 23 нөхөрлөлийн 217 гишүүдийн нэрсийн жагсаалт \11 хуудас\. 3-р хавсралт: Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын нутагт 2023 оны 10 сараас 2024 оны 04 дүгээр сарын хооронд ажилласан 4 нөхөрлөлийн нөхөн сэргээлт хийсэн газрыг хүлээн авсан акт болон дүгнэлт \9 хуудас\.
34	Нийслэлийн ЗД Х.Нямбаатар	14.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх 2018-2023 оны мэдээлэл, судалгаа, танилцуулга /сум, дүүрэг тус бүрээр, зурган мэдээллийн хамт/; 14.2.Бичил уурхай эрхлэгчдийн хүний нөөц, ашиглаж буй байдал, нөхөн сэргээлт, ашиглаж буй тоног төхөөрөмжийн мэдээлэл.	2024.05.03 01/2539 Хавсралт 1089 хуудас \1069\	1.Нийслэлийн нутаг дэвсгэрт түгээмэл ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон ТТАМ-ын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх 2018-2023 оны мэдээллийн жагсаалт \5 хуудас\ 2. Нийслэлийн ЗД-ын 2018 оны 9 захирамж \267 хуудас\ 3. Нийслэлийн ЗД-ын 2019 оны 7 захирамж \97 хуудас\ 4. Нийслэлийн ЗД-ын 2020 оны 44 захирамж \395 хуудас\ 5. Нийслэлийн ЗД-ын 2021 оны 9 захирамж \172 хуудас\ 6. Нийслэлийн ЗД-ын 2022 оны 7 захирамж \63 хуудас\ 7. Нийслэлийн ЗД-ын 2023 оны 4 захирамж \70 хуудас\ Түгээмэл тархацтай АМ-ын ашиглалтын тусгай зөвшөөрөл байхгүй болно. 1-р хавсралт: Хүчин төгөлдөр түгээмэл тархацтай АМ-ын хайгуулын тусгай зөвшөөрлийн мэдээлэл \12 ТЗ, 1 хуудас\ 2-р хавсралт: Бичил уурхай эрхлэгчдийн мэдээлэл \1 хуудас\ 3. Жаргалан, Есөнбулаг, Халиун, Алтай, Бигэр, Бугат, Цогт сумд олгогдсон түгээмэл тархацтай АМ-ын хайгуулын ТЗ-ийн зураглал \7 хуудас\ Бугат сумын нутагт “Касек” ХХК “Эко ойлдринг” ХХК, “Нөт бөүл” ХХК-уудад АМГТГ-аас 2019 оны 7/3599 дугаар албан бичгийн дүгнэлтийн дагуу түгээмэл тархацтай АМ-ын хайгуулын ТЗ-ийг 2021 онд олгосон байна.
35	Говь-Алтай аймгийн ЗД Г.Чинбат	14.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх 2018-2023 оны мэдээлэл, судалгаа, танилцуулга /сум, дүүрэг тус бүрээр, зурган мэдээллийн хамт/; 14.2.Бичил уурхай эрхлэгчдийн хүний нөөц, ашиглаж буй байдал, нөхөн сэргээлт, ашиглаж буй тоног төхөөрөмжийн мэдээлэл	2024.05.06 2/609 Хавсралт 9 хуудас	Түгээмэл тархацтай АМ-ын ашиглалтын тусгай зөвшөөрөл байхгүй болно. 1-р хавсралт: Хүчин төгөлдөр түгээмэл тархацтай АМ-ын хайгуулын тусгай зөвшөөрлийн мэдээлэл \12 ТЗ, 1 хуудас\ 2-р хавсралт: Бичил уурхай эрхлэгчдийн мэдээлэл \1 хуудас\ 3. Жаргалан, Есөнбулаг, Халиун, Алтай, Бигэр, Бугат, Цогт сумд олгогдсон түгээмэл тархацтай АМ-ын хайгуулын ТЗ-ийн зураглал \7 хуудас\ Бугат сумын нутагт “Касек” ХХК “Эко ойлдринг” ХХК, “Нөт бөүл” ХХК-уудад АМГТГ-аас 2019 оны 7/3599 дугаар албан бичгийн дүгнэлтийн дагуу түгээмэл тархацтай АМ-ын хайгуулын ТЗ-ийг 2021 онд олгосон байна.
36	Говь-Алтай аймгийн ЗД Г.Чинбат		2024.05.15 2/655 Хавсралт 3 хуудас	Бугат сумын нутагт “Касек” ХХК “Эко ойлдринг” ХХК, “Нөт бөүл” ХХК-уудад АМГТГ-аас 2019 оны 7/3599 дугаар албан бичгийн дүгнэлтийн дагуу түгээмэл тархацтай АМ-ын хайгуулын ТЗ-ийг 2021 онд олгосон байна.

				Дээрх газрууд нь тусгай хамгаалалттай газар нутагт давхцалтай байсан тул 2022 онд аймгийн ЗД-ын А/211дугаар захирамжаар цуцалсан болно.
37	Сэлэнгэ аймгийн ЗД Н.Лхагвадорж	14.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх 2018-2023 оны мэдээлэл, судалгаа, танилцуулга /сум, дүүрэг тус бүрээр, зурган мэдээллийн хамт/ 14.2.Бичил уурхай эрхлэгчдийн хүний нөөц, ашиглаж буй байдал, нөхөн сэргээлт, ашиглаж буй тоног төхөөрөмжийн мэдээлэл	2024.05.08 1/588 Хавсралт 12 хуудас	1-р хавсралт: Сэлэнгэ аймагт Түгээмэл тархацтай АМ-ын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүд \8 ТЗ 1 хуудас\ 2-р хавсралт: Сэлэнгэ аймагт Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүд \45 ТЗ, 5 хуудас\ 3-р хавсралт: Түгээмэл тархацтай АМ-ын хайгуулын тусгай зөвшөөрөлд сунгалт хийсэн ААН \4 ТЗ 1 хуудас\ 4-р хавсралт: Хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан ААН \24 ТЗ 3 хуудас\ 5-р хавсралт: Сэлэнгэ аймагт Бичил уурхайгаар үйл ажиллагаа эрхлэхээр хүсэлт гаргасан нөхөрлөл сумдын судалгаа \5 нөхөрлөл, 2 хуудас\ 1. Түгээмэл тархацтай АМ-ын ТЗ эзэмшигчдийн 2017-2023 оны судалгаа \2 х\ 2. Бичил уурхай эзэмшигчдийн 2017-2022 оны судалгаа \2 х\ 3. АМ ашиглагч ААН-үүдийн 2022 онд орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн албан татвар, хураамжийн орлогын тайлан \28 х\ 4. Сонгон шалгаруулалтын талаарх баримт бичгүүд \11 х\ 5. Түгээмэл тархацтай АМ-ын талаар орон нутагт тулгамдаад байгаа хүндрэлтэй асуудлын тухай \7 х\ Түгээмэл тархацтай АМ-ын тухай хуулийн дагуу олгогдсон түгээмэл тархацтай АМ-ын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх 2018-2023 оны мэдээлэл, судалгаа, танилцуулгыг хүргүүлэв. 1. Баян-Өлгий аймгийн дэвсгэрт хүчин төгөлдөр байгаа түгээмэл тархацтай АМ-ын хайгуул болон ашиглалтын лиценз ашиглалтын 8, хайгуулын 6 ТЗ-ийн жагсаалт \1 хуудас\ 2. АМГТГ-ын веб сайтаас авч хэвлэсэн мэдээлэл \35 хуудас\ 1-р хавсралт: Түгээмэл тархацтай АМ-ын ТЗ эзэмшигч этгээдийн бүртгэл, мэдээлэл (аймаг, нийслэл) \4 ашиглалт, 6 хайгуулын ТЗ эзэмшигчдийн жагсаалт 2 хуудас, Захирамж, солбицол, зураг г.м баримт 26 хуудас\ 2-р хавсралт: Нөхөрлөлүүдийн бүртгэл \6 сумын 41 нөхөрлөлийн жагсаалт 2 хуудас, холбогдох баримт 6 хуудас\ 40 гаруй нөхөрлөлийн 400 орчим иргэд Баян-Овоо сумын нутагт ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Наранмандал интерпрайзес” ХХК-ийн Цагаан цахирын алтны үндсэн ордод гурвалсан гэрээ байгуулан 2000-2023 онд үйл ажиллагаа явуулсан. 1. Баянхонгор аймгийн түгээмэл тархацтай АМ-ын ТЗ олголтын судалгаа \2018-2023\ \3 хуудас\ 14.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх 2018-2023 оны мэдээлэл, судалгаа, танилцуулга /сум, дүүрэг тус бүрээр, зурган мэдээллийн хамт/ 14.2.Бичил уурхай эрхлэгчдийн хүний нөөц, ашиглаж буй байдал, нөхөн сэргээлт, ашиглаж буй тоног төхөөрөмжийн мэдээлэл
38	Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын дарга О.Хүрэлчулуун	14.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх 2018-2023 оны мэдээлэл, судалгаа, танилцуулга /сум, дүүрэг тус бүрээр, зурган мэдээллийн хамт/ 14.2.Бичил уурхай эрхлэгчдийн хүний нөөц, ашиглаж буй байдал, нөхөн сэргээлт, ашиглаж буй тоног төхөөрөмжийн мэдээлэл	2024.05.09 2-10/685 Хавсралт ... хуудас \50\	
39	Баян-Өлгий аймгийн ЗД А.Камелият	14.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх 2018-2023 оны мэдээлэл, судалгаа, танилцуулга /сум, дүүрэг тус бүрээр, зурган мэдээллийн хамт/ 14.2.Бичил уурхай эрхлэгчдийн хүний нөөц, ашиглаж буй байдал, нөхөн сэргээлт, ашиглаж буй тоног төхөөрөмжийн мэдээлэл	2024.05.07 1-01/686 Хавсралт 36 хуудас	
40	Өвөрхангай аймгийн ЗД И.Доржсүрэн	14.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх 2018-2023 оны мэдээлэл, судалгаа, танилцуулга /сум, дүүрэг тус бүрээр, зурган мэдээллийн хамт/ 14.2.Бичил уурхай эрхлэгчдийн хүний нөөц, ашиглаж буй байдал, нөхөн сэргээлт, ашиглаж буй тоног төхөөрөмжийн мэдээлэл	2024.05.03 1/217 Хавсралт 36 хуудас	
41	Баянхонгор аймгийн ЗД Д.Мөнхсайхан	14.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх 2018-2023 оны мэдээлэл, судалгаа, танилцуулга /сум, дүүрэг тус бүрээр, зурган мэдээллийн хамт/ 14.2.Бичил уурхай эрхлэгчдийн хүний нөөц, ашиглаж буй байдал, нөхөн сэргээлт, ашиглаж буй тоног төхөөрөмжийн мэдээлэл	2024.05.13 1а/340 Хавсралт 3 хуудас	

		нөхөн сэргээлт, ашиглаж буй тоног төхөөрөмжийн мэдээлэл		
42	Дундговь аймгийн ЗД Ц.Мөнхбат	14.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх 2018-2023 оны мэдээлэл, судалгаа, танилцуулга /сум, дүүрэг тус бүрээр, зурган мэдээллийн хамт/; 14.2.Бичил уурхай эрхлэгчдийн хүний нөөц, ашиглаж буй байдал, нөхөн сэргээлт, ашиглаж буй тоног төхөөрөмжийн мэдээлэл	2024.05.14 01/668 Хавсралт 764 хуудас	Дундговь аймагт одоогийн байдлаар бичил уурхайн зориулалтаар үйл ажиллагаа явуулж байгаа бичил уурхай эрхлэгч иргэн, нөхөрлөл, болон дүгнэлттэй талбай байхгүй бөгөөд тус аймагт олгогдсон түгээмэл тархацтай АМ-ын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх 2018-2023 оны мэдээлэл, судалгаа, танилцуулга бусад холбогдох материалыг хүргүүлж байна. 1. Дундговь аймагт олгогдсон түгээмэл тархацтай АМ-ын ашиглалтын тусгай зөвшөөрөл: 1 \44 х\ 2. Дундговь аймагт олгогдсон түгээмэл тархацтай цуцлагдсан талбай: 4 \60 х\ 3. Дундговь аймагт олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл: жагсаалт 55 ТЗ
43	Дорноговь аймгийн ЗД-ын орлогч Г.Март	14.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх 2018-2023 оны мэдээлэл, судалгаа, танилцуулга /сум, дүүрэг тус бүрээр, зурган мэдээллийн хамт/; 14.2.Бичил уурхай эрхлэгчдийн хүний нөөц, ашиглаж буй байдал, нөхөн сэргээлт, ашиглаж буй тоног төхөөрөмжийн мэдээлэл	2024.05.20 02/724 Хавсралт 170 хуудас	Хавсралт 1: Түгээмэл тархацтай АМ-ын ашиглалтын ТЗ-ийн бүртгэл \1 хуудас, Хүснэгт 10 ТЗ\, захирамжийн хуулбар Хавсралт 2: Түгээмэл тархацтай АМ-ын хайгуулын ТЗ-ийн бүртгэл \1 хуудас, Хүснэгт 6 ТЗ\, захирамжийн хуулбар Хавсралт 3: Цуцлагдсан түгээмэл тархацтай АМ-ын хайгуулын ТЗ-ийн бүртгэл \2 хуудас, Хүснэгт 27 ТЗ\, захирамжийн хуулбар 4. Бичил уурхай эрхлэгчдийн судалгаа: Хатанбулаг, Эргөн сумын 8 нөхөрлөлийн 76 уурхайчдын нэрс \2 х\, гэрээ \36 х\
44	Архангай аймгийн ЗД Б.Цэрэннадмид	14.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх 2018-2023 оны мэдээлэл, судалгаа, танилцуулга /сум, дүүрэг тус бүрээр, зурган мэдээллийн хамт/; 14.2.Бичил уурхай эрхлэгчдийн хүний нөөц, ашиглаж буй байдал, нөхөн сэргээлт, ашиглаж буй тоног төхөөрөмжийн мэдээлэл	2024.05.20 01/771 Хавсралт 31 хуудас	Тус аймгийн хэмжээнд хүчингүй болгосон түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн материалыг хавсралтаар хүргүүлэв.
45	Увс аймгийн ЗД Ч.Чимэд	14.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх 2018-2023 оны мэдээлэл, судалгаа, танилцуулга /сум, дүүрэг тус бүрээр, зурган мэдээллийн хамт/; 14.2.Бичил уурхай эрхлэгчдийн хүний нөөц, ашиглаж буй байдал, нөхөн сэргээлт, ашиглаж буй тоног төхөөрөмжийн мэдээлэл	2024.05.14 1/876 Хавсралт 127 хуудас	Нотлох баримт ирүүлэх тухай албан бичгийг 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр хүлээн авч танилцаад хавсралтаар холбогдох мэдээллийг нэгтгэн хүргэж байна. Аймгийн “Бичил уурхайн холбоо” ТББ-д одоогоор 50 нөхөрлөлийн 700 гаруй гишүүн бүртгэлтэй байна. Увс аймгийн хэмжээнд олгогдсон нийт түгээмэл тархацтай АМ-ын мэдээлэл 2013-2024 он: түгээмэл тархацтай 3 хайгуулын, 1 ашиглалтын ТЗ хүчинтэй, 13 ТЗ-ийг 2016-2022 онд чөлөөлсөн \3 х\.
46	Орхон аймгийн ЗД М.Түмэнжаргал	14.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх 2018-2023 оны мэдээлэл, судалгаа, танилцуулга /сум, дүүрэг тус бүрээр, зурган мэдээллийн хамт/; 14.2.Бичил уурхай эрхлэгчдийн хүний нөөц, ашиглаж буй байдал,	2024.05.16 01/1577 Хавсралт 19 хуудас	... хуулийн дагуу олгогдсон түгээмэл тархацтай АМ-ын хайгуулын болон ашиглалтын ТЗ-ийн мэдээллийг хүргүүлэв. Хавсралт 1: Түгээмэл тархацтай АМ-ын хайгуулын ТЗ-тэй ААН-үүд \8 ААН, 9х\ Хавсралт 2: Түгээмэл тархацтай АМ-ын ашиглалтын ТЗ-тэй ААН-үүд \9 ААН, 10х\

		нөхөн сэргээлт, ашиглаж буй тоног төхөөрөмжийн мэдээлэл		
47	Ховд аймгийн ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Ганболд	14.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх 2018-2023 оны мэдээлэл, судалгаа, танилцуулга /сум, дүүрэг тус бүрээр, зурган мэдээллийн хамт/;	2024.05.13 2/995 Хавсралт 3 хуудас	1. Ховд аймгийн бичил уурхай эрхлэгчдийн судалгаа \2 х\ 2. Ховд аймагт олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын талаарх мэдээлэл \1 х\
48	Ховд аймгийн Засаг даргын орлогч Х.Батболд	14.2.Бичил уурхай эрхлэгчдийн хүний нөөц, ашиглаж буй байдал, нөхөн сэргээлт, ашиглаж буй тоног төхөөрөмжийн мэдээлэл	2024.05.21 1/1039 Хавсралт 1 хуудас	1. Ховд аймагт түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл цуцалсан аж ахуйн нэгжийн судалгаа
49	Булган аймаг	14.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх 2018-2023 оны мэдээлэл, судалгаа, танилцуулга /сум, дүүрэг тус бүрээр, зурган мэдээллийн хамт/;	Албан бичгийн хариуг ирүүлээг үй	
50	Говьсүмбэр аймаг	14.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх 2018-2023 оны мэдээлэл, судалгаа, танилцуулга /сум, дүүрэг тус бүрээр, зурган мэдээллийн хамт/;	Албан бичгийн хариуг ирүүлээг үй	
51	Дорнод аймаг	14.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх 2018-2023 оны мэдээлэл, судалгаа, танилцуулга /сум, дүүрэг тус бүрээр, зурган мэдээллийн хамт/;	Албан бичгийн хариуг ирүүлээг үй	
52	Сүхбаатар аймаг	14.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх 2018-2023 оны мэдээлэл, судалгаа, танилцуулга /сум, дүүрэг тус бүрээр, зурган мэдээллийн хамт/;	Албан бичгийн хариуг ирүүлээг үй	
53	Төв аймаг	14.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх 2018-2023 оны мэдээлэл, судалгаа, танилцуулга /сум,	Албан бичгийн хариуг ирүүлээг үй	

		дүүрэг тус бүрээр, зурган мэдээллийн хамт/;		
54	Хөвсгөл аймаг	14.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх 2018-2023 оны мэдээлэл, судалгаа, танилцуулга /сум, дүүрэг тус бүрээр, зурган мэдээллийн хамт/;	Албан бичгийн хариуг ирүүлээг үй	
55	Хэнтий аймаг	14.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх 2018-2023 оны мэдээлэл, судалгаа, танилцуулга /сум, дүүрэг тус бүрээр, зурган мэдээллийн хамт/;	Албан бичгийн хариуг ирүүлээг үй	
56	Монголросцвет мет ТӨҮГ-ын захирал Б.Мөнхбат	22.1.Бор-Өндөр Уулын баяжуулах үйлдвэрийн Баргилтын уурхайн төмрийн хүдрийн баяжмалыг экспортолсон худалдах, худалдан авах гэрээний хуулбар (2012-2024); 22.2.Бор-Өндөр Уулын баяжуулах үйлдвэрийн Баргилтын уурхайн төмрийн хүдэр болон завсрын бүтээгдэхүүнийг дотоодод борлуулсан худалдах, худалдан авах гэрээний хуулбар (2012-2024); 22.3.Бор-Өндөр Уулын баяжуулах үйлдвэрийн жоншны баяжмалыг дотоодод борлуулсан болон экспортолсон худалдах, худалдан авах гэрээний хуулбар (2012-2024);	2024.05.16 1/1177 Хавсралт 3629 хуудас	1. АМ хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох үйл ажиллагаа болон ашигт малтмалын ТЗ-ийн төлбөртэй холбоотой 3 хуудас; 2. ТЗ-өөр олгосон газар, түүний хэвлийг зориулалтын дагуу ашиглаж байгаатай холбоотой 3 хуудас; 3. Бор-Өндөр УБҮ-ийн Баргилтын уурхайн төмрийн баяжмалыг экспортолсон худалдах, худалдан авах гэрээний хуулбар 1509 хуудас (2012-2024); 4. Бор-Өндөр УБҮ-ийн Баргилтын уурхайн төмрийн хүдрийг дотоодод борлуулсан худалдах, худалдан авах гэрээний хуулбар 1470 хуудас (2012-2024); 2. Бор-Өндөр УБҮ-ийн хайлуур жоншны хүдэр, баяжмалыг дотоодод борлуулсан болон экспортолсон худалдах, худалдан авах гэрээний хуулбар 644 хуудас (2012-2024).
57	“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК	21.1.Төмрийн баяжмалыг экспортолсон худалдах, худалдан авах гэрээний хуулбар (2012-2024); 21.2.Түүхий хүдэр болон завсрын бүтээгдэхүүнийг дотоодод борлуулсан худалдах, худалдан авах гэрээний хуулбар (2012-2024); 21.3.Хуурай соронзон баяжуулах үйлдвэрийн өргөтгөл хийх шийдвэр, тендер шалгаруулалт, худалдан авалт, ажлын гүйцэтгэл, үр дүнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;	Албан бичиг ирүүлээг үй	Цахим шуудангаар 21 файл ирүүлсэн
58	MEC Mongolia Energy Corporation		2024.05.08 01/373	Хөшөөт төслийн товч танилцуулга

			Хавсралт 8 хуудас	
59	Монголын жонш олборлогч, үйлдвэрлэгч, экспортлогчдын холбоо		2024.05.15 1/07	... УИХ-ын Хянан шалгах түр хорооноос зохион байгуулах нийтийн сонголд "Нийтийн сонголын тухай" хуулийн 13.1-д (Сонголд тухайн асуудлаар мэргэшсэн мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагыг заавал оролцуулна.) гэж заасныг үндэслэн манай холбооноос төлөөлөл оролцуулна уу.
60	Монголын жонш олборлогч, үйлдвэрлэгч, экспортлогчдын холбоо		2024.05.26 04/4 Хавсралт 19 хуудас	Мэдээлэл: Салбарын хууль тогтоомжийн зөрчилдөөн, хийдлийн талаар
61	Нээлттэй нийгэм форумын гүйцэтгэх захирал		2024.05.16 46/1 Хавсралт 6 хуудас	Олборлох салбарын засаглалын асуудлаар ажилладаг төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааны хүрээнд цугларсан маргаан бүхий эрх зүйн зөрчилтэй байх магадлалтай тусгай зөвшөөрлийн мэдээллийг нэгтгэн хүргүүлж байгааг хүлээн авна уу. Эрх зүйн зөрчилтэй байх магадлалтай маргаан бүхий ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээлэл
62	Ганбөмбөлөг Ундрага ХХК-ийн гүйцэтгэх захирал Э.Энх-Амгалан		2024.05.09 24/03/17 0 Хавсралт	... энэхүү хуулийн буруу тогтолцоог яаралтай өөрчлөн, өмнө нь ноогдуулсан үндэслэлгүй төлбөрийг хүчингүй болгож үндэсний үйлдвэрлэгчдээ дэмжсэн, ээлтэй хууль санаачлан батлуулж өгөхийг хичээнгүйлэн хүсье. Нотлох баримтуудыг хавсралтаар хүргүүлэв. Үүнд: 1. МУ-ын Ерөнхийлөгч, МУ-ын Ерөнхий Сайд, УИХ-ын гишүүд болон холбогдох газруудад АМНАТ-тай холбоотой асуудлаа албан бичгээр илгээсэн хүсэлтүүд 2. Ганхүдэр Орд ХХК-с 2023, 2021, 2020, 2019 онуудын албан бичиг 3. Ганбөмбөлөг Ундрага ХХК-н 2023 онд явуулсан албан бичиг 4. МУ-ын үндсэн хуулийн цэцийн 2019.10.30-ны өдрийн Дугаар 04 5. МУ-ын үндсэн хуулийн цэцийн 2019.06.28 Дугаар 03

ХШТХ-ны нотлох баримт ирүүлэх тухай 2024 оны 06, 12 дугаар тогтоолын дагуу зарим төрийн байгууллага буюу Төрийн худалдан авах ажиллагааны газар, Санхүүгийн зохицуулах хороо, Стандарт хэмжил зүйн газар, Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК зэрэг байгууллагууд албан бичгийг оройтуулж буюу нотлох баримт болгон ашиглах боломжгүй хугацаанд ирүүлсэн.

Булган, Говьсүмбэр, Дорнод, Сүхбаатар, Төв, Хөвсгөл, Хэнтий аймгийн Засаг дарга нар албан бичгийн хариуг ирүүлээгүй.

Хяналт шалгалтын явцад Монголын жонш олборлогч, үйлдвэрлэгч, экспортлогчдын холбоо ГҮТББ-аас 2 албан бичгийг 2024 оны 055 дугаар сарын 15, 26-ны өдрүүдэд ирүүлсэн. Нээлттэй нийгэм форумын гүйцэтгэх захирал, мөн Ганбөмбөлөг Ундрага ХХК, Мо-Энко ХХК-аас холбогдох санал, баримтыг хавсарган ирүүлсэн.

ГУРАВ.НОТЛОХ БАРИМТЫН ИЖ БҮРДЭЛД ХЯНАЛТ ХИЙХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

УИХ-ын Хянан шалгах түр хороонд ирүүлсэн нотлох баримтын бүрдүүлбэрт хяналт хийж үзэхэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Нийслэлийн Засаг дарга зэрэг 7 байгууллагаас ирүүлсэн баримт нь нотлох баримтын шаардлага хангаагүй.

ДӨРӨВ.АШИГТ МАЛТМАЛ ХАЙХ, АШИГЛАХ ЗОРИУЛАЛТААР ГАЗАР, ТҮҮНИЙ ХЭВЛИЙГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛӨӨР ОЛГОХ, ТӨЛБӨР, ТАТВАР НОГДУУЛАХ, ХУРААХТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ҮҮРЭГ БҮХИЙ ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ

1.Ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, бүртгэх үйл ажиллагааны талаар:

1.1.1997-2023 оны хооронд нийт ашигт малтмалын хайгуулын 14,299 тусгай зөвшөөрөл олгосон байна. Улсын хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын газрын нэгдмэл санд ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлөөр олгогдсон газар 6,930.6 мян.га талбайд хүчин төгөлдөр 2,767 тусгай зөвшөөрөл, үүнээс 1,731 ашиглалтын тусгай зөвшөөрөл, 1,036 хайгуулын тусгай зөвшөөрөл бүртгэлтэй байна. Нийт тусгай зөвшөөрлөөр олгосон газар нь Монгол Улсын газар нутгийн 4.5 хувийг эзэлж байна.

1.2.Ашигт малтмалын тухай хууль 1994, 1997, 2006 онуудад шинэчлэн батлагдаж байсан бөгөөд өнөөдөр 2006 онд батлагдсан шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр үйлчилж байна. 2006 оноос хойш Ашигт малтмалын тухай хуульд 43 удаа нэмэлт, өөрчлөлт орсон.

1.3.Ашигт малтмалын тухай хуулиар ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг Засгийн газрын тогтоолоор болон Хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын журмаар цахим хэлбэрээр зохион байгуулан олгож байна. Хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох журам, сонгон шалгаруулалтын комиссын бүрэлдэхүүнийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар баталдаг. Хамгийн өндөр үнийн санал өгсөн тохиолдолд 70 хүртэлх оноогоор үнэлж байгаа нь геологи хайгуулын мэргэжлийн аж ахуйн нэгжүүдийн ажлын туршлага, техникийн хүчин чадал, мэргэжлийн ур чадварыг үнэгүйдүүлсэн, тусгай зөвшөөрлийг арилжааны хэрэгсэл болгох үндсэн шалтгаан, нөхцөлийг бүрдүүлж байна гэж дүгнэсэн.

1.4.Хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтад оролцоод хамгийн өндөр үнийн санал өгч шалгарсан ААН зөрүү төлбөр төлөхгүй, тусгай зөвшөөрөл авахгүй орхиж явах тохиолдол 68 удаа гарсан бөгөөд энэ нь тухайн талбайд явагдсан сонгон шалгаруулалтыг хүчингүй болгох, хууль бусаар ашигт малтмал олборлох зорилгоор уг талбайг эзэнгүй байлгах гэсэн санаатай үйлдэл байж болохоор байна.

1.5.Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газартай давхцуулан ашигт малтмал хайх, олборлох тусгай зөвшөөрөл олгохыг хориглодог хуулийн зохицуулалттай.

Нотлох баримтаар, газрын удирдлагын системд бүртгэлтэй Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газрын мэдээллээр нийт 1094 нэгж талбарын 184.7 га газартай хайгуулын тусгай зөвшөөрөл, нийт 2151 нэгж талбарын 191.9 га талбай газартай ашиглалтын тусгай зөвшөөрөл давхцалтай байна.

1.6. Байгууллага хооронд мэдээлэл солилцох хамтын ажиллагаа хангалтгүй, Төрийн байгууллагуудын хууль тогтоомж мөрдөөгүй хариуцлагагүй үйл ажиллагаанаас болж 3245 иргэний газар өмчлөх эрх зөрчигдсэн. Ингэснээр Монгол Улсын Үндсэн хууль зөрчигдөхөөс гадна Газрын хэвлийн тухай хуулийн 20.3, Газрын тухай хуулийн 31.3, Ашигт малтмалын тухай хуулийн 14.1, 24.4.2, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 6.1.1 дэх заалт тус тус зөрчигдсэн байна.

1.7. Улсын тусгай хэрэгцээний болон хуулиар хориглосон бусад газарт ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагаа явуулахыг хориглодог хуулийн зохицуулалттай. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Ашигт малтмал, газрын тосны газар болон Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас ирүүлсэн Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайн улсын тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалтай байдлын талаарх мэдээлэл зөрүүтэй байна. Ашигт малтмал, газрын тосны газар болон Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн давхцалтай газар нутгийг дараах байдлаар ангилан дүгнэсэн. Үүнд:

- Ашигт малтмал, газрын тосны газрын ирүүлсэн мэдээллээр тусгай хамгаалалттай газар, нутагтай давхцалтай 40 ашиглалтын, 1 хайгуулын тусгай зөвшөөрөл байна.
- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас ирүүлсэн мэдээллээр тусгай хамгаалалттай газар, нутагтай давхцалтай 19 ашиглалтын тусгай зөвшөөрөл байна.
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны ирүүлсэн тусгай хамгаалалттай газар, нутагтай давхцалтай 22 ашиглалтын, 7 хайгуулын тусгай зөвшөөрөл байна.

1.8. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас ирүүлсэн нотлох баримтад 53 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайтай давхцалтай 97 түүх, соёлын дурсгалт газар, хайгуулын 115 тусгай зөвшөөрөлтэй давхцалтай 263 түүх, соёлын дурсгалт газар байна. ШУА-ийн Археологийн хүрээлэнгээс нийт 20 түүх, соёлын дурсгалт газрын 6 нь устсан, 6 нь дам эрсдэл учруулсан, 8 нь нөлөөллийн бүсэд орсон баримт ирүүлсэн. Соёлын яамнаас ирүүлсэн баримтаар 9 түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын байршил нь ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайтай давхцсан зөрчил илэрсэн.

2. Тусгай зөвшөөрлөөр олгосон газар, түүний хэвлийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэх талаар:

2.1. Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхим нь хуулиар эрх олгоогүй журам, маягт баталж Монгол Улсаас экспортолж байгаа уул уурхайн бүтээгдэхүүнд гарал үүслийн гэрчилгээг олгож байгаа үйл ажиллагааг таслан зогсоож, холбогдох мэргэжлийн байгууллагаас гэрчилгээг авах, түүнчлэн замын хуудас, тээвэрлэлтийн хуудсаар экспортолж байгаа ашигт малтмалын гарал үүсэлд хяналт тавих зайлшгүй шаардлагатай байна.

2.2.Хянан шалгах ажлын хүрээнд тогтоогдсон тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайд үйл ажиллагаа явуулахгүй байгаа 1076 ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, нөөцгүй, нөөц дууссан, тодорхойгүй ашиглалтын тусгай зөвшөөрлийн асуудлыг шийдвэрлэх, тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайд олборлолтын үйл ажиллагаа явуулахгүй байгаа боловч ашигт малтмал экспортолж буй этгээдүүдэд хяналт шалгалтыг зохион байгуулж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй байна.

2.3.Хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрх зүйн зохицуулалтад уурхайн хаалтын асуудлыг байгаль орчны нөхөн сэргээлттэй холбон ойлгож ирсэн нь хаалтын асуудлыг бүрэн шийдвэрлэхэд хангалтгүй байна. Уурхайн хаалт, хаалтын дараах хяналт, хаасан уурхайг орон нутагт хүлээлгэж өгөх зэрэг асуудлуудыг цогц байдлаар зохицуулах ёстой. Тухайлбал, хаалтаа бүрэн хийсэн уурхайн талбайг ирээдүйд өөр зориулалтаар ашиглахтай холбоотой харилцааг зохицуулсан эрх зүйн орчин дутагдалтай байна.

3.Нутгийн захиргааны байгууллагаас ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар олгож буй зөвшөөрөл, түүний хэрэгжилтийн талаар:

3.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу орон нутгаас олгосон нийт 498 тусгай зөвшөөрөл байгаагаас хайгуулын 359, ашиглалтын 139 тусгай зөвшөөрөл байна. Дундговь, Сэлэнгэ, Өмнөговь, Улаанбаатар хотуудад түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хамгийн их буюу нийт тусгай зөвшөөрлийн 44 хувийг эзэлж байна. Нотлох баримтаар ашигт малтмалын хайгуулын болон алт, нүүрс, жонш, төмөр зэрэг ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайтай зэрэгцүүлэн Дундговь аймагт 31, Өмнөговь аймагт 13, Сэлэнгэ аймагт 10, Төв аймагт 9 түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгожээ.

3.2.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль батлагдсанаас хойш түгээмэл тархацтай ашигт малтмалын Улсын нөөцийн нэгдсэн тоо бүртгэл, түүний хөдөлгөөн, баланс огт хийгдэхгүй байна. Энэ нь Газрын хэвлийн тухай хуулийн 45.1 дэх хэсэгт “Ашигт малтмалын нөөц, орд, илрэлийг улсын нэгдсэн тоо бүртгэлд заавал бүртгэнэ” гэж заасныг зөрчиж байна.

3.3.Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулах нэрээр халхавчлан “журамд зааснаас том оврын техник, хэрэгсэл ашиглах, нөхөн сэргээгдээгүй эвдрэлд орсон талбайд үйл ажиллагаа явуулах ёстой байтал хөндөгдөөгүй эрүүл талбайд хөндөгдсөн гэх хуурамч материал бүрдүүлэн олборлох, санаатайгаар хууль бус олборлогч нарыг оруулж, эвдрэлд оруулах” зэрэг журмын хэрэгжилтэд нийтлэг алдаа зөрчил нэмэгдэх хандлагатай байна.

3.4.Бичил уурхайн асуудлуудаар нотлох баримтыг шинжлэн судлахад Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны хууль, эрх зүйн зохицуулалтууд “нэгдсэн зохион байгуулалтад оруулж, ажлын байр бий болгох, орон нутгийн төсөвт орох орлогыг нэмэгдүүлэх, бичил уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах” гэсэн анхны үзэл баримтлал нь дэвшүүлсэн зорилтоо хангасан боловч цаг үе, ач холбогдлоо алдсан байна. Иймд бичил уурхайн асуудлыг олон улсын жишигт нийцүүлэн эрх зүйн шинэчлэл хийх шаардлагатай байна.

4.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчид төлбөр, татвар ногдуулах, тайлагнах, төлөх, хураах үйл ажиллагааны талаар:

4.1.Ашигт малтмалыг дотоодод борлуулахад баримтлах жишиг үнэ зарлагддаггүйгээс тусгай зөвшөөрөл эзэмшигчийн борлуулалтын орлогод үндэслэн АМНАТ ногдуулж байгаа нь АМНАТ-тэй холбоотой маргаан зөрчил үүсэх шалтгаан болж байна.

4.2.Татварын ерөнхий хууль, Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу татвар төлөгч холбогдох хуулиар төлбөл зохих татварын ногдлоо өөрөө тодорхойлж, хуулиар тогтоосон хугацаанд төсөвт төлөх үүрэгтэй. Гэвч 2022 онд 157, 2023 онд 129 аж ахуйн нэгж АМНАТ-ийн тайлан ирүүлээгүй байна.

4.3.2023 оны байдлаар бүтээгдэхүүн экспортолсон боловч татварын албанд АМНАТ-ийн тайлан тайлагнаагүй 44 аж ахуйн нэгж байна. Үүнээс жоншны экспорт дийлэнх хувийг эзэлж байгаа бөгөөд нийт 8.8 тэрбум төгрөгийн АМНАТ тайлагнах, төлөхөөс зайлсхийсэн үйлдэл гэж үзэхээр байна.

4.4.Ашигт малтмалын тухай хуулиар үүсмэл ордыг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлдэг байсныг аж ахуйн нэгж хоорондын гэрээгээр зохицуулдаг болсон нь үүсмэл ордын АМНАТ-ийг 2.5 хувиар ногдуулж орлого буурах нөхцөлийг бий болгосон бөгөөд 6 аж ахуйн нэгжид хуулиар давуу байдал олгосон байна.

4.5.Дагалдах ашигт малтмалын бүтээгдэхүүнд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулахдаа гаалийн лабораторийн дүгнэлтээр илэрсэн бүх төрлийн ашигт малтмалд ногдуулж байгааг ашигт малтмалын хүдэр баяжмалын төрөл, ангиллаас хамааруулан эдийн засгийн хувьд үр ашигтай дагалдах ашигт малтмалыг тодорхойлж, түүнд АМНАТ ногдуулах нь зүйтэй байна.

4.6.Татварын албанаас уул уурхайн компаниудад хийсэн хяналт шалгалтын 24.5 хувьд нь АМНАТ-тэй холбоотой зөрчил илэрсэн байна. Сүүлийн жилүүдэд АМНАТ-тэй холбоотой зөрчил нэмэгдэх хандлагатай байна. Тусгайлсан удирдамжтайгаар 85 татвар төлөгчид хяналт шалгалт хийхэд нийт төлбөр ногдох суурь үнэлгээний 2.3 их наяд төгрөгийн зөрчил илрүүлсэн нь ТЕГ-аас ирүүлсэн нотлох баримтаар илэрлээ.

4.7.Өнөөдрийн байдлаар Татварын албанд хуримтлагдсан Уул уурхайн салбарын татварын нийт өр 3.3 их наяд, үүнээс 514 аж ахуйн нэгжид хамаарах АМНАТ-ийн өр 1.1 их наяд төгрөг байна.

5.Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудын ашиглалт, эзэмшлийн талаар:

5.1.Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын 16 ордыг баталсан. Эдгээр стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудаас өнөөдрийн байдлаар 7 ордод үйл ажиллагаа явуулаагүй, 9 ордод олборлолтын үйл ажиллагаа явуулж байна.

5.2.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, орлого төвлөрүүлэх суурь бүтцийг бий болгох замаар Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээх нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцэхээр байна.

ТАВ.УИХ-ЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

Ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, төлбөр, татвар ногдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 25 дугаар тогтоолоор байгуулагдсан Хянан шалгах түр хорооны тайлан, санал, дүгнэлт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, төлбөр, татвар ногдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хуульд ашигт малтмал эрэх, хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, бүртгэх, зориулалтын дагуу ашиглах, албан татвар, төлбөр, хураамж ногдуулах, тайлагнах, хураах үйл ажиллагааг зохицуулсан хуулийн зүйл, хэсэг, заалтад хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, чиг үүргийн шинжилгээг хийж, холбогдох хуулийн төслийг боловсруулан 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээх зарчимд нийцүүлэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;

3/Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газартай давхцуулан ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгосон, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгосон талбайд Монгол Улсын иргэнд газар өмчлүүлсэн асуудлыг шалгаж, холбогдох арга хэмжээг авч, хууль бус шийдвэр гаргасан албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх;

4/Монгол Улсын Үндсэн хуулийн Долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна.” гэж заасны дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрыг хамгаалалтад авч, бүртгэлийг сайжруулах;

5/хамгаалалтын бүс тогтоосон түүх, соёлын дурсгалт газар, гол, мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газар, усны сан бүхий газар, улсын тусгай

хамгаалалттай газар нь ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан асуудлыг судалж, төрийн байгууллагын мэдээлэл зөрүүтэй байгаад дүгнэлт хийж, мэдээллийн сан хоорондын уялдааг хангах, орон зайн өгөгдөлд суурилсан мэдээллийн системийн нэгдмэл байдлыг хангахтай холбогдох арга хэмжээг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан зохион байгуулах;

6/ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн өр үүссэн шалтгааныг судалж, өрийн үлдэгдэл 1.1 их наяд төгрөгийг яаралтай барагдуулах арга хэмжээг авч, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах саналыг боловсруулан 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

7/Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам, Ашигт малтмалын хүдэр, баяжмал, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинд тавигдах шаардлага, ангилал, тооцох үндсэн зарчим, аргачлалыг шинэчлэн боловсруулах, эдийн засгийн хувьд үр ашигтай дагалдах ашигт малтмалд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах эрх зүйн орчныг бий болгох;

8/үүсмэл ордоос олборлосон ашигт малтмалын бүтээгдэхүүнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 2.5 хувиар ногдуулж байгаа хуулийн холбогдох заалтад үр дагаврын үнэлгээ хийж, холбогдох саналыг боловсруулан 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах;

9/ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч өөрчлөгдөхөд төлөх татвар ногдуулах суурийг тооцох аргачлалыг боловсронгуй болгох;

10/хууль бусаар ашигт малтмал олборлогчийн үйл ажиллагааг таслан зогсоох, эвдрэлд орсон, орхигдсон талбайн байгаль орчинд учруулсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлэх, нөхөн сэргээх, төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцох, ажлын уялдаа холбоог сайжруулах;

11/уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн хаалт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд хяналт тавих, хаасны дараа орон нутагт хүлээлгэж өгөх асуудлыг зохицуулсан эрх зүйн орчныг бүрдүүлэх;

12/бичил уурхайгаар ашигт малтмал олборлох эрх зүйн зохицуулалтын талаар дүн шинжилгээ хийх, холбогдох саналыг боловсруулан 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах;

13/Монгол Улсын нийт газар нутгийн эрдэс баялгийн хэтийн төлөвийг тодорхойлж үнэлэх, зохистой хэрэглээг хянах зорилгоор геологийн суурь судалгааны ажлыг эрчимжүүлэх;

14/Монгол Улсын ашигт малтмалын нөөц, орд, илрэл болон газрын хэвлийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг хуульд заасны дагуу шинэчлэх, ордын ашигт малтмалын нөөцийн үнэн зөв байдал, тоо хэмжээ, чанар, орших нөхцөл, судалгааны түвшин, эдийн засгийн ач холбогдол, ордыг олборлолтод бэлтгэсэн байдалд магадлан шинжилгээ хийж, үнэмшлийг тогтоох;

15/уул уурхайн биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх;

16/Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхим нь хуулиар эрх олгоогүй журам, маягт баталж Монгол Улсаас экспортолж байгаа уул уурхайн бүтээгдэхүүнд гарал үүслийн гэрчилгээг олгож байгаа үйл ажиллагааг таслан зогсоож, холбогдох хуулийн төслийг боловсруулан 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах.

2.Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос байгаль орчны нөхөн сэргээлт хийх үүргээ биелүүлээгүй, хууль бусаар газрыг эвдрэлд оруулж, талбайн дүгнэлт гаргуулж, түүнд үндэслэн бичил уурхайгаар ашиглуулж байгаа асуудал илэрсэн гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг холбогдох хуулийн дагуу шалгаж шийдвэрлүүлэхийг Монгол Улсын Ерөнхий Прокурор /Б.Жаргалсайхан/, Авлигатай тэмцэх газар /З.Дашдаваа/, Цагдаагийн Ерөнхий газар /Т.Сүхболд/-т тус тус зөвлөсүгэй.

3.Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг авч, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, түр хорооны үйл ажиллагаанд саад учруулсан албан тушаалтан, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр нотлох баримтыг шинжлэн судлах сонсголд ирээгүй гэрчид хүлээлгэх хариуцлагын асуудлыг 2024 оны 3 дугаар улиралд багтаан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ц.Цэрэнпунцаг/, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /Ж.Батжаргал/, Хууль зүйн байнгын хороо /Д.Цогтбаатар/-нд тус тус даалгасугай.

5.Энэ тогтоолыг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

ЗУРГАА.ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ ТАЙЛАН

1.АШИГТ МАЛТМАЛ ХАЙХ, АШИГЛАХ ЗОРИУЛАЛТААР ГАЗАР, ТҮҮНИЙ ХЭВЛИЙГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛӨӨР ОЛГОХ, БҮРТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1.Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн олголт, бүртгэлийн үйл ажиллагаа

БНМАУ-ын Газрын хэвлийн тухай хууль 1988 онд батлагдсанаар газрын хэвлийн геологи судалгааны ажил, ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны эрх зүйн үндэслэл анх бүрдсэн байна.

Ашигт малтмалын тухай хууль /1994 он/

БНМАУ-ын Газрын хэвлийн тухай хууль 1988 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсанаар газрын хэвлийн геологи судалгааны ажил, ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны эрх зүйн үндэслэл анх бүрдсэн.

Улмаар УИХ-аас 1994 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр “Ашигт малтмалын тухай хууль”-ийг баталснаар Монгол Улсад ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааг төрийн эрх бүхий байгууллагаас олгосон “тусгай зөвшөөрөл”-ийн үндсэн дээр явуулах эрх зүйн зохицуулалттай болсон. Уг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн эрх бүхий байгууллагаас ашигт малтмалын хайгуул хийх болон ашигт малтмалын орд ашиглах эрх олгосон гэрчилгээг тусгай зөвшөөрөл гэнэ” гэж заасан байна. Мөн хуулийн 8 дугаар зүйлд зааснаар стратегийн болон тусгай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг Төрийн захиргааны төв байгууллага, ердийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга нь төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн олгохоор заасан.

Ашигт малтмалын тухай хууль /1997 он/

50	Улз групп ХХК	ХХК	5	4	1	А.Бүрэнтогтох	Ц.Барсболд, А.Бүрэнтогтох
51	Хүннү алтай минералс ХХК	ХХК (ГХОХХК)	5	0	5	Techathumana Sitthichai \Тайланд\,	Chaimongkol Mrs.Somruedee
52	Шинь Шинь ХХК	Гадаадын хөрөнгө оруулалттай	5	0	5	Song Guiming \БНХАУ\	Chen Xiaoming

Сэдвийн дүгнэлт

Ашигт малтмалын тухай хууль 1994, 1997, 2006 онуудад шинэчлэн батлагдаж байсан бөгөөд өнөөдөр 2006 онд батлагдсан хууль хүчин төгөлдөр үйлчилж байна.

Хуульд заасан хугацаанаас илүү насжилттай хайгуулын тусгай зөвшөөрөл 45 байна. Эдгээр нь шүүхийн шийдвэрээр, хуулийн үндэслэлтэй сэргээгдсэн болох нь тогтоогдсон.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Ашигт малтмалын тухай хуулиар ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг Засгийн газрын тогтоолоор болон хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох журмыг мөрдөж байна.

Хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж байна.

Хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын үнэлгээ нь “техникийн санал”, “хамгийн өндөр үнийн санал” гэсэн 2 үндсэн хэсэгтэй бөгөөд тус бүрд харгалзан 30, 70 хүртэл оноогоор дүгнэж шийдвэрлэдэг байна.

Хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох журам, сонгон шалгаруулалтын комиссын бүрэлдэхүүнийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар баталж байна.

Хамгийн өндөр үнийн санал өгсөн тохиолдолд 70 хүртэлх оноогоор үнэлж байгаа нь геологи хайгуулын мэргэжлийн аж ахуйн нэгжүүдийн ажлын туршлага, техникийн хүчин чадал, мэргэжлийн ур чадварыг үнэгүйдүүлсэн, тусгай зөвшөөрлийг арилжааны хэрэгсэл болгож байгаа нь шинжлэн судлах явцад тогтоогдлоо.

Хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтад оролцоод хамгийн өндөр үнийн санал өгч шалгарсан ААН зөрүү төлбөр төлөхгүй, тусгай зөвшөөрөл авахгүй орхиж явах тохиолдол 68 удаа гарсан бөгөөд энэ нь тухайн талбайд явагдсан сонгон шалгаруулалтыг хүчингүй болгох, хууль бусаар ашигт малтмал олборлох зорилгоор уг талбайг эзэнгүй байлгах гэсэн санаатай үйлдэл байж болохоор байна.

1.2. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайн давхцал

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй талбайн мэдээллийг Монгол улсын иргэнд өмчлүүлсэн газрын мэдээлэлтэй давхцуулсан байдал

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн гурав дахь хэсэгт “Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно.” гэж заасан байдаг.

Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газрыг ашигт малтмал хайх, олборлох үед хэрхэн хамгаалах, хадгалах, хориглох тухай асуудлыг дараах хуулиудаар зохицуулжээ. Үүнд:

- ▶ Газрын хэвлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т “Газрын хэвлийг ашиглагчид нь газар өмчлөх, эзэмших, ашиглах талаарх бусдын эрхийг аливаа хэлбэрээр хөндөхгүй байх үүрэгтэй бөгөөд ийм зөрчлийн улмаас тэдгээрт учруулсан хохирлыг өөрийн хөрөнгө, зардлаар нөхөн төлнө”;
- ▶ Газрын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т “Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно”, мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.Хүсэлт гаргасан газар нь бусдын эзэмшиж, ашиглаж байгаа газартай ямар нэг хэмжээгээр давхцаагүй байна”;
- ▶ Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т “Төр өмчлөгчийн хувьд энэ хуульд заасан нөхцөл, шаардлага, журмын дагуу ашигт малтмал эрэх, хайх, ашиглах эрхийг бусад этгээдэд олгох эрхтэй, мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4.2.тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон, түүнчлэн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайтай давхцаагүй;
- ▶ Газар өмчлүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “иргэнд газар тариалангийнхаас бусад зориулалтаар газар өмчлүүлэхдээ аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, аймгийн төвийн болон хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан, сумын төв, тосгоны тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрт заасан иргэдэд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, газар өмчилж авахыг хүссэн иргэдийн тоог иш үндэс болгох, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-т “хот, тосгон, бусад суурины нутаг дэвсгэр дэх нийтийн эдэлбэрийн газар /гудамж, талбай, зам, амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэг, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай зэрэг/, бэлчээр, ойн болон усны сан бүхий газар, тусгай хэрэгцээний газар, зам, шугам сүлжээний газраас бусад газарт” гэж тус тус заажээ.

Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газартай давхцуулан ашигт малтмал хайх, олборлох тусгай зөвшөөрөл олгохыг хориглодог.

Иймд УИХ-ын хяналт шалгалтын түр хорооноос ГЗБГЗЗЕГ, АМГТГ-т УИХ-16/3286, УИХ-16/3285 дугаар албан бичгийг хүргүүлж нотлох баримт гаргуулан

авсан. Ирүүлсэн албан бичгийн огноо, дугаар гарын үсэг зурсан албан тушаалтан, хавсралт хуудасны тоог хүснэгтээр харуулав.


Байгууллагын нэр	Гарын үсэг зурсан албан тушаалтан	Албан бичгийн, огноо, дугаар	Хуудасны тоо
Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар	Дарга А.Энхманлай	2024.05.10 1/1207	1,Хавсралт 33 хуудас
Ашигт малтмал, газрын тосны газар	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Баярмандал	2024.05.02 1/2003	1, Хавсралт 1 CD

Нотлох баримтаар, Газрын удирдлагын системд бүртгэлтэй Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газрын мэдээллийг ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий газрын мэдээлэлтэй давхцуулан шалгахад нийт 1094 нэгж талбарын 184.7 га газар давхцалтай байна.

Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газартай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл давхцуулж олгосон байдал

№	Аймаг	Сум	Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /м.кв/	Талбайн хэмжээ /га/
1	Баян-Өлгий	Буянт	8	11652	1.2
		Дэлүүн	130	171543	17.2
		Өлгий	38	28021	2.8
		Толбо	1	696	0.1
		Цэнгэл	16	14472	1.4
2	Булган	Хангал	21	14700	1.5
3	Дорноговь	Сайншанд	4	8000	0.8
4	Төв	Баянцогт	6	12000	1.2
		Жаргалант	820	1388793	138.9
		Лүн	50	197564	19.8
Нийт			1094	1847441	184.7

Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газартай тусгай зөвшөөрлийн талбайн давхцал




Нотлох баримтаар, Газрын удирдлагын системд бүртгэлтэй Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газрын мэдээллийг ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий газрын мэдээлэлтэй давхцуулан шалгахад нийт 2151 нэгж талбарын 191.9 га талбай газар давхцалтай байна.


Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газартай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл давхцуулж олгосон байдал

№	Аймаг	Сум	Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /м.кв/	Талбайн хэмжээ /га/
1	Булган	Орхон	1	699	0.1
2	Говьсүмбэр	Сүмбэр	800	559799	56.0
		Шивээговь	985	1031636	103.2
3	Дархан-Уул	Дархан	15	11493	1.1
4	Дорнод	Хэрлэн	8	5243	0.5
5	Өмнөговь	Цогтцэций	76	47969	4.8
6	Сэлэнгэ	Мандал	14	9786	1.0
		Сайхан	127	163638	16.4
7	Төв	Алтанбулаг	1	5000	0.5
		Заамар	4	11779	1.2
8	Улаанбаатар	Багануур	4	2796	0.3
		Баянзүрх	24	13606	1.4
		Сонгинохайрхан	71	42114	4.2
		Хан-Уул	17	10543	1.1
9	Хөвсгөл	Түнэл	4	2454	0.2
Нийт			2151	1918555	191.9

Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газартай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл давхцуулж олгосон байдал




8 аймгийн 11 сум, Улаанбаатар хотын 4 дүүрэгт өмчлүүлсэн газар ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайтай давхцалтай байх бөгөөд үүнээс хамгийн их буюу Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд газраа өмчилж авсан 800, Шивээговь суманд 985, Сэлэнгэ аймгийн Сайхан суманд 127 иргэн, Өмнөговь аймгийн Цогтцэций суманд 76, Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгт 71 иргэний эрх ноцтой зөрчигдөж байна.




Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайтай давхцалтай өмчлүүлсэн газар



Говьсүмбэр аймгийн Шивээговь суманд ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайтай давхцалтай өмчлүүлсэн газар



Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгт ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайтай давхцалтай өмчлүүлсэн газар




Өмнөговь аймгийн Цогтцэций суманд ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайтай давхцалтай өмчлүүлсэн газар

Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайтай давхцалтай Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газрын мэдээллийг он оноор, мөн өмчлүүлсэн болон тусгай зөвшөөрөл олгосон хугацаагаар ангилан шалгаж үзэхэд 2012-2019 онд 75-658 иргэнд газар өмчлүүлжээ.

Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй газарт давхцалтай өмчлүүлсэн газрын мэдээлэл


Д/д	Газар өмчлүүлсэн он /сар/	Өмчилсөн газрын тоо	Талбайн хэмжээ /м.кв/	Газар өмчлүүлсний дараа олгосон ашиглалтын ТЗ тоо	Ашиглалтын ТЗ олгосны дараа өмчлүүлсэн газрын тоо
1	2003	2	708	0	2
2	2004	11	6950	0	11
3	2005	1	658	1	0
4	2008	4	3200	1	3
5	2009	3	2056	1	2
6	2010	30	22514	0	30
7	2011	19	12727	1	18
8	2012	257	361450	207	50
9	2013	285	307490	272	13
10	2014	88	86272	72	16
11	2015	125	87885	108	17
12	2016	256	190431	1	255
13	2017	658	470618	0	658
14	2018	218	154733	2	216
15	2019	75	61537	0	75
16	2020	56	63084	0	56
17	2021	13	14647	0	13
18	2022	65	67481	0	65
19	2023	31	37596	0	31
20	2024	10	13071	0	10

Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй давхцсан, өмчилсөн газрын мэдээлэл




Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохоос өмнө 700 орчим иргэнд газар өмчлүүлсэн бол, Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосны дараа 1400 гаруй иргэнд газар өмчлүүлсэн зөрчил гарсан байна.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлсний дараа ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгосон байдал



Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгосны дараа Монгол Улсын иргэнд газар өмчлүүлсэн байдал



Говьсүмбэр аймгийн Сүмбэр, Шивээговь суманд гадаадын 100 хувь хөрөнгө оруулалттай “Эйкүсора” ХХК-д Нүүрс олборлох зориулалтаар тусгай зөвшөөрлийг 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдөр олгосон байна.

2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө 2012 онд Говьсүмбэр аймгийн Шивээговь суманд 207 иргэнд, 2013 онд Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд 189 иргэнд газар өмчилж байсан байна. Газар өмчилсний дараа тусгай зөвшөөрөл олгосон нь АМГТГ-ын бусад байгууллагатай мэдээлэл солилцоогүй буруутай үйлдлээс болсон гэж үзэж болно.

2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс хойш буюу ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосноос хойш 2016 онд Говьсүмбэр аймгийн Шивээговь суманд 239 иргэнд, 2017 онд Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд 591 иргэнд газар өмчлүүлсэн нь ГЗБГЗЗЕГ, Говьсүмбэр аймгийн Засаг дарга болон АМГТГ-ын хариуцлагагүй үйл ажиллагаатай холбоотой юм.

Сэдвийн дүгнэлт

Хяналт шалгалтаас харахад дараах зөрчил, дутагдал илэрч байна. Үүнд:

- ▶ Төрийн байгууллагуудын хууль тогтоомж мөрдөөгүй хариуцлагагүй үйл ажиллагаанаас болж 3245 иргэний газар өмчлөх эрх зөрчигдсөн.
- ▶ Байгууллага хооронд мэдээлэл солилцох хамтын ажиллагаа хангалтгүй.

Ингэснээр Монгол Улсын Үндсэн хууль зөрчигдөхөөс гадна Газрын хэвлийн тухай хуулийн 20.3, Газрын тухай хуулийн 31.3, Ашигт малтмалын тухай хуулийн 14.1, 24.4.2, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 6.1.1 дэх хэсэг, заалтууд зөрчигдөж байна.

Санал, зөвлөмж

Монгол Улсын Үндсэн хууль, Газрын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газартай давхцуулан ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгосон асуудлыг шуурхай шалгаж, холбогдох шийдвэрийг хүчингүй болгох арга хэмжээг авч, хууль бус шийдвэр гаргасан албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайн улсын тусгай хэрэгцээний болон хуулиар хориглосон бусад газартай давхцалтай байдал

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн нэг дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.”, хоёр дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн.” гэж тус тус заасан.

Улсын тусгай хэрэгцээний болон хуулиар хориглосон бусад газрыг ашигт малтмал хайх, олборлох үед хэрхэн хамгаалах, хадгалах, хориглох тухай зохицуулалтыг дараах хуулиудад тодорхой заасан байна. Үүнд:

1. Газрын хэвлийн тухай хууль:
 - 20 дугаар зүйл. Газрын хэвлийг ашиглагчийн үндсэн эрх, үүрэг
 2. Газрын хэвлийг ашиглагч нь дор дурдсан шаардлагыг хангах үүрэгтэй:
 - 3/газрын хэвлийг ашиглахад үүсэж болзошгүй хортой нөлөөнөөс хий мандлын агаар, газар, ой, ус, рашаан, мал ан амьтан, байгаль орчны бусад объект, барилга байгууламжийг найдвартай хамгаалах, түүнчлэн тусгай хамгаалалттай газар, байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалтыг хангах.
2. Газрын тухай хууль:
 - 31.3. Хүсэлт гаргасан газар нь бусдын эзэмшиж, ашиглаж байгаа газартай ямар нэг хэмжээгээр давхцаагүй байна.
 - 50.1. Газар эзэмшигч, ашиглагч нь газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах талаар дараах шаардлагыг биелүүлнэ:
 - 50.1.4. ойн төгөл, ховор, ховордсон амьтан, ургамал, түүх, соёлын дурсгалт зүйл бүхий газрыг хамгаалах;
 - 50.1.5. бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газарт байгаль орчинд сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаа явуулахгүй байх.
3. Ашигт малтмалын тухай хууль:
 - 5.2. Төр өмчлөгчийн хувьд энэ хуульд заасан нөхцөл, шаардлага, журмын дагуу ашигт малтмал эрэх, хайх, ашиглах эрхийг бусад этгээдэд олгох эрхтэй.
 - 24.4.2. тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон, түүнчлэн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайтай давхцаагүй.
4. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль:
 - 12 дугаар зүйл. Дархан цаазат газарт хориглох үйл ажиллагаа

Дархан цаазат газарт энэ хуулийн 10,11 дүгээр зүйлд зааснаас өөр зориулалтаар дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

 - 1/газар хагалах, ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, геологийн судалгаа хийх, металл хайгч, химийн хорт болон тэсрэх бодис авч явах, ашиглах, элс, хайрга чулуу авах, мод, зэгс, шагшуурга бэлтгэх, хязгаарлалтын бүсээс бусад газарт зам тавих зэргээр байгалийн төлөв байдлыг өөрчлөх;
 - 6/ хөрс, ус, агаар бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулах;
 - 10/ нуур, мөрөн, гол горхи, булаг, шанд зэрэг ил задгай усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах.

5. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль: 4 дүгээр зүйл. Ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох
- 4.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглоно.
- 4.2. Энэ хуулийн 4.1 дэх хэсэг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамаарахгүй.
- 4.3. Энэ хуулийн 4.1-д заасан газрын хилийн заагийг Засгийн газар тогтооно.
- 4.5. Энэ хуулийн 4.1-д заасан газарт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохгүй.

6. Усны тухай хууль

- 22.1. Усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, үер, усны гамшгаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эх үүсвэрт онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс тогтооно.
- 22.2. Усны сан бүхий газрын эргээс 50 метрээс доошгүй зайд болон гол мөрний татамд онцгой хамгаалалтын бүс тогтооно.
- 22.2.1. онцгой хамгаалалтын бүсэд барилга, байгууламж барих, газар хагалах, тэсэлгээ хийх, газар тариалан эрхлэх, ашигт малтмал хайх, олборлох, зэгс, шагшуурга, мод огтлох, элс, хайрга, чулуу авах, байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх, мал угаах болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулахыг хориглоно.

Дээрх хуулиудад Улсын тусгай хэрэгцээний болон хуулиар хориглосон бусад газарт ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагаа явуулахыг хориглодог байна.

Иймээс УИХ-ын хяналт шалгалтын түр хорооноос БОАЖЯ, ГЗБГЗЗЕГ, АМГТГ-т УИХ-16/3273, УИХ-16/3286, УИХ-16/3285 дугаар албан бичгийг хүргүүлж нотлох баримтыг гаргуулан авав.

Нотлох баримтаар ирүүлсэн албан бичгийн мэдээлэл

Дд	Байгууллагын нэр	Гарын үсэг зурсан албан тушаалтан	Албан бичгийн, огноо, дугаар	Хуудасны тоо
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Сайд Б.Бат-Эрдэнэ	2024.05.10 01/2240	1, Хавсралт 38 хуудас
2	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар	Дарга А.Энхманлай	2024.05.10 1/1207	1, Хавсралт 33 хуудас
3	Ашигт малтмал, газрын тосны газар	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Баярмандал	2024.05.02 1/2003	1, Хавсралт 1 CD

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайн улсын тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалтай байдал

Дүд	Тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалтай байдлын судалгаа	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар	Ашигт малтмал, газрын тосны газар
1	Давхцалтай тусгай хамгаалалттай газрын тоо	9	7	45
2	Давхцалтай ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн тоо	22	19	40
3	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан талбайн хэмжээ /га\	21,034.48	8,679.02	47,133.69
4	Давхцалтай хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн тоо	7	0	1
5	Хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан талбайн хэмжээ /га\	29,354.58	0	2.73

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайн улсын тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалтай байдал

Дүд	Аймаг, нийслэлийн нэр	Тусгай хамгаалалттай газрын нэр	Давхцалтай ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн нэр	Давхацсан талбайн хэмжээ /га/
1	Дундговь	Их газрын чулуу	Хонгор овоо	588.40
2			Гурвансайхан	2,440.16
3	Булган	Зэд хантай бүтээлийн нуруу	Хандгайт	1,768.71
4			Тарвагатайн гол	89.85
5			Хандгайт	258.20
6	Хөвсгөл	Тэнгис-Шишгэдийн голын ай сав	Тэнгэс гол	47.39
7	Хэнтий	Тосон хулстай	Салхит	51.42
8			Тохой булаг	218.61
9			Салхит-Уул	25.18
10	Баян-Өлгий	Чигэртэйн голын ай сав	Бураат	352.99
11	Архангай	Хангайн нуруу	Өлзийт тээл	2.60
12	Сэлэнгэ	Ноён уул	Билүүт	127.05
13			Булагийн -Ам	7.87
14			Эрээн	50.54
15			Баавгайт	50.60
16			Ноён уулын ам	189.30
17			Зуун модны гол	998.68
18			Зуун модны гол-1	812.75
19			Эрээн гол	598.72
НИЙТ ДАВХАЦСАН ТАЛБАЙН ХЭМЖЭЭ				8,679.02

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайн гол, мөрний урсац бүрэлдэх эхийн заагтай давхцалтай байдал

Д/д	Гол, мөрний урсац бүрэлдэх эхтэй давхцалтай тусгай зөвшөөрлийн судалгаа	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар	Ашигт малтмал, газрын тосны газар
1	Давхцалтай ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн тоо	67		26
2	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан талбайн хэмжээ \га\	19,155.12		5,743.5
3	Давхцалтай хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн тоо	1		1
4	Хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан талбайн хэмжээ \га\	1,577.94		1,577.62

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайн ойн сан бүхий газартай давхцалтай байдал

Д/д	Ойн сан бүхий газартай давхцалтай тусгай зөвшөөрлийн судалгаа	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар	Ашигт малтмал, газрын тосны газар
1	Давхцалтай ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн тоо	144	182	116
2	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан талбайн хэмжээ \га\	42,269.39	68,514.79	36,167.4
3	Давхцалтай хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн тоо	10	107	10
4	Хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан талбайн хэмжээ \га\	60,402.80	153,015.74	60,401.98

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайн усны сан бүхий газрын хамгаалалтын бүстэй давхцалтай байдал

Д/д	Усны сан бүхий газрын хамгаалалтын бүстэй давхцалтай тусгай зөвшөөрлийн судалгаа	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар	Ашигт малтмал, газрын тосны газар
1	Давхцалтай ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн тоо	177	312	175
2	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан талбайн хэмжээ \га\	15,222.44	8,679.02	16,937.7
3	Давхцалтай хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн тоо	28	301	26
4	Хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан талбайн хэмжээ \га\	8,245.46	4,981.29	8,150.84

Сэдвийн дүгнэлт

Хяналт шалгалтаас харахад дараах зөрчил, дутагдал илэрч байна. Үүнд:

- ▶ Төрийн байгууллагуудын ашиглаж буй ижил төрлийн мэдээллүүд орон зайн хувьд маш их хэмжээгээр зөрүүтэй.
- ▶ Байгууллага хооронд мэдээлэл солилцох хамтын ажиллагаа хангалтгүй.
- ▶ Хууль тогтоомж мөрдөхгүй.
- ▶ Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон түүний харьяа байгууллагуудаас Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт болон Ашигт малтмал, газрын тосны газарт Ашигт малтмалын тухай хуулийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу мэдээллээ ирүүлдэггүй.

Ингэснээр Монгол Улсын Үндсэн хуулиас гадна Газрын хэвлийн тухай хуулийн 20.2.3, Газрын тухай хуулийн 31.3, Ашигт малтмалын тухай хуулийн 14.1, 24.4.2, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 12.1, 18.1, 21.2, 24.2, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 4.1, 4.5, Усны тухай хуулийн 22.2.1 дэх заалт, хэсгүүд зөрчигдөж байна.

Санал, зөвлөмж

Хамгаалалтын бүс тогтоосон гол, мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газар, усны сан бүхий газар, улсын тусгай хамгаалалттай газар нь ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан асуудлыг судалж, төрийн байгууллагын мэдээлэл зөрүүтэй байгаад дүгнэлт хийж, мэдээллийн сан хоорондын уялдааг хангах, газрын нэгдмэл сангийн удирдлагын цахим системтэй холбох арга хэмжээг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан зохион байгуулахыг Засгийн газарт даалгасан УИХ-ын тогтоол гаргах.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан байдал

Монгол Улсын Үндсэн хуулийн Долдугаар зүйлийн нэг дэх хэсэгт “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна.” гэж заасан байдаг.

Түүх, соёлын дурсгалт газар¹ гэдэг нь унаган газартаа хүрээлэн байгаа орчны хамт үнэ цэнэ, ач холбогдол нь илэрхийлэгдэх дангаар болон цогцолбор байдлаар орших, тодорхой орон зайд шилжүүлэн байрлуулах боломжгүй үл хөдлөх дурсгал бүхий газар, түүний хэвлийг хэлдэг.

Түүх, соёлын дурсгалт газрыг ашигт малтмал хайх, олборлох үед хэрхэн хамгаалах, хадгалах, хориглох тухай зохицуулалтыг дараах хуулиудад тодорхой заасан байна. Үүнд:

1. Газрын хэвлийн тухай хууль:

20 дугаар зүйл. Газрын хэвлийг ашиглагчийн үндсэн эрх, үүрэг

2. Газрын хэвлийг ашиглагч нь дор дурдсан шаардлагыг хангах үүрэгтэй:

3/газрын хэвлийг ашиглахад үүсэж болзошгүй хортой нөлөөнөөс хий мандлын агаар, газар, ой, ус, рашаан, мал ан амьтан, байгаль орчны бусад объект, барилга байгууламжийг найдвартай хамгаалах,

¹ Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 3.1.3, 3.1.6

түүнчлэн тусгай хамгаалалттай газар, байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалтыг хангах;

2. Газрын тухай хууль:
 - 31.3.Хүсэлт гаргасан газар нь бусдын эзэмшиж, ашиглаж байгаа газартай ямар нэг хэмжээгээр давхцаагүй байна.
 - 34.11.Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар эзэмших хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь газар эзэмших гэрээ байгуулахаас өмнө уг газарт палеонтологи, археологи, угсаатны урьдчилсан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авсан байна.
 - 50.1.Газар эзэмшигч, ашиглагч нь газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах талаар дараах шаардлагыг биелүүлнэ:
 - 50.1.4.ойн төгөл, ховор, ховордсон амьтан, ургамал, түүх, соёлын дурсгалт зүйл бүхий газрыг хамгаалах;
3. Соёлын өвийг хамгаалах тухай хууль:
 - 38.1.Соёлын өвд хохирол учруулж болзошгүй дараах үйл ажиллагааг хориглоно:
 - 38.1.2.палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэхгүйгээр хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, тариалангийн талбай олгох, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулж газар олгох;
 - 43.1.Хамгаалалтын бүсэд энэ хуулийн 38.1-д зааснаас гадна доор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно:
 - 43.1.2.ашигт малтмал эрэх, хайх, ашиглах;
 - 44.1.Орчны бүсэд энэ хуулийн 38.1-д зааснаас гадна доор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно:
 - 44.1.1.ашигт малтмал эрэх, хайх, ашиглах;
 - 45.3.Түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүсэд энэ хуулийн 38.1-д зааснаас гадна доор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно:
 - 45.3.6.ашигт малтмал эрэх, хайх, ашиглах;
4. Ашигт малтмалын тухай хууль:
 - 5.2.Төр өмчлөгчийн хувьд энэ хуульд заасан нөхцөл, шаардлага, журмын дагуу ашигт малтмал эрэх, хайх, ашиглах эрхийг бусад этгээдэд олгох эрхтэй.
 - 24.4.2.тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон, түүнчлэн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайтай давхцаагүй;
 - 40¹.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж болон энэ хуулийн 40², 46 дугаар зүйлд заасан үүргийг биелүүлнэ.
 - 40¹.2.Ашигт малтмалын хайгуул хийхдээ палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авахгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно.
 - 40².1.2.ашигт малтмал эрэх, хайх явцад олж илрүүлсэн соёлын өвийн бүрэн бүтэн байдлыг хангаж, хуульд заасны дагуу соёлын өвийн

бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх ба тухайн өвийг холбогдох байгууллагад хадгалуулахаар шилжүүлэх үүрэг хүлээнэ.

41.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна.

5. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль:

24 дүгээр зүйл. Дурсгалт газрын дэглэм

2. Дурсгалт газар дахь байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлээс О,1-3,0 км-ийн орчимд сүр бараа, үзэмжийг нь дарах барилга байгууламж барих, газар хагалах, ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлийг хөндөх, эвдэх, буулгах, тэдгээрт хохирол учруулахуйц бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Дээрх хуулиудад түүх, соёлын дурсгалт газар болон түүний хамгаалалтын, орчны бүсэд ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагаа явуулахыг хориглодог байна.


Иймээс УИХ-ын хяналт шалгалтын түр хорооноос Соёлын яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар руу УИХ-16/3287, УИХ-16/3286, УИХ-16/3285 дугаар албан бичгийг хүргүүлж нотлох баримтыг гаргуулан авав. Ирүүлсэн албан бичгийн огноо, дугаар гарын үсэг зурсан албан тушаалтан, хавсралт хуудасны тоог Хүснэгт 1.2.3.1-д харуулав.

Төрийн байгууллагуудаас нотлох баримт ирүүлсэн албан бичгийн мэдээлэл

Д\д	Байгууллагын нэр	Гарын үсэг зурсан албан тушаалтан	Албан бичгийн, огноо, дугаар	Хавсралт хуудасны тоо
1	Соёлын яам	Дэд сайд П.Баттөр	2024.05.14 2/1348	Хавсралт 41 хуудас
2	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар	Дарга А.Энхманлай	2024.05.10 1/1207	Хавсралт 33 хуудас
3	Ашигт малтмал, газрын тосны газар	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Баярмандал	2024.05.02 1/2003	Хавсралт 1 CD

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас ирүүлсэн нотлох баримтад 53 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайтай давхцалтай 97 түүх, соёлын дурсгалт газар, хайгуулын 115 тусгай зөвшөөрөлтэй давхцалтай 263 түүх, соёлын дурсгалт газар байна.

Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй газартай давхцаж буй түүх, соёлын дурсгалт газрын байршил



Монгол улс Дэлхийн өвийн конвенцод 1990 онд нэгдэн орж 1996 онд анх Дэлхийн өвд бүртгүүлж болох Монголын байгалийн болон соёлын өвийн Урьдчилсан жагсаалтыг боловсруулж, Дэлхийн өвийн төвд хүргүүлж байжээ.

Монгол улсаас Дэлхийн өвийн жагсаалтад дараах таван өв бүртгэгдсэн байна. Үүнд:

Байгалийн ангиллаар:

- Увс нуурын ай сав газар (2003 он)
- Дагуурын ландшафт (2017 он)

Соёлын ангиллаар:

- Орхоны хөндийн соёлын дурсгалт газар (2004 он)
- Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор (2011 он)
- Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг (2015 он)

2006-2008 онд ЮНЕСКО-ийн Оролцох хөтөлбөрийн хүрээнд Монголын Соёлын өвийн төвтэй хамтран “Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл мэдээллийн санг сайжруулах нь” төсөл хэрэгжүүлж, хээрийн судалгааны мэргэжлийн баг 6800 км зам туулж, 55 дурсгалт газрын 1000 гаруй дурсгалт зүйлийн бүртгэл судалгаа, мэдээллийг стандартын дагуу шинэчлэн, 27 дурсгалыг шинээр бүртгэжээ.

Монгол Улсын Их Хурал 1994 онд Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль, 2001 онд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийг тус тус баталж 2014 онд шинэчлэн найруулсан байна. Энэ хуулийн 13.1.12 дахь заалтад түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон дурсгалт газарт хамгаалалтын бүс тогтоох, өөрчлөх, цуцлах асуудлыг Засгийн газрын бүрэн эрхэд тусгасан байна.

Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 13 дугаар тогтоолоор "Улсын хамгаалалтын зэрэглэлд байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт"-ыг баталсан. Энэхүү тогтоолд 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 179 дүгээр тогтоолоор 10 аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт 18 түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрыг нэмж, 3 дурсгалт газрыг хассан, Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын

28-ны өдрийн 65 дугаар тогтоолоор 10 аймгийн нутаг дэвсгэрт хамаарах 12 түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрыг жагсаалтад нэмсэн. Засгийн газрын 3 удаагийн тогтоолоор 21 аймаг, нийслэлийн хэмжээнд нийт 194 түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын жагсаалтыг баталсан байна.

Засгийн газрын тогтоолоор баталсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газар

Дд	Аймаг, нийслэлийн нэр	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоо	Дд	Аймаг, нийслэлийн нэр	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоо
1	Архангай	22	12	Орхон	1
2	Баян-Өлгий	16	13	Өвөрхангай	14
3	Баянхонгор	12	14	Өмнөговь	13
4	Булган	12	15	Сүхбаатар	8
5	Говь-Алтай	11	16	Сэлэнгэ	3
6	Говьсүмбэр	1	17	Төв	18
7	Дархан-Уул	1	18	Увс	7
8	Дорноговь	6	19	Ховд	10
9	Дорнод	3	20	Хөвсгөл	9
10	Дундговь	6	21	Хэнтий	1
11	Завхан	6	22	Улаанбаатар	14

Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 179 дүгээр тогтоолын 4 дэх хэсэгт “Жагсаалтад орсон түүх, соёлын үл хөдлөх дурсгалын эх төрх, бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хадгалах зорилгоор хамгаалалтын бүс тогтоох, мэдээллийн санд оруулан бүртгэлжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэхийг Соёлын сайд Ч.Номинд даалгасан” байна.

Соёлын яамнаас ирүүлсэн нотлох баримтаар 8 түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын байршил нь ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан зөрчлийн талаарх мэдээллийг ирүүлсэн.

ШУА-ийн Археологийн хүрээлэнгээс ирүүлсэн судалгаагаар нийт 20 түүх, соёлын дурсгалт газрын 6 нь утсан, 6 нь дам эрсдэл учруулсан, 8 нь нөлөөллийн бүсэд орсон байна.

Соёлын өвийн үндэсний төвийн бүртгэл, мэдээллээр улсын хамгаалалтад буй 8 түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газар ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан байна.

Улсын хамгаалалтад буй 8 түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын мэдээлэл

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын талаах мэдээлэл							Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын талбайн мэдээлэл			
№	Аймаг	Сум	Дурсгалт газрын нэр	Дурсгалын төрөл	Хамгаалалтын зэрэглэл	Соёлын өвийн улсын бүртгэлийн дугаар	Эзэмшигч	Нэр	Төрөл	Талбайн дугаар
1	Төв	Өндөрширээт	Уянгын үзүүрийн хадны зураг	Хадны зураг, бичгийн дурсгал	Улсын хамгаалалтад	416100262	Говькар аван	Хавцал уул	Хайгуулын тусгай зөвшөөрөл	XV-021849
2	Баянхонгор	Баянлиг	Лигийн цагаан агуй	Чулуун зэвсгийн дурсгалт газар	Улсын хамгаалалтад	641300021	Люкс минерал	Хөх овоо	Хайгуулын тусгай зөвшөөрөл	XV-022568

3	Хэнтий	Баянхутаг	Сэрвэн хаалганы бичээс	Хадны зураг бичгийн дурсгал	Улсын хамгаалалт ад	31900072	Дунгоул д	Баянхутаг	Хайгуулын тусгай зөвшөөрөл	XV-019217
4	Баян-Өлгий	Цэнгэл	Цагаан голын цогцолбор дурсгал	Хөшөө дурсгал	Улсын хамгаалалт ад	833702056	Түгэл өргөө	Цагаан гол	Хайгуулын тусгай зөвшөөрөл	XV-022586
5	Өвөрхангай	Баруунбаян-Улаан	Андай сайр палеонтологийн дурсгалт газар	Палеонтологийн дурсгалт газар	Улсын хамгаалалт ад	620400198	Азаргын гол чонот	Цагаан жалга-4	Хайгуулын тусгай зөвшөөрөл	XV-020916
6	Өвөрхангай	Гучин-Ус	Паалуугийн хадны зураг	Хадны зураг, бичгийн дурсгал	Улсын хамгаалалт ад	622200062	Говькар аван	Дэрсэн худаг	Хайгуулын тусгай зөвшөөрөл	XV-021817
7	Дархан-Уул	Хонгор	Хүйтэний голын хадны зураг бичээс	Хадны зураг, бичгийн дурсгал	Улсын хамгаалалт ад	450700202	Бичигт хад майнинг	Бичигт хад	Ашиглалтын талбай	MV-014989
8	Баян-Өлгий	Улаанхус	Бага Ойгорын хадны зураг	Хадны зураг, бичгийн дурсгал	Улсын хамгаалалт ад	833402462	Кавернболд	Улаанхус	Ашиглалтын талбай	MV-011864

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.1.2 дахь заалтаар “палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэхгүйгээр ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах үйл ажиллагаа явуулахад зориулж газар олгох”-ыг хориглосон байдаг.

Ашигт малтмалын тухай хуулийн 40¹, 40² дугаар зүйлд заасны дагуу соёлын өвийг хамгаалах үүргээ хэрэгжүүлж ажилласан тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл болон хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх сүүлийн 3 жилийн мэдээллийг авч үзэхэд 2021 онд 190 хайгуул судалгаа, 5 малтлага судалгаа, 2022 онд 237 хайгуул судалгаа, 9 малтлага судалгаа, 2023 онд 234 хайгуул судалгаа, 10 малтлага судалгааг 10 мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн байна.

2021-2023 онд хэрэгжүүлсэн археологи, палеонтологийн авран хамгаалах хайгуул, малтлага судалгаа


Дд	Судалгаа хийсэн байгууллагын нэр	2021 он		2022 он		2023 он	
		Хайгуул судалгаа	Малтлага судалгаа	Хайгуул судалгаа	Малтлага судалгаа	Хайгуул судалгаа	Малтлага судалгаа
1	ШУА-ийн Археологийн хүрээлэн	40	5	56	3	36	3
2	ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн	6			2		1
3	Улаанбаатарын их сургууль	3		22	1		
4	МУИС-ийн Археологийн судалгааны төв			22	1	37	
5	МУИС-ийн Шинжлэх ухаан, технологийн Улаанбаатар парк					21	
6	Монголын үндэсний музей	4	1			5	
7	МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн антропологи, археологийн тэнхим	11					

8	ШУТИС-ийн Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургууль	11		21	2	9	5
9	ШУА-ийн Палеонтологийн хүрээлэн	115	1	108		113	1
10	ШУТИС, Стратиграфи-палеонтологийн судалгааны төв			8		13	
Бүгд		190	7	237	9	234	10


Соёлын өвийн үндэсний төвөөс ирүүлсэн, хамгаалалтын бүс тогтоосон 10 түүх, соёлын дурсгалт газрын орон зайн мэдээллийн санг Ашигт малтмал, газрын тосны газраас түр хороонд ирүүлсэн орон зайн мэдээллийн санг (2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар) ArcGIS программ дээр давхцуулан шалгаж үзэхэд 9 түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүс ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайтай тодорхой хэмжээгээр давхцаж байгааг, ArcGIS программ дээр давхцалыг харуулсан зураг болон дурсгалт газрын фото зургийг харуулав.

Түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүс ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайтай давхцаж буй байдал



Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын талаах мэдээлэл							Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын талбайн мэдээлэл			
№	Аймаг	Сум	Дурсгалт газрын нэр	Дурсгалын төрөл	Хамгаалалтын зэрэглэл	Соёлын өвийн улсын бүртгэлийн огноо	Эзэмшигч	Нэр	Төрөл	АМ-ын ТЗ олгосон огноо
1	Төв	Өндөрширэт	Уянгын үзүүрийн хадны зураг	Хадны зураг, бичгийн дурсгал	Улсын хамгаалалтад	2020.01.08	Говькараван	Хавцал уул	Хайгуулын ТЗ	2021.07.19
2	Баянхонгор	Баянлиг	Лигийн цагаан агуй	Чулуун зэвсгийн дурсгалт газар	Улсын хамгаалалтад	2020.01.08	Люкс минерал	Хөх овоо	Хайгуулын ТЗ	2023.10.31
3	Хэнтий	Баянхутаг	Сэрвэн хаалганы бичээс	Хадны зураг бичгийн дурсгал	Улсын хамгаалалтад	2020.01.08	Дунгоулд	Баянхутаг	Хайгуулын ТЗ	2016.04.27
4	Баян-Өлгий	Цэнгэл	Цагаан голын цогцолбор дурсгал	Хөшөө дурсгал	Улсын хамгаалалтад	2020.01.08	Түгэл өргөө	Цагаан гол	Хайгуулын ТЗ	2023.10.31
5	Өвөрхангай	Баруунбаян-Улаан	Андай сайр палеонтологийн дурсгалт газар	Палеонтологийн дурсгалт газар	Улсын хамгаалалтад	2020.01.08	Азаргын гол чонот	Цагаан жалга-4	Хайгуулын ТЗ	2017.09.15
6	Өвөрхангай	Гучин-Ус	Паалуугийн хадны зураг	Хадны зураг, бичгийн дурсгал	Улсын хамгаалалтад	2021.06.30	Говькараван	Дэрсэн худаг	Хайгуулын ТЗ	2021.07.02
7	Дархан-Уул	Хонгор	Хүйтэний голын хадны зураг бичээс	Хадны зураг, бичгийн дурсгал	Улсын хамгаалалтад	2020.01.08	Бичигт хад майнинг	Бичигт хад	Ашиглалтын ТЗ	2009.07.09
8	Баян-Өлгий	Улаанхус	Бага Ойгорын хадны зураг	Хадны зураг, бичгийн дурсгал	Улсын хамгаалалтад	2020.01.08	Кавернболд	Улаанхус	Ашиглалтын ТЗ	2006.07.17
9	Хэнтий	Цэнхэрмандал	Цэнхэрмандалын бичээс	Хадны зураг, бичгийн дурсгал	Улсын хамгаалалтад	2024.02.28	Экс Ай Эн	Бургастай-1	Ашиглалтын ТЗ	2019.05.15



Төв аймгийн Өндөрширээт сумын нутагт байрлах “Уянгын үзүүрийн хадны зураг” түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан байдал




Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутагт байрлах “Лигийн цагаан агуй” зураг түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан байдал




Хэнтий аймгийн Баянхутаг сумын нутагт байрлах “Сэрвэн хаалганы бичээс” түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан байдал





Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутагт байрлах “Цагаан голын цогцолбор дурсгал” түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан байдал





Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын нутагт байрлах “Андай сайр палеонтологийн дурсгалт газар” түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан байдал



Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумын нутагт байрлах “Паалуугийн хадны зураг” түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан байдал



Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт байрлах “Хүйтэний голын хадны зураг бичээс” түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газар ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан байдал



Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын нутагт байрлах “Цэнхэрмандалын бичээс” түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газар ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан байдал



Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутагт байрлах “Бага Ойгорын хадны зураг” түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газар 2006 онд гянтболд олборлох зориулалтаар олгосон ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан байдал

Монгол улсаас Дэлхийн өвийн жагсаалтад 5 өв бүртгэгдсэний дотор Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор 2011 онд бүртгэгджээ. “Бага Ойгорын хадны зураг” түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газар нь Монгол Алтайн нурууны хадны зургийн 3 цогцолборын нэг юм.



Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолборын байршил \3 хэсгээс бүрдэнэ\



“Бага Ойгорын хадны зураг” нь 10000 гаруй сүг зураг 15 км газар нутагт үргэлжлэн тархсан байна.

Түүх, соёлын дурсгалт 9 газартай давхцуулан ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход дараах зөрчил илрэв. Үүнд:

1. “Уянгын үзүүрийн хадны зураг”-ийг 2020 оны 1 сард Засгийн газар Улсын хамгаалалтын зэрэглэлтэй дурсгалт газрын бүртгэлд бүртгэсэн байтал 2021 оны 7 дугаар сард хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон байна.


2. “Лигийн цагаан агуй”-г 2020 оны 1 сард Засгийн газар Улсын хамгаалалтын зэрэглэлтэй дурсгалт газрын бүртгэлд бүртгэсэн байтал 2023 оны 10 дугаар сард хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон байна.

3. “Цагаан голын цогцолбор дурсгал”-ыг 2020 оны 1 сард Засгийн газар Улсын хамгаалалтын зэрэглэлтэй дурсгалт газрын бүртгэлд бүртгэсэн байтал 2023 оны 10 дугаар сард хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон байна.

4. “Паалуугийн хадны зураг”-ийг 2021 оны 6 сард Засгийн газар Улсын хамгаалалтын зэрэглэлтэй дурсгалт газрын бүртгэлд бүртгэсэн байтал 2021 оны 7 дугаар сард хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон байна.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээллийн санд “Бага Ойгорын хадны зураг” түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрыг хамгаалалтын бүсээр бүртгэсэн нь тусгай зөвшөөрлийн талбайтай давхцалгүй мэт харагдаж байна. Соёлын өвийг хамгаалах тухай хуулиар хамгаалалтын болон орчны бүсэд ашигт малтмал хайх, олборлохыг хориглодог.

Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутагт байрлах “Бага Ойгорын хадны зураг” /2011 онд Дэлхийн өвд бүртгэгдсэн/ түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газар ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайд бүртгэгдсэн байдал



Сэдвийн дүгнэлт

Хяналт шалгалтаас харахад дараах зөрчил, дутагдал илэрч байна. Үүнд:

1. Хууль тогтоомж мөрдөхгүйгээс түүх, соёлын дурсгалт 6 газар устсан.
2. Байгууллага хооронд мэдээлэл солилцох хамтын ажиллагаа хангалтгүй.
3. Төрийн байгууллагуудын ашиглаж буй ижил төрлийн мэдээллүүд орон зайн хувьд маш их хэмжээгээр зөрүүтэй.
4. Ашигт малтмалын тухай хуулийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу түүх, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв, төрийн захиргааны байгууллагуудаас улсын хамгаалалтад авсан мэдээллийг ирүүлдэггүй.
5. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын хамгаалалтын бүс болон орчны бүсийг солбицолжуулсан мэдээллийг холбогдох төрийн байгууллагууд руу тогтмол хүргүүлдэггүй.

Ингэснээр Монгол Улсын Үндсэн хууль зөрчигдөхөөс гадна Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.1.2, 43.1.2, 44.1.1, 45.3.6, Газрын хэвлийн тухай хуулийн 20.2.3, Газрын тухай хуулийн 31.3, 34.11, 50.1.4, Ашигт малтмалын тухай хуулийн 14.1, 24.4.2, 40¹.1, 40¹.2, 41.1, Газар өмчлүүлэх тухай хуулийн 6.1.1, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 12.1, 18.1, 21.2, 24.2 хэсэг, заалтууд зөрчигдөж байна.

Санал, зөвлөмж

Монгол Улсын Үндсэн хуулийн Долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна.” гэж заасны дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайтай давхацсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрыг хамгаалалтад авч, бүртгэлийг сайжруулах үүргийг Засгийн газарт даалгахаар УИХ-ын тогтоолын төсөл боловсруулах.

1.3.Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөн

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл шилжүүлэхтэй холбоотой дараах журам, аргачлал хэрэгжиж байсан.

Хуулийн үндэслэл	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 16.14	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 30.6
Тушаал	2017 оноос өмнө	Сангийн сайдын 2017 оны 380 дугаар тушаал	Сангийн сайдын 2019 оны 302 дугаар тушаал
Аргачлал	Татварын ногдлыг шууд бус аргаар тооцох аргачлал	•Гэрээний үнээр тооцох •Хайгуулын ажлын зардлаар тооцох •Харьцуулалтын шалгуур үзүүлэлтээр үнэлэх	•Зардалд суурилсан арга •Орлогод суурилсан арга •Гэрээний үнийн арга
Өөрчлөх шаардлага	30% тооцож байсан. Тусгай аргачлал байгаагүй.	Татвар тооцох аргачлалтай болсон. 30% тооцож байсан.	Аргачлалыг нарийвчлах 10% тооцдог болсон.

2020 оноос өмнө Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл шилжүүлэхдээ талбайн үнэлгээний 30%-иар татвар тооцож байсан бөгөөд 2020 оноос 10% болгон бууруулснаар тусгай зөвшөөрөл шилжүүлэх үйл явц идэвхэжсэн байдаг.

Мөн Сангийн сайдын 2017 оны 380 дугаар тушаал, 2019 оны 302 дугаар тушаалаар аргачлал батлагдахаас өмнө аж ахуйн нэгжүүд ашигт малтмалын тусгай

зөвшөөрөл шилжүүлэхдээ гэрээний үнийн дүнг хэт бага буюу 1-10 сая төгрөгөөр үнэлж татвараас зайлсхийх үзэгдэл ихээхэн гарч байсан удаатай.

Одоо хүчин төгөлдөр байгаа аргачлалыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 30.6-д заасны дагуу Сангийн сайдын 2019 оны 302 дугаар тушаалаар “Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн үнэлгээ тооцох, татварын ногдлыг тодорхойлох аргачлал, тусгай зөвшөөрөл борлуулсан, шилжүүлсний орлогод албан татвар ногдуулах журам” -аар шинэчилж баталсан.

Энэхүү журмаар Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг шилжүүлэхэд эцсийн эзэмшигчийг өөрчлөх “шууд бус шилжүүлгийн татварын дүрэм” (“ШБШТД”) үйлчилж байна.

Хайгуулын тусгай зөвшөөрлийг шилжүүлэхдээ:

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь бусдад шилжүүлсэн тохиолдолд тусгай зөвшөөрлийн үнийг татвар төлөгчийн мэдүүлсэн гэрээг үндэслэн шилжүүлгийн татвар ногдуулж байна. Харин гэрээний үнэ нь тус аргаар тооцоолсон үнийн дүнгээс 20 ба түүнээс дээш хувиар бага байх тохиолдолд тусгай зөвшөөрлийн үнэлгээний журмаар тодорхойлно:

▶ Тусгай зөвшөөрөлтэй холбоотой нөөцийг Эрдэс баялгийн зөвлөлөөс А, В гэж ангилсан тохиолдолд орлогод суурилсан аргаар тооцно;

▶ Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хайгуулын зардал нь Ашигт малтмалын тухай хуульд заасан хайгуулын зардлын доод хэмжээнээс тухайн актад заасан хувиар хэтрээгүй тохиолдолд зах зээлийн аргаар тооцсон үнийн дүнгийн дундаж болон зардалд суурилсан аргаар тооцно;

▶ Бусад бүх тохиолдолд зардалд суурилсан аргаар тооцно.

Ашиглалтын тусгай зөвшөөрлийг шилжүүлэхдээ:

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь бусдад шилжүүлсэн тохиолдолд тусгай зөвшөөрлийн үнийг татвар төлөгчийн мэдүүлсэн гэрээг үндэслэн шилжүүлгийн татварыг ногдуулна. Харин гэрээний үнэ нь төслийн ТЭЗҮ-д тусгагдсан орлогоос 20 ба түүнээс дээш хувиар бага байвал орлогод суурилсан аргыг хэрэглэнэ. Орлогод суурилсан аргыг хэрэглэх боломжгүй тохиолдолд зардалд суурилсан аргыг хэрэглэнэ.

1997-2022 оны хооронд ашигт малтмалын хайгуулын 13911 тусгай зөвшөөрөл олгосон ба үүний 2 орчим хувь нь ашиглалтын тусгай зөвшөөрөл болж, өөрөөр хэлбэл дунджаар 50 хайгуулын тусгай зөвшөөрлөөс зөвхөн 1 тусгай зөвшөөрлийн талбайд нөөц тогтоогдож олборлолтод шилжсэн нь геологи-хайгуулын ажил нь өндөр эрсдэлтэй бөгөөд хайгуул хийгдсэн талбай болгон орд болж уул уурхай үйлдвэрлэл болдоггүйг харуулна.

Хайгуулын ажлыг амжилттай явуулах гол хөшүүргүүдийн нэг нь тухайн талбайд хөрөнгө оруулалтыг оновчтой явуулах баг ажиллахтай шууд холбоотой байдаг. Тийм учраас Монголд төдийгүй дэлхий дахинд хайгуулын чиглэлээр мэргэшсэн аж ахуйн нэгжүүд хайгуулын тусгай зөвшөөрлийг нэгээс нөгөөд шилжүүлж, инженер техникийн баг өөр өөрийн төлөвлөлтөөр геологи, хайгуулын

ажлыг оновчилж, ирээдүйд үнэ цэн бүхий төслийг бойжуулдаг. Энэ салбарын онцлог нь хайгуул хийсэн баг, төслийг олборлолтод бэлтгэсэн баг, олборлох баг ихэнх тохиолдолд өөр өөр байдагт оршин ба энэ шилжих хөдөлгөөнийг уян хатан зохицуулах нь салбарын ирээдүйтэй хамааралтай байдаг.

2015 оноос хойш тусгай зөвшөөрлөө шилжүүлсэн байдал

№		ТЗ Төрөл	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022.10
1	Тоо	Хайгуул	42	81	68	128	50	53	51	41
2		Ашиглалт	33	28	52	19	23	25	18	11
3	Мөнгөн дүн /тэрбум.төг/	Хайгуул	0.4	0.37	0.69	1.5	1.6	0.4	1.1	2.9
4		Ашиглалт	1.1	0.5	8.3	2.3	0.6	2.3	2.1	3.5
Нийт			1.5	0.8	8.99	3.8	2.2	2.7	3.2	7.4

32	Монголиан Нейшнл Рийр Ийрт Корпорейшн	Увс	Завхан	Шар толгой	MV-011933	Ховор металл	нөөцгүй	Хайгуулын ажлын үр дүнгийн тайлангийн шинжээч томилуулж ажиллаж байгаа тухайгаа албан бичгээр ирүүлсэн ч өнөөдрийг хүртэл нөөц бүртгүүлээгүй байна.
33	Кормонмайн хаус	Сэлэнгэ	Мандал	Алтат	MV-011950	Алт шороо	нөөцгүй	Хөрөнгө оруулалт тодорхойгүй

								хугацаагаар хойшилсон тул хайгуулын ажил удааширч байгаа.
34	Бороогоул д	Сэлэнгэ	Мандал	Их даширын хөндий	MV-012039	Алт шороо	нөөцгүй	Энэ жил хайгуул хийхээр төлөвлөгөө батлуулсан.
35	Бугант мандал	Сэлэнгэ	Ерөө	Сангийн гол	MV-012246	Алт шороо	нөөцгүй	ЭБМЗ-ийн 2021.04.02-ны өдрийн ХХ-04-01 хурлаар нөөц оруулсан боловч урт нэртэй хуультай давхцалтай шалтгаанаар бүртгэж аваагүй байна.
36	Андын тэмүүлэл	Баянхонго р	Баян-Овоо	Гучин-сайр	MV-012717	Алт шороо	нөөц дууссан	Хайгуул хийнэ. Санхүүжилт байхгүйгээс зогсонги байдалд байна.
37	Хосхас	Булган	Бүрэгхангай	Өгөөмөр хоолой-3	MV-013205	Алт шороо	нөөц дууссан	Хайгуул хийж байгаа.
38	Ноёнгари	Төв	Баян	Ямаат худаг	MV-013678	Алт шороо	нөөц дууссан	Нэмэлт хайгуулын ажил гүйцэтгэж байгаа
39	Алтанхен дий	Дархан- Уул	Хонгор	Хуурай	MV-014686	Алт шороо	нөөц дууссан	Хайгуул хийсэн. Нөөцөө ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх гэж байгаа.
40	Түвшинтө р трейд	Төв	Сэргэлэн	Буурлын хөндийн дээд	MV-015458	Алт шороо	нөөц дуусан.	2018.06.25 18/06-01 албан тоотоор нөөц дууссан. Талбайг буцаан өгөхөөр ажиллаж байна гэсэн байна
41	Шарнарст	Булган, Сэлэнгэ	Сэлэнгэ, Түшиг	Хандгайт	MV-015465	Алт шороо	нөөц дууссан	Нөхөн сэргээлтийн ажил хийгдэж байгаа. Нөөцийн тайлан оруулсан боловч тусгай хамгаалалтад орсон гээд хэлэлцэхээс татгалзсан
42	Олз гоулд майнинг	Төв	Заамар	Туул гол	MV-015586	Алт шороо	нөөц дууссан	Хайгуул хийнэ
43	Хорикава металл	Увс	Хяргас	Шар уул	MV-015606	Алт шороо	нөөцгүй	MV-015606 тай цуг ТЭЗҮ-тэй боловч нөөцгүй
44	Эн Си Жи Ти	Говь- Алтай	Бигэр	Булаг	MV-017117	Алт шороо	нөөц дууссан	Хайгуул хийж байгаа
45	Илт хэт	Төв	Заамар	Баянголын дэнж-1	MV-017304	Алт шороо	нөөц дууссан	Хайгуул хийж байгаа
46	Тунамал шижир	Дорнод	Баяндун	Рашаантын доод хэсэг	MV-017443	Алт шороо	нөөцгүй	Хайгуул хийж байгаа
47	Илт хэт	Төв	Заамар	Баянголын дэнж-1	MV-017643	Алт шороо	нөөц дууссан	Хайгуул хийж байгаа
48	Илт хэт	Төв	Заамар	Баянголын дэнж-1	MV-017644	Алт шороо	нөөц дууссан	Хайгуул хийж байгаа
49	Эрхэсмай нинг	Төв	Заамар	Ар тамсаг-1- 3-2	MV-020391	Алт шороо	нөөцгүй	Хайгуул хийх гэж байгаа.
50	Жамп	Баянхонго р	Жаргалант	Бөөргийн ам	MV-020400	Алт шороо	нөөцгүй	Нөхөн сэргээлт хийж байгаа
51	Уулсзаам ар	Булган, Төв	Дашинчилэ н, Заамар	Урд дэлэн	MV-020427	Алт шороо	нөөц дууссан	Онцгой хамгаалалтын бүстэй давхцалтай 4.14 кг-ийн нөөц байгаа.
52	Хризопраз а групп	Сэлэнгэ	Ерөө	Сойрт	MV-020646	Алт шороо	нөөцгүй	Хайгуул хийнэ.
53	Ньюголд ен кроун	Сэлэнгэ	Ерөө	Бугантай-1	MV-020709	Алт шороо	нөөцгүй	Хайгуул хийнэ.
54	Баялагбог д	Баянхонго р	Бууцагаан	Цав уул	MV-020819	Алт шороо	нөөцгүй	Урт нэртэй хуулиар хуваагдсан талбай. Талбайд нөөц байхгүй буцааж өгнө.
55	Альтаирго улд	Төв	Сүмбэр		MV-020838	Алт /Шороо/	нөөцгүй	Хайгуул хийж нөөц оруулна
56	Гурвантам га	Төв	Заамар	Хайлааст	MV-020869	Алт шороо	нөөц дууссан	Нөхөн сэргээлт хийгдэж байгаа

57	Булган майнинг				MV-021088	Алт /Шороо/	нөөцгүй	Хайгуул хийж нөөц оруулна
58	Би Эйч Ай Би	Төв	Заамар	Туулын зүүн дэнж	MV-021089	Алт шороо	нөөц дууссан	Хайгуул хийнэ
59	Бат-Алт төв	Төв	Заамар	Баянгол	MV-021305	Алт шороо	нөөцгүй	
60	Мандах заамар майнинг	Төв	Заамар	Бор толгой	MV-021524	Алт шороо	нөөцгүй	Хайгуул хийж байгаа.
61	Бүрдэл майнинг	Төв	Заамар	Бор толгой	MV-021525	Алт шороо	нөөцгүй	Хайгуул хийж байгаа.
62	Бүрдэл майнинг	Төв	Заамар	Бор толгой	MV-021526	Алт шороо	нөөцгүй	Хайгуул хийж байгаа.
63	Бүрдэл майнинг	Төв	Заамар	Бор толгой	MV-021527	Алт шороо	нөөцгүй	Хайгуул хийж байгаа.
64	Наран тахилт	Төв	Баян	Шанд худаг	MV-000911	гантиг /мрамор/	Нөөцгүй	тодорхойгүй
65	Говьманхан	Төв	Эрдэнэ	Баруун шохойн хажуу	MV-001830	шохойн чулуу	Нөөцгүй	ШУТЗ-ын 1976.12.29-ны 76 тоот протокол, Нөөцгүй
66	Гөүлдэннэст	Булган	Орхон	Айраг уул	MV-002613	шохойн чулуу	Нөөцгүй	ШУТЗ-ын 1962.03.16-ны протокол, Нөөцийн блокийг тусгай зөвшөөрлийн талбайд буулгаж үзэх шаардлагатай, Р-280 мян.м3 /2018.10.09-ны 10/19 тоот/
67	Гөүлдэннэст	Булган	Орхон	Думбатын гол	MV-003274	шохойн чулуу	Нөөцгүй	ШУТЗ-ын 1962.03.16-ны протокол, Нөөцийн блокийг тусгай зөвшөөрлийн талбайд буулгаж үзэх шаардлагатай, Р-260 мян.м3
68	Лайм-Инвест	Сэлэнгэ	Орхон	Хөтөлийн шохой-2	MV-009470	шохойн чулуу	Нөөцгүй	2018.06.28-ны өдрийн 1861 албан тоотоор шинжээчийн үнэ хөлс дээр тохиролцоогүй, ХӨ байхгүй гэсэн тайлбар ирүүлсэн /3 сар сунгах санал ирүүлсэн/
69	Шаширтрайд	Дорноговь	Даланжаргалан	Өлзийт ухаа	MV-010258	Жонш	Нөөцгүй	Нөөцгүй
70	Тавин-Эх	Хэнтий	Галшар	Хар бичигт	MV-010714	Жонш	Нөөцгүй	2018.07.31-ний өдрийн 7/03 тоот албан бичгээр нөөцийн тайланг боловсруулах ажлыг хийж байгаа гэсэн тайлбар ирүүлсэн. 2018.07.31 -нд Банзрагч, Цогхүү нар шинжээчээр томилогдсон. Нөөцгүй.
71	Ти Эн Би	Дорноговь	Айраг	Майхант толгой	MV-016870	Жонш	Нөөцгүй	2018.08.18-ны ХХ-2018/98 шинжээч томилогдсон хуудас ирүүлсэн Нөөцгүй
72	Талст дөл баяжмал	Дорноговь	Даланжаргалан	Цахир толгод	MV-019889	Жонш	Нөөцгүй	Мэдээлэлгүй
73	Стар флюорит	Дорноговь	Даланжаргалан	Өлзийт ухаа	MV-020726	Жонш	Нөөцгүй	Хайгуул хийж байгаа.
74	Тайхар-Орд	Дундговь	Баянжаргалан	Хөх тээг	MV-020763	Жонш	Нөөцгүй	Нөөцгүй
75	ШИБА	Дархан-Уул	Хонгор	Цемент 3 орд	MV-003166	шохойн чулуу	Нөөцгүй	Нөөцгүй
76	Баялагжонш	Дорноговь	Даланжаргалан	Баруун бүс	MV-005294	Жонш	Нөөцгүй	Нөөцгүй
77	Тавин-Эх	Хэнтий	Галшар	Хар бичигт	MV-010714	Жонш	Нөөцгүй	2018.07.31-ний өдрийн 7/03 тоот албан бичгээр нөөцийн тайланг боловсруулах ажлыг хийж байгаа гэсэн

								тайлбар ирүүлсэн. 2018.07.31 -нд Банзрагч, Цогхүү нар шинжээчээр томилогдсон. Нөөцгүй.
78	Бэрх-Уул	Хэнтий	Хэрлэн	Баянхаан	MV-010965	Жонш	Нөөцгүй	Нөөцгүй
79	Ньюсинэкс	Дархан-Уул	Хонгор	Цохиот толгой 1	MV-021515	шохойн чулуу	Нөөцгүй	Нөөцгүй
80	Хүннү говь алтай	Говьалтай	Төгрөг	Хүрэнгийн талбай	MV-020611	Нүүрс	Нөөцгүй	Гол мөрний урсац бүрэлдэх эх ... хуулийн үйлчлэлтэй давхцаж байгаа хэсгийн буцаалттай холбоотой шинээр үүссэн тусгай зөвшөөрөл.
81	Төгрөгнүүрын энерги	Төв	Баян, Баянжаргалан	Тахилт-2	MV-015429	Нүүрс	Нөөцгүй	2019 онд хайгуулын ажлын үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр ажиллаж буй тухай 2018.03.19-ны 18/07 тоот албан бичиг ирүүлсэн.
82	Багануур	Улаанбаатар	Багануур	Нарийний тал	MV-013630	Нүүрс	Тодорхой бус	Уурхайн төлөвлөлтөөр уг тусгай зөвшөөрлийн талбайд хөрсний гадаад овоолго байршуулах байдлаар ашиглаж байгаа тухай 2018.07.16-ны 01/648 дугаартай албан бичиг ирүүлсэн.

Экспортод гаргаж буй уул уурхайн гаралтай бүтээгдэхүүнд гарал үүслийн гэрчилгээ олгож буй байдалд хийсэн дүн шинжилгээ

Тухайн экспортолж буй бараа бүтээгдэхүүн бүхэлдээ болон хэсэгчлэн Монгол Улсад үйлдвэрлэсэн болохыг олон улсын зах зээлд хуулийн хүрээнд баталгаажуулсан баримт бичиг юм. Үүнийг ихэвчлэн импортлох үеийн зөвшөөрөл олгох үйл явцын нэг хэсэг болгон тухайн импортлогч улсын гаалийн байгууллага шаарддаг. Гаалийн ажилтан нь тухайн гарал үүслийн гэрчилгээний үндсэн дээр татварын хувь хэмжээ, худалдааны гэрээний дагуу бараа бүтээгдэхүүнд давуу эрх эдлэхэд ашигладаг.

Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүнд **FORM B** төрлийн гарал үүслийн гэрчилгээ олгодог бөгөөд энэ гэрчилгээ нь тухайн улсын зах зээлд гаалийн тарифын хөнгөлөлт эдэлдэггүй, зөвхөн барааны гарал үүслийг тодорхойлоход ашигладаг бичиг баримт юм. Монгол улстай одоогоор худалдааны гэрээ хэлэлцээр хийгдээгүй, хөнгөлөлтөд хамруулаагүй улс орнууд ордог. Үүнд: БНХАУ, Хонг Конг, БНСУ, Энэтхэг, Тайвань, Тайланд, Малайз, Иран, Арабын орнууд, Африкийн орнууд гэх мэт.

Хууль эрх зүйн орчин

Гарал үүслийн гэрчилгээг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 6.2.3-д “энэ хуульд өөрөөр заагаагүй бол экспортын барааны гарал, үүслийг гэрчлэх” гэж заасны дагуу Монгол Улсаас экспортолж буй ашигт малтмалд гарал үүслийн гэрчилгээ олгож байна.

Мөн түүнчлэн Гаалийн тухай хуулийн 3.1.2-т "монголын бараа" гэж энэ хуулийн 99.1-д заасан горимын дагуу боловсруулалт хийснээс бусад Монгол Улсад


үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, эсхүл Монгол Улсын нутаг дэвсгэр дээр чөлөөт эргэлтэд байгаа гадаадын барааг гэж, мөн хуулийн 99.1-д “Барааг гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах горимын дагуу шаардагдах бичиг баримтыг үндэслэн гадаадын барааг боловсруулж хугацаанд нь буцаан гаргах нөхцөлөөр гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулна” гэж тус заасныг баримтлан Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн танхимаас олгож байна.

Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн танхимын ХХ Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 03 тоот тогтоолоор баталсан “Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дүрэм”-ийн 2.2.10-д “Монгол Улс, Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн худалдааны болон бусад төрөл бүрийн баримт бичиг, гэрчилгээ олгох, баталгаа, магадалгаа гаргах” гэж заасныг баримтлан МҮХАҮТ-ын гүйцэтгэх захирлын 2024 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн А/39 тоот тушаалаар баталсан “Монгол Улсаас гарал үүсэлтэй экспортын бараанд гарал үүслийн гэрчилгээ олгох, баталгаажуулах журам”-аар уг гэрчилгээг олгох ажлыг зохицуулж байна.

Нөхцөл байдал

Хууль эрх зүйн хувьд холбогдох хуульд гэрчлэх, гэрчилгээ олгох зохицуулалт нь туссан боловч журам батлах тухай эрх хуулиар Монголын Үндэсний Худалдаа, Аж үйлдвэрийн танхимд олгогдоогүй бөгөөд тус танхимын танхимын ХХ Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 03 тоот тогтоолоор баталсан “Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дүрэм”-ийн 2.3.12-д “Монголын экспортын барааны гарал үүслийн гэрчилгээ олгож, мөн гарал үүсэл тодорхойлох болон баталгаажуулах талаар холбогдох журам боловсруулан баталж, мөрдөн ажиллах” гэж заасны дагуу МҮХАҮТ-ын даргын 2006 оны 03 сарын 01-ны өдрийн 52а тоот тушаалын хавсралт 1-ээр батлагдсан **Монгол Улсаас гарал үүсэлтэй экспортын барааны гарал үүсэл тодорхойлох, гарал үүслийн гэрчилгээ олгох, баталгаажуулах журам**”, МҮХАҮТ-ын гүйцэтгэх захирлын 2024 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн А/39 тоот тушаалаар баталсан **“Монгол Улсаас гарал үүсэлтэй экспортын бараанд гарал үүслийн гэрчилгээ олгох, баталгаажуулах журам”**-аар тус тус олгож байна.

Гарал үүслийн гэрчилгээ олгож байгаа байдлыг дараах зургаар харуулав.



Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-д “Танхимын үйлчилгээний хөлсний хэмжээг танхимын саналыг үндэслэн Сангийн сайд, Худалдаа үйлдвэрийн сайд хамтран тогтооно” гэж заасан боловч уг заалтыг зөрчиж, МҮХАҮТ-ын даргын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/130 тоот “Үйлчилгээний үнийн тариф шинэчлэн батлах тухай” тушаалаар баталсан байна.

Санал: Монгол Улсын экспортолж буй ашигт малтмалд гарал үүслийг гэрчилгээг олгохдоо тухайн мэргэжлийн байгууллагаар дамжуулах олгох эрх зүйн орчныг бий болгох шаардлагатай байна.

2.2. Уул уурхайн салбарын байгаль орчны нөхөн сэргээлт, уурхайн хаалт

Хууль эрх зүйн орчин

Ашигт малтмалын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон энэ хуулийн 38, 39 дүгээр зүйлд заасан үүргийг биелүүлнэ” гэж заасан байдаг.

Мөн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3-д “газрын тос болон уул уурхайн төслүүд нь нөхөн сэргээлт, хаалтын менежментийн төлөвлөгөөг тухайн үйл ажиллагаа эхэлж, хаалт хийхээс гурван жилээс доошгүй хугацааны өмнө боловсруулж, тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авч, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэх”, Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.14-д “уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах” гэж тус тус заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд нарын хамтарсан 2019 оны А/181, А/458 тоот тушаалаар “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам”-ыг баталсан байна.


Өөрөөр хэлбэл ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн хувьд үйл ажиллагаа явуулахад байгаль орчны чиглэлээр дараах бичиг баримтыг бүрдүүлэхээр хуульчилсан байна. Үүнд:

№	Бичиг баримтын нэр	Баталгаажуулах байгууллага	Хугацаа
1	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	ТЭЗҮ батлагдсанаас хойш
2	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Хайгуул (Сумын Засаг дарга), ашиглалт (Байгаль орчин, аялал жуулчлалын яам)	Жил бүр
3	Байгаль орчны менежментийн тайлан	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Жил бүр
4	Уурхайн хаалтын төлөвлөгөө	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Ашиглалт дуусахаас жилийн өмнө

Нөхөн сэргээлтийн талаар

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас ирүүлснээр Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нарын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн

167,/A698,/A/336,/A242 тоот тушаалаар батлагдсан “Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээний биелэлтийн дараах зурагт үзүүлэв.




Нөхөн сэргээлт арга хэмжээний хүрээнд 21 аймаг, нийслэлийн хэмжээнд **37.24** хувьтай байна.

Уурхайн хаалтын талаар

Уул уурхайн практикт тухайн ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах шатнаас эхлэн хаалтын асуудлыг төлөвлөх, төлөвлөлтийн дагуу гүйцэтгэж ирсэн.

Манай улсын хувьд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3-д “... нөхөн сэргээлт, хаалтын менежментийн төлөвлөгөөг тухайн үйл ажиллагаа эхэлж, хаалт хийхээс гурван жилээс доошгүй хугацааны өмнө боловсруулж ...” гэж заасан байна.

Дэлхийд хаагдсан уурхайн статистикийг ав үзвэл тогтоогдсон нөөцийг ашиглаж дуусаад анх төлөвлөсөн хугацаанд уурхайгаа хаасан нь нийт хаагдсан уурхайн $\frac{1}{4}$ буюу 25 хувийг эзэлж байгаа нь гэнэтийн хаалтын зохицуулалтыг нарийвчлан зохицуулах шаардлагатай байгааг харуулж байна.



Уурхайн хаалтад шаардагдах ажилбарууд

Санал: Хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрх зүйн зохицуулалтад уурхайн хаалтын асуудлыг байгаль орчны нөхөн сэргээлттэй холбон ойлгож ирсэн нь хаалтын асуудлыг бүрэн шийдвэрлэхэд хангалтгүй байна. Уурхайн хаалт, хаалтын дараах хяналт, хаасан уурхайг орон нутагт хүлээлгэж өгөх зэрэг асуудлуудыг цогц байдлаар зохицуулах ёстой. Тухайлбал, уурхайн хаалтыг бүрэн хийсэн талбайг цаашид өөр зориулалтаар ашиглахтай холбоотой харилцааг зохицуулсан тогтолцоо шаардлагатай байна.

Сэдвийн дүгнэлт

Ашигт малтмалын тухай хуулийн нөөцийн бүртгэл хийхтэй холбоотой тус хуулийн 111.1.4, 48.4 дэх заалтуудад холбогдох төрийн захиргааны байгууллагуудын чиг үүргийн давхардал байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн №03 тоот зөвлөмжөөр “Ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээг тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрийн 15 хувиас хэтрүүлэхгүй” гэснийг баримталж, хайгуулын тусгай зөвшөөрлийн олголтыг нэмэгдүүлэх, сонгон шалгаруулалтаар авсан хайгуулын тусгай зөвшөөрлийн хүрээнд хайгуул, судалгаа ажлыг тогтвортой явуулах, эрчимжүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсын хилээр экспортолж буй ашигт малтмалд гарал үүслийг олгоходоо холбогдох мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, тээвэрлэлтийн замын хуудас олгож экспортолж буй ашигт малтмалд хяналт тавих нь зүйтэй байна.

Нөөц нь дууссан тусгай зөвшөөрлийн талбайг нөхөн сэргээлт, хаалтыг бүрэн хийлгэх, талбайг хүлээлгэн өгөх, нөөц нь тодорхойгүй тусгай зөвшөөрлүүдийг бүрэн гүйцэтгэх судлах чиглэлийг холбогдох байгууллагад хүргүүлэх, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон хуулийн хязгаарлалтад орсон тусгай зөвшөөрлийн асуудлыг

шийдвэрлэхдээ Улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн ордын нөөцийн асуудлыг давхар шийдвэрлэх нь зүйтэй байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас дутуу материал ирүүлсэн тул бүрэн дүн шинжилгээ хийх боломжгүй байсан. Нөхөн сэргээлт, хаалтын асуудлаар нэмэлт материал шаардлагатай байна.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрх зүйн зохицуулалтад уурхайн хаалтын асуудлыг байгаль орчны нөхөн сэргээлттэй холбон ойлгож ирсэн нь хаалтын асуудлыг бүрэн шийдвэрлэхэд хангалтгүй байна. Уурхайн хаалт, хаалтын дараах хяналт, хаасан уурхайг орон нутагт хүлээлгэж өгөх зэрэг асуудлуудыг цогц байдлаар зохицуулах ёстой. Тухайлбал, уурхайн хаалтыг бүрэн хийсэн талбайг цаашид өөр зориулалтаар ашиглахтай холбоотой харилцааг зохицуулсан тогтолцоо шаардлагатай байна.

3.НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГААС АШИГТ МАЛТМАЛ ХАЙХ, АШИГЛАХ ЗОРИУЛАЛТААР ОЛГОЖ БУЙ ЗӨВШӨӨРӨЛ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

3.1.Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгож буй түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн асуудал

Анх Монгол Улсын Их Хурлаас 2014 онд Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийг баталж, хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг шат шатны аймаг, нийслэлийн Засаг дарга олгохоор хуульчлан баталсан.

Хяналт шалгалтын ажлын хүрээнд Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хувийг хэргийг УИХ-ын архиваас гаргуулж авч үзсэн бөгөөд уг хувийн хэрэгт байгаа үзэл баримтлалд “Хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг хориглосноор хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо буурч, ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо өссөн нь зарим талдаа сайн боловч зам, барилга, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил эрчимжиж байгаа өнөө үед тэдгээр бүтээн байгуулалтад шаардлагатай элс, хайрга зэрэг түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын ажил зогсонги байдалд орсон нь сөрөг үр дагавартай байна” гэсэн нь 2012 оноос Хайгуулын тусгай зөвшөөрлийг олгохыг хориглох тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмал гэж зам, барилгын материалын зориулалтаар ашиглах боломжтой, элбэг тархалт бүхий элс, хайрга, тоосгоны шавар, хүрмэн, боржин, дайрганы зориулалттай барилгын чулууг хэлнэ.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгох процесс



Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу орон нутгаас олгосон нийт **498** тусгай зөвшөөрөл байгаагаас хайгуулын **359**, ашиглалтын **139** тусгай зөвшөөрөл байна.

Аймаг орон нутгаас олгосон түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээлэл /аймгаар/

№	Аймаг	Хайгуулын тусгай зөвшөөрөл	Хайгуулын талбайн хэмжээ /га/	Ашиглалтын тусгай зөвшөөрөл	Талбайн хэмжээ (га)	Тусгай зөвшөөрөл	Талбайн хэмжээ га
1	Архангай	2	51.91	2	165.66	4	217.57
2	Баян-Өлгий	9	1,256.91	8	363.63	17	1,620.54
3	Баянхонгор	12	2,872.07	1	25.34	13	2,897.41
4	Булган	8	892.38			8	892.38
5	Говь-Алтай	13	4,303.68			13	4,303.68
6	Говьсүмбэр	4	946.70	2	319.46	6	1,266.17
7	Дархан-Уул	8	1,015.51	10	1,371.26	18	2,386.76
8	Дорноговь	9	2,085.49	9	2,170.62	18	4,256.10
9	Дорнод	7	948.92	4	149.86	11	1,098.79
10	Дундговь	56	16,376.38	1	104.77	57	16,481.15
11	Завхан	3	433.88			3	433.88
12	Орхон	9	606.06	1	34.10	10	640.17
13	Өвөрхангай	6	620.26	4	122.12	10	742.38
14	Өмнөговь	51	15,599.92	19	4,432.98	70	20,032.90
15	Сүхбаатар	12	3,184.77	2	129.54	14	3,314.31
16	Сэлэнгэ	45	8,508.67	7	632.19	52	9,140.86
17	Төв	26	2,030.76	16	1,542.48	42	3,573.24
18	Увс	3	246.07	1	26.09	4	272.17
19	Улаанбаатар	54	3,407.65	45	3,466.47	99	6,874.12
20	Ховд	8	292.78	2	282.52	10	575.30
21	Хөвсгөл	3	80.05	3	114.99	6	195.04
22	Хэнтий	12	1,321.57	2	102.86	14	1,424.43
	НИЙТ	359	67,082.41	139	15,556.95	498	82,639.35

Дундговь, Сэлэнгэ, Өмнөговь, Улаанбаатар хотуудад түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хамгийн их буюу нийт тусгай зөвшөөрлийн **44** хувийг эзэлж байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл
эзэмшиж буй аж ахуй нэгжийн мэдээлэл

Тусгай зөвшөөрөл	Эзэмшиж буй аж ахуй нэгжийн тоо	Нийт тусгай зөвшөөрөл
1	331	331
2	52	104
3	14	42
4	1	4
5	1	5
6	2	12
Нийт	401	498

Гурваас дээш түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл
эзэмшиж буй аж ахуй нэгжийн жагсаалт

№	Аж ахуй нэгжийн нэр	Эзэмшиж буй ТЗ-ийн тоо	Талбайн хэмжээ (га)
1	Газрын зурвас	4	1,453.17
2	Эрдэсплазм	5	274.52
3	Ноён асралт	6	2,336.31
4	Говь эрдэнэс групп	6	1,542.46

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль батлагдсанаас хойш олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд тогтоогдсон илэрцийн мэдээллийг дараах хүснэгтэд харуулав.

№	ТЗ-ийн дугаар	ТЗ-ийн төрөл	Талбайн нэр	Олгосон огноо	Аймаг	Тайланг ийн дугаар	Илрэлийн төрөл
1	46000019	хайгуул	Шаварт	2015.04.20	Өмнөговь	3740	чулуун нүүрс
2	19233	ашигла лт	Алтан суврага- 8	2015.09.14	Дундговь	1600	уран
3	21000015	хайгуул	Шар энгэр	2016.04.14	Дорнод	5172	манган
4	20784	ашигла лт	Ар хүрэн уул	2017.03.22	Ховд	4505	циркон
5	20898	ашигла лт	Цувраа толгой	2017.08.31	Төв	2078	молибден
6	21120	ашигла лт	Улаан чулууны нуруу	2018.08.16	Баянхонгор	8830	элс
7	43000129	хайгуул	Цагаан толгой	2018.10.24	Сэлэнгэ	5065	шохойн чулуу
8	43000130	хайгуул	Толгод	2018.10.24	Сэлэнгэ	4443	шохойн чулуу
9	82000006	хайгуул	Халиун-2	2018.11.30	Говь-Алтай	4186	шохойн чулуу
10	46000066	хайгуул	Хүрэн толгой	2018.12.24	Өмнөговь	1587	шохойн чулуу
11	21242	ашигла лт	Баянхайрхан	2018.12.26	Архангай	5454	алт
12	22000012	хайгуул	Ар цахилдаг 1	2018.12.27	Сүхбаатар	4443	гянтболд
13	48000048	хайгуул	Зээгийн хэц	2019.02.01	Дундговь	1868	бал чулуу

14	48000074	хайгуул	Нэргүй толгой	2019.03.12	Дундговь	4727	алт
15	43000189	хайгуул	Мандах	2019.05.01	Сэлэнгэ	5157	алт
16	43000160	хайгуул	Хадат	2019.06.06	Сэлэнгэ	4615	элс-хайрганы хольц
17	48000065	хайгуул	Өндөршил	2019.08.22	Дундговь	5463	бал чулуу
18	48000081	хайгуул	Зээг	2019.08.22	Дундговь	1600	хайлуур жонш
19	23000050	хайгуул	Өндөр уул	2019.09.16	Хэнтий	3453	хайлуур жонш
20	48000154	ашигла лт	Улаан	2021.09.06	Дундговь	2036	шаазан-ваарын түүхий эд (шавар)
21	21982	ашигла лт	Хонгор	2021.11.17	Баянхонгор	8825	агат
22	48000157	хайгуул	Хөтөл хяр	2021.11.29	Дундговь	1938	өнгөлгөөний чулуу (гантиг)
23	43000257	хайгуул	Тайхаржин транс ХХК	2022.05.20	Сэлэнгэ	5157	алт
24	41000272	хайгуул	Баянбүрд	2022.06.24	Төв	4971	алт
25	46000215	ашигла лт	Ямаат	2022.08.30	Өмнөговь	5163	зэс

Өөр төрлийн ашигт малтмалын илэрц дээр элс, хайрга, дайрганы хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон байна.

Хяналт шалгалтын хүрээнд 21 аймаг, нийслэлийн Засаг дарга руу Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн байдал, олгосон тусгай зөвшөөрлийн дэлгэрэнгүй мэдээллийг авахаар албан бичиг явуулсан бөгөөд 8 аймаг, нийслэлийн Засаг даргаас хариу ирсэн.

Аймаг, нийслэлийн Засаг дарга нараас ирүүлсэн мэдээлэл судалгаанд анхан шатны боловсруулалт хийж, Ашигт малтмал, газрын тосны газрын бүртгэлийн мэдээлэлтэй тулгаж үзэхэд дараах зөрүүтэй мэдээллүүд байна.

Хяналт шалгалтын хүрээнд Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэст хадгалагдаж байгаа Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн хувийн хэрэг, архивын баримт материалд шалгалт хийхэд Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2-д заасан тусгай зөвшөөрөл олгох боломжгүй гэх дүгнэлт гаргасан боловч, аймаг, нийслэлийн Засаг дарга олгосон 12 тохиолдол байна.

Дээрх олгох боломжгүй гэх дүгнэлт гаргасан аймгийн Засаг дарга нарын олгосон тусгай зөвшөөрлийн жагсаалтыг хүснэгтэд харуулав.

№	Аймаг, нийслэлийн нэр	Талбайн хэмжээ (га)	Өргөдөл гаргагч	Дүгнэлтийн огноо	Олгосон огноо	Дуусах огноо	Төлөв
1	Дорноговь	27.42	Дорноговь АЗЗ ХХК	2018.07.30	2017.07.06	2020.07.06	Хүчингүй
2	Завхан	29.35	Ханжаргалант стоунс ХХК	2022.10.05	2022.12.06	2025.12.06	Хүчинтэй
3	Өвөрхангай	10.01	Алтан-Ёндой ХХК	2016.12.08	2016.07.14	2017.01.20	Хүчингүй
4	Өвөрхангай	344.04	Зул буян ундрах ХХК	2016.12.08	2017.01.02	2020.01.02	Хүчингүй
5	Өвөрхангай	363.36	Майхантаг ХХК	2016.10.25	2016.10.24	2017.01.20	Хүчингүй

6	Өвөрхангай	18.14	Алтан-Ёндой ХХК	2016.10.25	2016.10.25	2017.01.20	Хүчингүй
7	Өвөрхангай	362.55	Майхантээг ХХК	2016.11.01	2016.11.03	2017.01.20	Хүчингүй
8	Сэлэнгэ	31.44	ЗУУБ ХХК	2020.07.06	2023.06.12	2026.06.12	Хүчингүй
9	Хөвсгөл	25.70	Хөвсгөлмон трэйвел ХХК	2018.07.30	2018.04.10	2021.04.10	Хүчингүй
10	Өмнөговь	25.57	Ханбогд Өлзийт ХХК	2022.11.09	2022.08.15	2037.08.15	Ашиглалт
11	Өмнөговь	381.36	Би эл Транс ХХК	2022.12.06	2022.11.16	2037.11.16	Ашиглалт
12	Өмнөговь	198.18	Хошуу овоо ХХК	2023.03.30	2020.08.24	2035.08.24	Ашиглалт

Дээрх 12 тохиолдолд дүн шинжилгээ хийж үзэхэд Өвөрхангай – 5, Өмнөговь – 3, Дорноговь – 1, Завхан – 1, Сэлэнгэ – 1, Хөвсгөл – 1 тус тус байсан бөгөөд 4 хүчинтэй, 8 хүчингүй болгосон байв.

Мөн түүнчлэн Ашигт малтмал, газрын тосны газраас ирүүлсэн ашигт малтмалын болон түгээмэл тархацтай ашигт малтмалын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, ашигт малтмалын хайгуул, ашиглалтын талбайтай зэрэгцүүлэн олгосон байдлыг гаргав.



Зургаас Дундговь /31/, Сэлэнгэ /9/-уудад ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй зэрэгцүүлэн болон дунд нь олгосон тохиолдол хамгийн их байна.

Дундговь аймагт жонш, Сэлэнгэ аймагт алтны тусгай зөвшөөрлийн геологийн хилд дээрх тусгай зөвшөөрлүүдийг олгосон байх магадлалтай байна.

Иймд 2014 онд Монгол Улсын Их хурлаас баталсан Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль анхны үзэл баримтлалтайгаа нийцэхгүй болсон, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн бүртгэл, нөөцийн асуудлыг геологи, уул уурхайн мэргэжлийн ур чадвар бүхий ажилтан, албан хаагч гүйцэтгэх, мэргэжлийн байгууллага уг асуудлыг хариуцах, цаашдаа газрын хэвлийн баялгийг төр нэгдсэн бодлого зохицуулалтаар авч явах шаардлагатай байх тул Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийг хүчингүй болгох зайлшгүй шаардлагатай байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайтай зэрэгцүүлэн олгосон судалгаа

УИХ-ын хяналт шалгалтын түр хорооноос Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг авахаар Ашигт малтмал, газрын тосны газар, аймаг, нийслэлийн Засаг дарга нар руу УИХ-16/3285, УИХ-16/3248 албан тоотыг хүргүүлж нотлох баримтыг авав. Ирүүлсэн албан бичгийн огноо, дугаар гарын үсэг зурсан албан тушаалтан, хавсралт хуудасны тоог харуулав.

Нотлох баримтаар ирүүлсэн албан бичгийн мэдээлэл

#	Байгууллагын нэр	Гарын үсэг зурсан албан тушаалтан	Албан бичгийн огноо, дугаар	Хуудасны тоо
1	Архангай аймаг	Засаг дарга Б.Цэрэннадмид	2024.05.20 01/771	Хавсралт 31 хуудас
2	Баян-Өлгий аймаг	Засаг дарга А.Камелият	2024.05.07 1-01/686	Хавсралт 36 хуудас
3	Баянхонгор аймаг	Засаг дарга Д.Мөнхсайхан	2024.05.13 1а/340	Хавсралт 3 хуудас
4	Булган аймаг		Хариу ирүүлээгүй	
5	Говь-Алтай аймаг	Засаг дарга Г.Чинбат	2024.05.06 2/609	Хавсралт 9 хуудас
6	Говьсүмбэр аймаг		Хариу ирүүлээгүй	
7	Дархан-Уул аймаг	ЗДТГ-ын дарга О.Хүрэлчулуун	2024.05.09 2-10/685	Хавсралт хуудас \50\
8	Дорноговь аймаг	Засаг даргын орлогч Г.Март	2024.05.20 02/724	Хавсралт 170 хуудас
9	Дорнод аймаг		Хариу ирүүлээгүй	
10	Дундговь аймаг	Засаг дарга Ц.Мөнхбат	2024.05.14 01/668	Хавсралт 764 хуудас
11	Завхан аймаг	Засаг дарга Т.Өнөрбаяр	2024.05.01 1/420	Хавсралт 3 хуудас
12	Орхон аймаг	Засаг дарга М.Түмэнжаргал	2024.05.16 01/1577	Хавсралт 19 хуудас
13	Өвөрхангай аймаг	Засаг дарга И.Доржсүрэн	2024.05.03 1/217	Хавсралт 36 хуудас
14	Өмнөговь аймаг	Засаг дарга Р.Сэддорж	2024.05.03 01/1265	Хавсралт 147 хуудас
15	Сүхбаатар аймаг		Хариу ирүүлээгүй	
16	Сэлэнгэ аймаг	Засаг дарга Н.Лхагвадорж	2024.05.08 1/588	Хавсралт 12 хуудас
17	Төв аймаг		Хариу ирүүлээгүй	
18	Увс аймаг	Засаг дарга Ч.Чимэд	2024.05.14 1/876	Хавсралт 127 хуудас
19	Ховд аймаг	Засаг даргын орлогч Х.Батболд	2024.05.21 1/1039	Хавсралт 1 хуудас
20	Хөвсгөл аймаг		Хариу ирүүлээгүй	
21	Хэнтий аймаг		Хариу ирүүлээгүй	
22	Нийслэл	Засаг дарга Х.Нямбаатар	2024.05.03 01/2539	Хавсралт 1089 хуудас \1069\

23	Ашигт малтмал, газрын тосны газар	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Баярмандал	2024.05.02 1/2003	Хавсралт 1 CD
----	-----------------------------------	--	-------------------	---------------

Нотлох баримтаас үзэхэд АМГТГ-ын ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээллийн санд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын 359, ашиглалтын 139 тусгай зөвшөөрөл бүртгэлтэй бол аймаг, нийслэлийн Засаг дарга нараас ирүүлсэн тоо мэдээ нь түүнээс зөрж байгааг харуулав.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээллийн сан болон аймаг, нийслэлд бүртгэлтэй түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн тоо

Д/д	Аймгийн нэр	Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо		Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо	
		Аймгаас ирүүлсэн тоо	Кадастрын мэдээллийн сан	Аймгаас ирүүлсэн тоо	Кадастрын мэдээллийн сан
1	Архангай аймаг \нэгтгэсэн тоо баримт ирүүлээгүй\	Баримт шаардлага хангаагүй	2		2
2	Баян-Өлгий аймаг	7	9	8	8
3	Баянхонгор аймаг	25 \4 хүчинтэй\	12	1	1
4	Булган аймаг	Ирүүлээгүй	8		
5	Говь-Алтай аймаг	12	13	0	0
6	Говьсүмбэр аймаг	Ирүүлээгүй	4		2
7	Дархан-Уул аймаг	4	8	10	10
8	Дорнод аймаг	Ирүүлээгүй	7		4
9	Дорноговь аймаг	6	9	10	9
10	Дундговь аймаг	55	56	1	1
11	Завхан аймаг	3	3	0	0
12	Орхон аймаг	8	9	9	1
13	Өвөрхангай аймаг	6	6	4	4
14	Өмнөговь аймаг	31	51	25	19
15	Сүхбаатар аймаг	Ирүүлээгүй	12		2
16	Сэлэнгэ аймаг	45	45	8	7
17	Төв аймаг	Ирүүлээгүй	26		16
18	Увс аймаг	3	3	1	1
19	Ховд аймаг	6	8	2	2
20	Хөвсгөл аймаг	Ирүүлээгүй	3		3
21	Хэнтий аймаг	Ирүүлээгүй	12		2
22	Нийслэл \нэгтгэсэн тоо баримт ирүүлээгүй\	Баримт шаардлага хангаагүй	54		45
Бүгд			359		139


АМГТГ-аас авсан Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл болон Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээллийн сангаас (ArcGIS программ дээр) түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайтай зэрэгцүүлэн олгосон байдлын судалгааг хийж ерөнхий болон зурган мэдээллийг үзүүлэв.

Судалгаагаар 11 аймгийн Засаг даргын захирамжаар 2015-2023 онд зэрэгцүүлэн олгогдсон 78 хайгуулын, 10 ашиглалтын тусгай зөвшөөрлийн ерөнхий мэдээг үзүүлэв.


Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайтай зэрэгцүүлэн олгосон байдлын судалгаа

Д/д	Аймгийн нэр	Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо	Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо	Хамаарах он, сар
1	Баянхонгор аймаг	6		2019 2021-2022
2	Говь-Алтай аймаг	5		2017-2018 2023
3	Дархан-Уул аймаг	1		2020
4	Дорноговь аймаг	4	1	2015 2019 2023
5	Дундговь аймаг	31		2019-2022
6	Өвөрхангай аймаг	1		2020
7	Өмнөговь аймаг	7	6	2015-2022
8	Сэлэнгэ аймаг	9	1	2015-2022
9	Төв аймаг	7	2	2016-2022
10	Ховд аймаг	1		2015
11	Хэнтий аймаг	6		2017-2020


Аймаг, нийслэлийн Засаг дарга нараас ирүүлсэн түгээмэл тархацтай тусгай зөвшөөрлийн мэдээлэл мэдээ: хайгуулын 186, ашиглалтын 79



Ашигт малтмалын мэдээллийн санд бүртгэлтэй түгээмэл тархацтай тусгай зөвшөөрлийн мэдээлэл: хайгуулын 359, ашиглалтын 139



Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг зэрэгцүүлэн олгосон судалгаа



Судалгаанаас харахад ашигт малтмалын хайгуулын болон алт, нүүрс, жонш, төмөр г.м ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайтай зэрэгцүүлэн Дундговь аймагт 31, Өмнөговь аймагт 13, Сэлэнгэ аймагт 10, Төв аймагт 9 түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгожээ.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй зэрэгцүүлэн олгосон дэлгэрэнгүй судалгаа

Д/д	Аймгийн нэр	Түгээмэл тархацтай АМ-ын ТЗ-ийн тоо	Түгээмэл тархацтай АМ-ын ТЗ олгосон огноо	Аймгийн Засаг даргын нэр	ТЗ-ийн орчим дахь ашигт малтмалын нэр
1	Баянхонгор аймаг	Хайгуул: 7	2019-2022		
	Өлзийт сум	Хайгуул: 1	2021.09.02	Д.Мөнхсайхан	Алт, шороон орд
	Бөмбөгөр сум	Хайгуул: 1	2019.03.15	Г.Батжаргал	Алт, шороон орд
	Баян-Овоо сум	Хайгуул: 1	2019.03.20	Г.Батжаргал	Алт, шороон орд
	Баян-Овоо сум	Хайгуул: 1	2019.03.20	Г.Батжаргал	Алт, шороон орд
	Галуут сум	Хайгуул: 1	2022.10.25	Д.Мөнхсайхан	Алт
	Галуут сум	Хайгуул: 1	2022.10.25	Д.Мөнхсайхан	Алт
2	Говь-Алтай аймаг	Хайгуул: 5	2017-2018-2023		
	Бугат сум	Хайгуул: 1	2018.11.30	Гансэлэм Рэнцэндорж	Нүүрс
	Алтай сум	Хайгуул: 1	2018.12.10	Гансэлэм Рэнцэндорж	Нүүрс
	Тайшир сум	Хайгуул: 1	2023.01.06	О.Амгаланбаатар	Хайгуулын ТЗ Зэс, алт
	Халиун сум	Хайгуул: 1	2018.11.30	Гансэлэм Рэнцэндорж	Хайгуулын ТЗ
3	Дархан-Уул аймаг	Хайгуул: 1	2020		
	Хонгор сум	Хайгуул: 1	2020.08.19	С.Насанбат	Алтны ашиглалт 4 ТЗ
5	Дундговь аймаг	Хайгуул: 31	2019-2022		
	Өлзийт сум	Хайгуул: 1	2021.12.28	Мөнхбат	Жонш
	Өлзийт сум	Хайгуул: 1	2022.03.01	Мөнхбат	Жонш
	Өлзийт сум	Хайгуул: 1	2022.04.20	Мөнхбат	Жонш
	Гурвансайхан сум	Хайгуул: 1	2020.05.05	Сүхбаатар	Жонш
	Гурвансайхан сум	Хайгуул: 1	2019.03.12	Сүхбаатар	Нүүрс, жонш
	Гурвансайхан сум	Хайгуул: 1	2020.09.22	Сүхбаатар	Нүүрс, жонш
	Гурвансайхан сум	Хайгуул: 1	2019.03.12	Сүхбаатар	Нүүрс, жонш

	Өлзийт сум	Хайгуул: 1	2020.05.05	Сүхбаатар	Нүүрс, жонш
	Гурвансайхан сум	Хайгуул: 1	2022.03.01	Мөнхбат	Шороон орд алт
	Гурвансайхан сум	Хайгуул: 1	2019.03.12	Сүхбаатар	Гантиг
	Гурвансайхан сум	Хайгуул: 1	2019.03.12	Сүхбаатар	Гантиг
	Гурвансайхан сум	Хайгуул: 1	2019.03.12	Сүхбаатар	Гантиг
	Гурвансайхан сум	Хайгуул: 1	2019.03.12	Сүхбаатар	Гантиг
	Гурвансайхан сум	Хайгуул: 1	2019.03.12	Сүхбаатар	Гантиг
	Гурвансайхан сум	Хайгуул: 1	2019.03.12	Сүхбаатар	Гантиг
	Гурвансайхан сум	Хайгуул: 1	2019.03.12	Сүхбаатар	Гантиг
	Гурвансайхан сум	Хайгуул: 1	2021.11.29	Сүхбаатар	Жонш, гантиг
	Өндөршил сум	Хайгуул: 1	2020.05.05	Сүхбаатар	Жонш
	Өндөршил сум	Хайгуул: 1	2020.05.05	Сүхбаатар	Жонш
	Өндөршил сум	Хайгуул: 1	2020.07.09	Сүхбаатар	Жонш
	Өндөршил сум	Хайгуул: 1	2019.02.01	Сүхбаатар	Уран, Шохойн чулуу
	Өндөршил сум	Хайгуул: 1	2019.02.01	Сүхбаатар	Уран, Шохойн чулуу
	Өндөршил сум	Хайгуул: 1	2019.03.12	Сүхбаатар	Уран, Шохойн чулуу
	Өндөршил сум	Хайгуул: 1	2019.05.08	Сүхбаатар	Уран, Шохойн чулуу
	Өндөршил сум	Хайгуул: 1	2019.08.22	Сүхбаатар	Уран, Шохойн чулуу
	Өндөршил сум	Хайгуул: 1	2019.08.22	Сүхбаатар	Жонш, Бал чулуу, Манган
	Баянжаргалан сум	Хайгуул: 1	2022.03.01	Мөнхбат	Жонш
	Баянжаргалан сум	Хайгуул: 1	2022.03.01	Мөнхбат	Жонш
	Баянжаргалан сум	Хайгуул: 1	2021.12.28	Мөнхбат	Жонш
6	Өвөрхангай аймаг	Хайгуул: 1	2020		
	Уянга сум	Хайгуул: 1	2020.10.05	И.Доржсүрэн	Алт
7	Өмнөговь аймаг	Хайгуул: 7	2015-2022		
	Ханхонгор сум	Хайгуул: 1	2015.04.20	Бадраа	Нүүрс
	Ханбогд сум	Ашиглалт: 1	2019.11.28	Наранбаатар	Алт, Зэс
	Ханбогд сум	Хайгуул: 1	2020.12.04	Р.Сэддорж	Алт, Зэс
	Ханбогд сум	Ашиглалт: 1	2017.10.04	Наранбаатар	Алт, Зэс
	Ханбогд сум	Ашиглалт: 1	2018.05.23	Наранбаатар	Алт, Зэс
	Баян-Овоо сум	Ашиглалт: 1	2022.08.30	Р.Сэддорж	Алт, Зэс, Холимог металл
	Ханбогд сум	Ашиглалт: 1	2016.01.13	Бадраа	Алт, Зэс, Холимог металл
	Ханбогд сум	Ашиглалт: 1	2018.01.26	Наранбаатар	Алт, Зэс, Холимог металл
	Ханбогд сум	Хайгуул: 1	2019.04.17	Наранбаатар	Алт, Зэс, Холимог металл
	Ноён сум	Хайгуул: 1	2019.01.14	Наранбаатар	Нүүрс
	Ноён сум	Хайгуул: 1	2019.01.14	Наранбаатар	Нүүрс
	Ноён сум	Хайгуул: 1	2019.01.16	Наранбаатар	Нүүрс
	Мандал-Овоо сум	Хайгуул: 1	2022.04.26	Р.Сэддорж	Жонш
8	Сэлэнгэ аймаг	Хайгуул: 9	2015-2022		
	Орхонтуул сум	Хайгуул: 1	2019.06.06	Оргил	Алт
	Орхонтуул сум	Хайгуул: 1	2019.05.01	Оргил	Алт
	Орхонтуул сум	Хайгуул: 1	2019.05.01	Оргил	Алт
	Баянгол сум	Хайгуул: 1	2019.06.06	Оргил	Алт
	Баянгол сум	Хайгуул: 1	2021.03.26	Н.Лхагвадорж	Алт
	Баянгол сум	Хайгуул: 1	2022.05.20	Н.Лхагвадорж	Алт
	Баянгол сум	Хайгуул: 1	2019.05.07	Оргил	Алт
	Ерөө сум	Ашиглалт: 1	2015.06.24	Эрдэнэбат	Төмөр
	Ерөө сум	Хайгуул: 1	2017.03.07	Оргил	Төмөр
	Ерөө сум	Хайгуул: 1	2019.06.06	Оргил	Төмөр

Сэдвийн дүгнэлт

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгосон тусгай зөвшөөрлийн бүртгэл, нөөцийн хөдөлгөөн балансыг хууль батлагдсанаас хойш бүрэн хийгдээгүй байна. Нэр бүхий аймгийн Засаг дарга нар хууль зөрчиж түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгосон байна. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй зэрэгцүүлэн геологийн хилтэй давхцуулан түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгосон асуудлууд хяналт шалгалтаар илэрлээ.

Ингэснээр Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 19.7 Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 12.1, 18.1, 21.2, 24.2, Ашигт малтмалын тухай хуулийн 24.4.2, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.5.2, 8.6.13, 8.8, 8.9, 8.11, 8.16 дахь хэсэг, заалтууд зөрчигдөж байна.

3.2.Бичил уурхайн асуудлууд

Ажлын байр бий болгосноор орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх, ашиглалтын явцад байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг багасгах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаанд хяналт тавих зорилгоор анх Үйлдвэр худалдааны сайдын 2002 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 59 дугаар тушаалаар “Ашигт малтмалыг үйлдвэрлэлийн бус аргаар олборлох түр журам”-ыг баталжээ.

Ашигт малтмалын тухай хуульд 3 дугаар зүйлийн 3.2-т Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг журмаар зохицуулах бөгөөд уг журмыг Засгийн газар батална” гэж заасны дагуу бичил уурхайн эрх зүйн харилцааг дараах Засгийн газрын тогтоолоор зохицуулжээ. Үүнд:

- Засгийн газрын 2008 оны “Бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг 71 дүгээр тогтоолоор;
- Засгийн газрын 2008 оны “Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ыг 72 дугаар тогтоолоор;
- Засгийн газрын 2008 оны “Налайхын нүүрсийг хувиараа ашиглаж байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ийг 89 дүгээр тогтоол;
- Засгийн газрын 2010 оны “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг батлагдсан 308 дугаар тогтоолоор;
- Засгийн газрын 2017 оны “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг 151 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан;
- Засгийн газрын 2019 оны “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 355 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2022 оны “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг 296 дугаар тогтоолоор тус тус баталсан байна.

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд өмнө нь хөндөгдөөгүй болон нөхөн сэргээлт хийж хүлээлгэн өгсөн газар ашиглуулахыг хориглосон байдаг байна.

Бичил уурхай эрхлэгч этгээд нь бичил уурхайгаар ашигт малтмал олборлохыг хүссэн өргөдлийг тухайн сум, дүүргийн Засаг даргад гаргах бөгөөд дараах шаардлагыг хангасан иргэнийг бичил уурхайд ажиллуулна. Үүнд:

- 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн;
- тухайн аймаг, нийслэлд оршин суугчаар бүртгүүлсэн;
- нөхөрлөл, хоршооны гишүүн;

- бичил уурхайн мэргэжлийн холбооны зохион байгуулсан бичил уурхайн эрх зүйн зохицуулалт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, нөхөн сэргээлтийн болон бичил уурхайгаар олборлох бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох сургалтад хамрагдан гэрчилгээ авсан;
- харьяалах аймаг, нийслэлийн татварын албанд татвар төлөгчөөр бүртгүүлсэн байх гэсэн шаардлагуудыг багтаасан байдаг.


Дээрх үндсэн шаардлагуудыг хангаагүй иргэнийг гишүүнээр элсүүлсэн бол тухайн бичил уурхай эрхлэгч этгээдийн гаргасан өргөдлийг хүлээн авахгүй байх нөхцөлтэйгээр журамласан байдаг нь орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байна.

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох нэгж талбайн хэмжээ 5 га-аас ихгүй байх бөгөөд сум, дүүргийн нутаг дэвсгэрт бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талбайн дээд хэмжээг 50 га-аас ихгүй байхаар зохицуулсан байдаг.

Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.23."бичил уурхай эрхлэх" гэж үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон талбайд ашигт малтмал олборлох зорилгоор Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу бүртгэгдээгүй нөхөрлөлийн, Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл болон 36.4-д заасан хоршооны хэлбэрээр зохион байгуулагдсан иргэдийн эрхэлж байгаа үйл ажиллагааг гэж хуульчилсан байна.

БОНХАЖ-ын сайдын 2015 оны А-138 дугаар тушаалаар батлагдсан Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал заасны дагуу эвдэрсэн газар гэж аливаа үйл ажиллагааны улмаас аж ахуйн анхдагч үнэ цэнээ алдаж, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх эх үүсвэр болж хувирсан газрыг хэлнэ гэж заасан байна.

Бичил уурхайн газрын дүгнэлт гаргах процесс



Засгийн газрын 2022 оны “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг 296 дугаар тогтоолоор батлагдан хэрэгжиж эхэлснээс хойш нийт 21 аймгаас 194 албан бичгээр 527 талбайд бичил уурхайгаар ашигт малтмал ашиглах хүсэлт ирүүлсний дагуу ашигт малтмал олборлох боломжтой талбайн 23, боломжгүй талбайн 484, хүчингүй талбайн 7 дүгнэлтийг аймгийн Засаг дарга нарт

тус бүр хүргүүлсэн. Бичил уурхайгаар ашигт малтмал ашиглах хүсэлт ирүүлсэн 13 талбайн дүгнэлт хяналтын шатандаа байна. Үүнээс:

Сэлэнгэ, Дорноговь, Говь-Алтай, Увс, Баян-Өлгий, Хэнтий, Дундговь, Төв, Баянхонгор зэрэг аймгуудын Засаг дарга нараас 2022 онд 17 албан бичгээр ирүүлсэн 85 талбайд бичил уурхайн дүгнэлт гаргуулах хүсэлтийг хүлээн авч ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, эсхүл тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайтай бүхэлдээ буюу хэсэгчлэн давхацсан эсэх талаар дүгнэлт гаргаж, газрын хэмжээ, хил хязгаарыг тогтоох шүүлтийг хийж, ашигт малтмал олборлох боломжтой талбайн 1, боломжгүй талбайн 84 дүгнэлтийг тус тус гарган хариуг тухай бүр хүргүүлсэн;


Сэлэнгэ, Дорноговь, Өмнөговь, Говь-Алтай, Увс, Дундговь, Баянхонгор, Төв, Баян-Өлгий, Өвөрхангай, Булган, Ховд, Хэнтий, Завхан зэрэг аймгуудын Засаг дарга нараас 2023 онд 156 албан бичгээр ирүүлсэн 422 талбайд бичил уурхайн дүгнэлт гаргуулах хүсэлтийг хүлээн авч ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, эсхүл тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайтай бүхэлдээ буюу хэсэгчлэн давхацсан эсэх талаар дүгнэлт гаргаж, газрын хэмжээ, хил хязгаарыг тогтоох шүүлтийг хийж, ашигт малтмал олборлох боломжтой талбайн 22, боломжгүй талбайн 380, хүчингүй болгох талбайн 7 дүгнэлтийг гарган хариуг тухай бүр хүргүүлсэн. Бичил уурхайгаар ашигт малтмал ашиглах хүсэлт ирүүлсэн 13 талбайн дүгнэлт хяналтын шатанд байна.

Сэлэнгэ, Өвөрхангай, Хэнтий, Дархан-Уул, Дорноговь, Дундговь зэрэг аймгуудын Засаг дарга нараас 2024 онд 25 албан бичгээр ирүүлсэн 20 талбайд бичил уурхайн дүгнэлт гаргуулах хүсэлтийг хүлээн авч ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, эсхүл тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайтай бүхэлдээ буюу хэсэгчлэн давхацсан эсэх талаар дүгнэлт гаргаж, газрын хэмжээ, хил хязгаарыг тогтоох шүүлтийг хийж, ашигт малтмал олборлох ашигт малтмал олборлох боломжгүй талбайн 20 дүгнэлтийг тус тус гаргасан байна.

Ашигт малтмалын тухай хуульд бичил уурхайн үйл ажиллагааны онцлог, нөхцөл байдлыг харгалзан үзэж бичил уурхайчид тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын үйлдвэрлэлийн бус агуулгатай эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон үүсмэл орд, илрэл бүхий талбайд ашигт малтмал олборлох эрхийг баталгаажуулсан байна.




Дундговь аймгийн Хулд сумын нутагт орших Ар цагаан, Ацат хүрэн

Бичил уурхайн нөхөрлөлийн гишүүдийн ажиллах нөхцөлийн аюулгүй байдлыг хангаагүй, ажлын мөргөцөгт саравч гаргаж ухсан мөргөцгийн өндрийг хөрс, чулуулгийн тогтоц, шинж чанарыг тооцолгүйгээр хэт өндөр, огцом босоо мөргөцөг (хажуу хана) гаргасан зэрэг үндэслэлээр Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас 2019 онд хийгдсэн хяналт шалгалтаар 12 нөхөрлөлийн үйл ажиллагааг улсын ахлах байцаагчийн актаар зогсоосон байдаг.






Говь-Алтай аймаг Дарви сум. Жавхлант 3 дугаар багийн Хавцгайн амны Баагийн улаан.

Дарив сумын Засаг даргын 2022 оны А/103 тоот, Говь-Алтай аймгийн аймгийн Засаг даргын 2 удаагийн 2023 оны А/31, А/376 тоот захирамжаар хууль бус үйл ажиллагаанаас сэргийлж, халдашгүй байдлыг хангах холбогдуулан пост ажиллуулах шийдвэр гаргасан байна.





Дарив сумын Засаг дарга 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 1/109, 04 дүгээр сарын 19-ний өдрийн 1/110 тоот албан бичгүүдээр хамгаалалт, хяналтын постыг бичил уурхайгаар гэрээ байгуулсан гэх үндэслэлээр 2024 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөр дуусгавар болгох тухай хүсэлтийг 2 удаа аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна. Говь-Алтай аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/300 тоот захирамжаар хяналтын цэгийг 2024 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс татан буулгах шийдвэр гаргасан байна.




Тамгын газрын ажилтны 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн илтгэх хуудсанд суухайн бүс Засгийн газрын 2022 оны 296 дугаар тогтоолоор батлагдсан "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-д заасны дагуу эвдрэлд орсон газрын судалгаанд ороогүй үйлдвэрлэлийн технологийн хаягдал биш зөвхөн шинэ илэрц тул дээрх журамд хамруулах үндэслэлгүй гэсэн хариуг бичил уурхайгаар ашигт малтмал олборлох хүсэлт өгсөн 4 нөхөрлөлд өгсөн гэж дурдсан байна.

Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд ирүүлсэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 01/5091 өдрийн албан бичгийн хавсралтаар ирүүлсэн хууль бус үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын мэдээлэлд Хавцгайн амны Баагийн нэртэй газрын талаар ороогүй байна.



Говь-Алтай аймгийн Дарив сумын Жавхлант 3 дугаар багийн нутагт орших Хавцгайн амны Баагийн улаан нэртэй газар нь алтны илэрэлтэй нь үнэн болно гэсэн бичгийн сумын Засаг дарга 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 1/184 тоот албан бичгээр хүргүүлж байсан байна. Стандарт хэмжил зүйн үндэсний төвөөс итгэмжлэгдсэн "Актлабс Эйши" ХХК-аар хийлгэсэн лабораторийн шинжилгээний хариуг хавсралтаар хүргүүлсэн байна.



ACTLABS ASIA LLC. USB-1403 Final Report



Element	Unit	Result	Limit	Pass/Fail
As	mg/kg	0.01	0.01	Pass
Cd	mg/kg	0.01	0.01	Pass
Cr	mg/kg	0.01	0.01	Pass
Pb	mg/kg	0.01	0.01	Pass
Hg	mg/kg	0.01	0.01	Pass
Mn	mg/kg	0.01	0.01	Pass
Co	mg/kg	0.01	0.01	Pass
Ni	mg/kg	0.01	0.01	Pass
Fe	mg/kg	0.01	0.01	Pass
Zn	mg/kg	0.01	0.01	Pass
Al	mg/kg	0.01	0.01	Pass
Si	mg/kg	0.01	0.01	Pass
Ca	mg/kg	0.01	0.01	Pass
Mg	mg/kg	0.01	0.01	Pass
Na	mg/kg	0.01	0.01	Pass
K	mg/kg	0.01	0.01	Pass
Cl	mg/kg	0.01	0.01	Pass
S	mg/kg	0.01	0.01	Pass
F	mg/kg	0.01	0.01	Pass
Br	mg/kg	0.01	0.01	Pass
I	mg/kg	0.01	0.01	Pass
B	mg/kg	0.01	0.01	Pass
Li	mg/kg	0.01	0.01	Pass
Be	mg/kg	0.01	0.01	Pass
Ba	mg/kg	0.01	0.01	Pass
Sr	mg/kg	0.01	0.01	Pass
Y	mg/kg	0.01	0.01	Pass
Zr	mg/kg	0.01	0.01	Pass
Nb	mg/kg	0.01	0.01	Pass
Mo	mg/kg	0.01	0.01	Pass
Ta	mg/kg	0.01	0.01	Pass
W	mg/kg	0.01	0.01	Pass
P	mg/kg	0.01	0.01	Pass
V	mg/kg	0.01	0.01	Pass
Cr	mg/kg	0.01	0.01	Pass
Mn	mg/kg	0.01	0.01	Pass
Co	mg/kg	0.01	0.01	Pass
Ni	mg/kg	0.01	0.01	Pass
Cu	mg/kg	0.01	0.01	Pass
Zn	mg/kg	0.01	0.01	Pass
Pb	mg/kg	0.01	0.01	Pass
Bi	mg/kg	0.01	0.01	Pass
Po	mg/kg	0.01	0.01	Pass
At	mg/kg	0.01	0.01	Pass
Rn	mg/kg	0.01	0.01	Pass
Fr	mg/kg	0.01	0.01	Pass
Ra	mg/kg	0.01	0.01	Pass
Ac	mg/kg	0.01	0.01	Pass
Th	mg/kg	0.01	0.01	Pass
Pa	mg/kg	0.01	0.01	Pass
U	mg/kg	0.01	0.01	Pass
Np	mg/kg	0.01	0.01	Pass
Pu	mg/kg	0.01	0.01	Pass
Am	mg/kg	0.01	0.01	Pass
Cm	mg/kg	0.01	0.01	Pass
Bk	mg/kg	0.01	0.01	Pass
Cf	mg/kg	0.01	0.01	Pass
Es	mg/kg	0.01	0.01	Pass
Fm	mg/kg	0.01	0.01	Pass
Md	mg/kg	0.01	0.01	Pass
No	mg/kg	0.01	0.01	Pass
Lr	mg/kg	0.01	0.01	Pass

Page 2 of 3




Говь-Алтай аймгийн Дарив сумын Засаг даргын 2022 оны 1/100 тоот албан бичгээр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанд тодорхой газруудыг тусгай хэрэгцээнд авах, эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөх хүсэлтийг хүргүүлсэн байна.

Говь-Алтай аймгийн Дарив сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн “Газар нутгийг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах тухай” 14 дүгээр тогтоолоор 2 дугаар багийн “Дэрстийн эх”, 3 дугаар багийн “Баагийн Улаан” гэх газруудыг бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан байдаг.



Говь-Алтай аймгийн Дарив сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн “Газар нутгийг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах тухай” 14 дүгээр тогтоол бичил уурхайн зориулалтаар олгох газрын байршил, эргэлтийн цэгийг тодорхойлсон хавсралт хоёр өөр байна.





Говь-Алтай аймгийн Дарив сумын Засаг дарга 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 1/221 тоот албан бичгээр Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн "Газар нутгийг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах тухай" 14 дүгээр тогтоолоор тусгай хэрэгцээнд авсан газруудад мэргэжлийн байгууллагаар нарийвчилсан хэмжилт хийлгэн, солбицолд өөрчлөгдөөгүй тул бичил уурхайн зориулалтаар ашиглаж болох талаар дүгнэлт гаргуулах хүсэлтийг аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна.



Говь-Алтай аймгийн Засаг даргын 2023 оны 1/1425 тоот албан бичгээр Дарви сумын ИТХ-ын 2023 оны "Газар нутгийг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах тухай" 14 дүгээр тогтоолоор тусгай хэрэгцээнд авсан газруудын солбицолд өөрчлөгдөөгүй тул бичил уурхайн зориулалтаар ашиглаж болох талаар дүгнэлт гаргуулах хүсэлтийг Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлсэн байна. Уг хүсэлтийг үндэслэн 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 10/1251 тоот албан бичгээр бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай дүгнэлтийг гарган аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна.



Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Салбарын хяналтын газраас 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 06-00/003 тоот төлөвлөгөөт бус шалгалтын удирдамжаар Говь-Алтай аймгийн Дарив сумын 3 дугаар багийн нутагт орших Хавцгайн амны Баагийн улаан нэртэй газарт Говь-Алтай аймгийн Засаг даргад хүргүүлсэн Кадастрын хэлтсийн даргын 2024 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 10/1251 дугаартай дүгнэлт гарсан талбайд албан томилолтоор ажилласан байна.



Хяналт шалгалтаар ажиллах үеийн газар тогтоогдсон дээрх нөхцөл байдал. Ашигт малтмал, газрын тосны газраас ирүүлсэн өгөгдсөн солбицол бүхий талбайн дотор туршилтын байдлаар 3 ам гаргаж хөндөгдсөн байсан бөгөөд олборлолтын үйл ажиллагаа хийгдсэн /цагдаагийн алба хаагчдын яриагаар сүүлийн 2 жил орчим хууль бусаар олборлосон, доошоо 10 орчим метр ухсан хэмээн ярьж байсан/ нөхцөл байдалтай байна. Мөн тус талбай нь өмнө олгогдоод хаагдсан хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай дотор байршилтай байсан байна.



Сэдвийн дүгнэлт

Бичил уурхайн асуудлуудаар нотлох баримтыг шинжлэн судлахад Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны хууль, эрх зүйн зохицуулалтууд “нэгдсэн зохион байгуулалтад оруулж, ажлын байр бий болгох, орон нутгийн төсөвт орох орлогыг нэмэгдүүлэх, бичил уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах” гэсэн анхны үзэл баримтлал нь дэвшүүлсэн зорилтоо хангасан, одоо цаг үе, ач холбогдлоо алдсан;

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулах нэрээр халхавчлан “журамд зааснаас том оврын техник, хэрэгсэл ашиглах, нөхөн сэргээгдээгүй эвдрэлд орсон талбайд үйл ажиллагаа явуулах ёстой байтал хөндөгдөөгүй эрүүл талбайд хөндөгдсөн гэх хуурамч материал бүрдүүлэн олборлох, санаатайгаар хууль бус олборлогч нарыг оруулж, эвдрэлд оруулах” зэрэг журмын хэрэгжилтэд нийтлэг алдаа завхрал нэмэгдэх хандлагатай;

Хууль бусаар ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагааг таслан зогсооход чиглэгдсэн арга хэмжээг эрчимжүүлэх, хууль, хяналт, хүчний болон холбогдох байгууллагуудын хоорондын мэдээлэл солилцох ажлын уялдаа холбоог сайжруулах, эвдрэлд орсон, орхигдсон талбайн байгаль орчинд учруулсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлж нөхөн сэргээх ажлыг гүйцэтгүүлэх, хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай;

Бичил уурхайн зориулалтаар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор орон нутгийн тусгай хэрэгцээнд авч байгаа үйл ажиллагаа нь Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу бодит нөхцөл байдлыг тогтоосон, холбогдох нотлох баримтыг нягтлан судалсан эсэхэд хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллагууд хамтран хяналт шалгалтыг хийж гүйцэтгэх;

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг журмаар зохицуулахад гарч байгаа хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Ашигт малтмалын тухай хуулийн 3.2-д заасан бичил уурхайн зохицуулалтыг хүчингүй болгож, энэхүү үйл ажиллагаанаас үүссэн бодит хохирлыг тогтоох, нөхөн сэргээх, байгаль орчны тогтвортой байдлыг хангах зэрэг дүгнэлтийг хийлээ.

4. АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИД ТӨЛБӨР, ТАТВАР НОГДУУЛАХ, ТАЙЛАГНАХ, ТӨЛӨХ, ХЯНАХ, ХУРААХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах, төлөх, хянах, хураах үйл ажиллагаа

Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ.” гэж заасан нь төр өөрийн баялгийг аливаа этгээдэд ашиглуулж, түүний өгөөжийг ард нийтээр тэгш шударга хүртээж байгалийн баялаг ард түмний өмч байх баталгааг хангаж өгсөн байна.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь байгалийн баялгийн өгөөжийг ард түмэнд хүртээх зорилгоор хуулиар ногдуулж буй төлбөр бөгөөд Татварын ерөнхий хуульд зааснаар "төлбөр" гэдэг нь төрийн өмчийн газар, газрын хэвлий, **байгалийн баялаг**, ой, ургамал, рашаан, **ашигт малтмал**, газрын тосны нөөц, агаар, ус, хөрс **ашигласны**, бохирдуулсны, ан амьтан агнасны **төлөө аливаа этгээдээс авч төсөвт төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгө** гэж заасны дагуу газрын гадаргуу, хэвлийд үүсэж бий болсон, аливаа хэрэгцээнд ашиглаж болох байгалийн байдлаараа байгаа эрдсийн хуримтлалыг ашигласны төлөө төсөвт төлж байгаа аж ахуйн үйл ажиллагааны үр ашгаас үл хамааран төлөх төлбөр юм.

Анх УИХ-аас 1994 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр “Ашигт малтмалын тухай хууль”-ийг баталснаар Монгол Улсад ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааг төрийн эрх бүхий байгууллагаас олгосон “тусгай зөвшөөрөл”-ийн үндсэн дээр явуулах эрх зүйн зохицуулалттай болсон.

Монгол Улсад Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ногдуулахтай холбоотой дараах эрх зүйн актууд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Үүнд:

1. Монгол Улсын хууль:

- ▶ Ашигт малтмалын тухай хууль -2006 он;
- ▶ Татварын ерөнхий хууль -2019 он;
- ▶ Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль -2023 он;

2. Засгийн газрын тогтоол:

- ▶ Аргачлал батлах тухай 2011 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 193 дугаар тогтоол – Ашигт малтмалын хүдэр, баяжмал, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинд тавигдах шаардлага, ангилал, тооцох үндсэн зарчим, аргачлал;
- ▶ Биржийн болон зах зээлийн үнийн эх сурвалжийн нэр зарлах тухай 2016 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн 81 дүгээр тогтоол;
- ▶ Тогтоолын хавсралт шинэчлэн батлах, хавсралтад өөрчлөлт оруулах тухай 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 465 дугаар тогтоол -

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам;

- ▶ Тогтоолын хавсралтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2013 оны 04 дугаар сарын 06-ны өдрийн 131 дүгээр тогтоол - “Уул уурхайн бүтээгдэхүүний жишиг үнийг нийтэд мэдээлэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллуулах”;
- ▶ Биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллыг батлах тухай 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 223 дугаар тогтоол;

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлд Засгийн газар биржийн болон зах зээлийн үнийн эх сурвалжийн нэр зарлах /АМТХ-47.14/, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журмыг батлах /АМТХ-47.6/, хүдэр, баяжмал, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинд тавигдах шаардлага, ангилал, тооцох үндсэн зарчим, аргачлалыг батлахаар зохицуулсан.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн ногдуулалт, төлөлт

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-д зааснаар ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, ашигт малтмал экспортолсон этгээд, Монголбанк, арилжааны банканд алт тушаасан этгээд гэсэн 3 субъект ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байна.

Борлуулалтын үнэлгээ:

АМНАТ-ийг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д заасан “бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлого”-д ногдуулдаггүй бөгөөд ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээг тооцож, тухайн үнэлгээнд ногдуулдаг.

АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээг тухайн бүтээгдэхүүнийг худалдсан, худалдахаар ачуулсан, экспортолсон, өөрийн хэрэгцээнд ашигласан бүтээгдэхүүний агуулгын цэвэр хувь хэмжээ, шинж чанар, ангиллаас хамааран АМТХ-ийн 47 дугаар зүйлийн 47.2-т заасны дагуу тодорхойлно:

- ▶ Экспортод бүтээгдэхүүн гаргасан бол олон улсын худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн тухайн сарын дунджийг тогтоох зарчмыг үндэслэн тухайн бүтээгдэхүүний, эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийг баримтлан;
- ▶ Дотоодод борлуулсан буюу ашигласан бол тухайн бүтээгдэхүүний, эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний дотоодын зах зээлийн үнийг үндэслэн;
- ▶ Дотоод, гадаадын зах зээлд борлуулсан бүтээгдэхүүний зах зээлийн жишиг үнийг тодорхойлох боломжгүй тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдүүлсэн борлуулалтын орлогыг үндэслэн;

Экспортолсон бүтээгдэхүүний агуулга, түүний хувь, шинж чанар, ангиллыг Гаалийн лабораторийн дүгнэлтэд үндэслэн тодорхойлсны дагуу борлуулалтын үнэлгээ тооцоход ашигладаг.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээг дараах байдлаар тооцно:

$$Бү = Бх * Ах * Бдү$$

Бү - Хүдэр ба баяжмалын борлуулалтын үнэлгээ

Бх - Хүдэр ба баяжмалын биет хэмжээ /хүндийн жингийн нэгжээр/

Ах - Хүдэр, баяжмал дахь тухайн бүтээгдэхүүний агуулгын хувь

Бдү -

Экспортын бүтээгдэхүүний олон улсын бирж, эх сурвалжийн дундаж үнэ

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.14-т “Экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний үндэслэл болгох олон улсын жишиг үнэ тогтоодог биржийн, зах зээлийн үнийн эх сурвалжийн нэрийг тухайн бүтээгдэхүүний төрлийг харгалзан Засгийн газар нийтэд зарлах” зохицуулалттай.

Хуулийн дээрх зохицуулалтын хүрээнд Засгийн газрын 2016 оны 81 дүгээр тогтоолоор зарласан эх сурвалжид үндэслэн Сангийн яам, Уул уурхайн яам, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг “Экспортод гаргасан ашигт малтмалын бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийн мэдээлэл”-ийг албан ёсны цахим хуудас [/www.mof.gov.mn/](http://www.mof.gov.mn)-д байршуулан, сар бүр мэдээлж байна.

Эх сурвалж:

- ▶ www.lme.com/
- ▶ www.mongolbank.mn/
- ▶ www.indmin.com
- ▶ www.umetal.com
- ▶ www.asianmetal.com
- ▶ www.en.sxcoal.com

Эрдэс баялгийн бүтээгдэхүүний сүүлийн 5 жилийн зах зээлийн үнийн дундаж, (ам.дол/тн)

	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
Алт	44.0	55.6	57.9	58.5	62.4
Мөнгө	0.5	0.6	0.8	0.7	0.7
Зэс	6,007.2	6,027.4	9,165.0	8,912.4	8,482.8
Жонш	365.0	319.6	299.7	341.5	370.7
Төмөр	73.0	86.1	135.7	95.0	98.5
Молибдени	24,147.9	19,129.5	33,242.5	39,965.0	53,511.2
Цагаан тугалга	18,839.6	16,912.8	30,935.4	32,651.6	25,982.8
Гянтболд	12,957.9	12,049.1	15,453.6	16,972.7	16,852.3
Цайр	2,577.9	2,222.0	2,952.7	3,507.7	2,648.5
Хар тугалга	1,999.2	1,816.2	2,180.8	2,160.3	2,136.5
Хөнгөн цагаан	1,808.3	1,678.9	2,419.0	2,731.6	2,251.2
Манган	242.0	198.1	192.0	192.1	164.0
Нүүрс-Боловсруулаагүй	88.7	70.5	132.8	144.3	109.1
Нүүрс- Баяжуулсан	109.6	97.2	184.9	163.7	126.6
Нүүрс-Кокс	169.5	179.1	316.9	337.9	219.6

Эх сурвалж: ТЕГ

Ногдуулах хувь, хэмжээ:

- ▶ Үндсэн хувь - 5.0%;
- ▶ Нэмэлт хувь /АМТХ-47.5, 47.17/;

- ▶ Олборлож өөрийн хэрэгцээнд ашигласан, дотоодод худалдсан нүүрс 2.5%, Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд худалдсан алт 5.0% /нэмэлт төлбөргүй/;
- ▶ Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь 5.0% хүртэл Засгийн газар тогтоож болно.
- ▶ Үүсмэл ордоос олборлосон 2.5% /нэмэлт төлбөргүй/;

Нэмэгдүүлэн ногдуулах ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг бүтээгдэхүүний боловсруулалтын түвшин (хүдэр, баяжмал, бүтээгдэхүүн)-ээс хамааруулан хүдэрт их, эцсийн бүтээгдэхүүнд бага байх зарчмаар өөр өөр хувиар тооцон ногдуулдаг. (АМТХ-47.5, 47.17)

АМТХ-ийн 47 дугаар зүйлийн 47.5 дахь заалтын хэсгээс

Бүтээгдэхүүний нэр төрөл	Хэмжих нэгж	Жишиж үнэлэх бүтээгдэхүүн	Зах зээлийн үнийн түвшин /ам.доллар/	Бүтээгдэхүүний боловсруулалтын түвшингээс хамаарч үндсэн хувь дээр нэмж ногдуулах хувь		
				Хүдэр	Баяжмал	Бүтээгдэхүүн
Зэс	тн	Зэс /цэвэр металл/	0-5000 хүртэл	0	0	0
			5000-6000 хүртэл	22	11	1
			6000-7000 хүртэл	24	12	2
			7000-8000 хүртэл	26	13	3
			8000-9000 хүртэл	28	14	4
			9000 ба түүнээс дээш	30	15	5

Эх сурвалж: Ашигт малтмалын тухай хууль

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах зарчим

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.7, 47.16-д заасны дагуу Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг давхардуулан ногдуулахгүй бөгөөд 47.18-д заасан төлбөрийн баримт, 47.19-д заасны дагуу суутган ногдуулсан тайланг үндэслэн өмнө нь ногдуулсан төлбөрийг хасаж тооцдог бөгөөд энэхүү зохицуулалт нь татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлан”-гийн маягтад тусгагдсан байгаа нь төлбөр төлөгч нь өмнөх шатны борлуулагчийн төлсөн болон суутган авч, төсөвт шилжүүлсэн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг хасаж тооцох нөхцөлийг бүрдүүлж өгсөн байна.

АМНАТ-ийг давхардуулан ногдуулахгүй гэсэн хуулийн зохицуулалтын хэрэгжиж буй байдлыг нүүрсний жишээ нь дээр авч үзвэл:

Тусгай зөвшөөрөл эзэмшигч “А” компани өөрийн олборлосон 100 тн боловсруулаагүй нүүрсийг өөрөө экспортолсон. Тухайн сарын олон улсын зах зээлийн үнийг баримтлан зарласан сарын дундаж жишиг үнэ 130 доллар байсан гэвэл:

“А” компани:

$$БҮ=130\$*100тн=13000\$$$

$$Төлбөл зохих АМНАТ=13000\$*(5\% үндсэн+5\% нэмэлт)=1300\$$$

Хэрвээ тусгай зөвшөөрөлгүй “Б” компани тусгай зөвшөөрөл эзэмшигч “А” компаниас 100 тн боловсруулаагүй нүүрсийг 110 \$-оор худалдан авч экспортолсон тохиолдолд:

“А” компани:

$$БҮ=110\$*100тн=11000\$$$

$$Төлбөл зохих АМНАТ=11000\$*2.5\%=275\$$$

“Б” компани:

$$БҮ=130\$*100тн=13000\$$$


$$Төлбөл зохих АМНАТ=13000\$*(5\% үндсэн+5\% нэмэлт)-275\$=1025$$

Харин эрдэс баялгийн бүтээгдэхүүнийг дотоодод борлуулсан тохиолдолд Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.2.-т “дотоодод борлуулсан буюу ашигласан бол тухайн бүтээгдэхүүний, эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний дотоодын зах зээлийн үнийг үндэслэн” гэж заасны дагуу аж ахуйн нэгжүүд борлуулалтын орлого /гэрээний үнэ/-оор борлуулалтын үнэлгээг тооцон АМНАТ-ийг ногдуулан төлж байгаа бөгөөд аливаа нэг этгээдээс дотоодын борлуулалтын үнийг зарлах, зохицуулах харилцаа одоогоор байхгүй байгаа нь тусгай зөвшөөрөлгүй экспортлогчдын өмнөх шатанд ногдуулан төлсөн АМНАТ-ийг хасаж тооцох дүн харилцан адилгүй, бүтээгдэхүүний чанар, тоо хэмжээтэй уялдаагүй, өөр хооронд нь жишиглэх боломжгүй хэт ялгавартай байгаагаас эцсийн экспортлогчид татварын ачаалал төвлөрч маргаан зөрчил үүсэх шалтгаан болж байна.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлагнал

АМНАТ нь улсын төсвийн орлогын томоохон эх үүсвэр болдгийн хувьд төлбөр ногдуулах аргачлал, арга зүйг жил бүр боловсронгуй болгох, бүтээгдэхүүнийг олборлон борлуулах, экспортлох тухай бүрд бүрэн ногдуулах талаар анхааран татварын байгууллагын зүгээс 2022 оноос цахим тайлангийн системд Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлан /ТТ-15 маягт/-г цахимжуулсан байгаа нь тухайн тайланг үнэн, зөв тайлагнах нөхцөлийг хангаж, Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд ашигт малтмалын бүтээгдэхүүнийг олборлох, борлуулах, тээвэрлэх, экспортлох зэрэг бүх үйл ажиллагаатай холбогдох гэрээг татварын нэгдсэн системд бүртгэж, бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох боломжийг бүрдүүлсэн байна.

АШИГТ МАЛТМАЛЫН ГЭРЭЭ БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА




Эх сурвалж: ТЕГ

Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-т болон Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.11-т заасны дагуу татвар төлөгч татварын тайланг хуулиар тогтоосон хугацаанд харьяа татварын албанд тушаах үүрэгтэй.

Мөн татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-т заасны дагуу татвар төлөгч холбогдох татварын хуулиар төлбөл зохих татварын ногдлоо өөрөө тодорхойлж, хуулиар тогтоосон хугацаанд төсөвт төлнө.

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.10, 47.12-т заасны дагуу бүх төрлийн ашигт малтмалд ногдох тухайн сарын төлбөрийг дараагийн сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайлангаар хийсэн эцсийн тооцоогоо дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор болон тушаасан алтны борлуулалтын үнэлгээнээс суутгасан төлбөрийг тухай бүр улсын төсөвт шилжүүлэх үүрэгтэй.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлангийн ирц (2019-2023 он)



Эх сурвалж: ТЕГ


Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлангийн ирц 2022 онд 88.3 хувьтай буюу 157 аж ахуйн нэгж, 2023 онд 91 хувьтай буюу 129 аж ахуйн нэгж тайлан ирүүлээгүй байна.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн ногдуулалт, төлөлтийн байдал

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.10, 47.12-т заасны дагуу бүх төрлийн ашигт малтмалд ногдох тухайн сарын төлбөрийг дараагийн сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайлангаар хийсэн эцсийн тооцоогоо дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор болон тушаасан алтны борлуулалтын үнэлгээнээс суутгасан төлбөрийг тухай бүр улсын төсөвт шилжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын хэмжээнд 2018-2023 оны ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн ногдол, төлөлтийн мэдээлэл дараах байдалтай байна.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн ногдол, төлөлт




Эх сурвалж: ТЕГ

Татварын алба тайлант жилийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлангийн ногдлыг тухайн жилдээ дунджаар 85.1 хувьтай хураан барагдуулсан байдалтай байна. Үлдсэн 15 орчим хувьд Татварын ерөнхий хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2-т “Татварын алба нэхэмжлэхийг татварын өр үүссэн хугацаанаас хойш ажлын 30 өдөрт багтаан татвар төлөгчид хүргүүлнэ.” гэж заасны дагуу өрийн нэхэмжлэх хүргүүлж өр хураах ажиллагаа эхлүүлдэг.

АМНАТ-ийн ногдол, төлөлтийн дүн тогтмол өсөлттэй байгаа бөгөөд 2018 он болон 2023 онуудыг харьцуулбал даруй 4 дахин өссөн байна. 2022 оны ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн ногдуулалт 3.1 их наяд төгрөг байсан бол 2023 онд 1.7 их наяд төгрөгөөр өссөн нь нүүрсний экспортын тоо хэмжээ өмнөх оноос 118.8 хувиар өссөнтэй холбоотой бөгөөд татварын албаны тайлангийн ирцийн мэдээлэл, тайлангаарх ногдлын мэдээллийг гаалийн экспортын мэдээлэлтэй харьцуулан шинжлэн судалж үзвэл:

Ашигт малтмал экспортолсон аж ахуйн нэгж, бүтээгдэхүүний тоо хэмжээ



Эх сурвалж: ТЕГ, ГЕГ

2018 онд 80 аж ахуйн нэгж ашигт малтмалын бүтээгдэхүүнийг экспортолсон бол 2023 оны байдлаар 326 болж 4 дахин нэмэгдсэн байна. Сүүлийн 6 жилийн дунджаар нийт экспортолсон бүтээгдэхүүний 97 орчим хувийг тусгай зөвшөөрөлтэй этгээд экспортолж ирсэн байна.

2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн “Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн үзэл баримтлалд “Үндэсний статистикийн газраас авсан мэдээллээр 2012-2016 онд нийт 381 сая ам.долларын 1.6 сая тонн жонш экспортод гарсан байна. Тухайн жилүүдэд 34.6 тэрбум төгрөг АМНАТ хэлбэрээр улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх байснаас 11.1 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.” гэж дурьдсан байх бөгөөд тус хуулийн өөрчлөлтөөр 47.1-т ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд АМНАТ төлөгч байхаар зохицуулсан бөгөөд 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар 47.1-т ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, 47.2-т ашигт малтмал экспортолсон этгээд гэж нарийвчилж өгсөн байна.

Ашигт малтмал экспортолсон тусгай зөвшөөрөлгүй этгээдийн экспортолсон тоо хэмжээ нийт ашигт малтмалын бүтээгдэхүүний экспортын 2022 онд 3%, 2023 онд 5.6 %-ийг эзэлж байгаа боловч 2022 онд 85 тусгай зөвшөөрөлгүй этгээд бүтээгдэхүүн экспортолсноос 12 аж ахуйн нэгж буюу 14.1 хувь нь, 2023 онд 193 тусгай зөвшөөрөлгүй этгээд бүтээгдэхүүн экспортолсноос 30 аж ахуйн нэгж буюу 15.5 хувь нь тус тус тайлагнаагүй үзүүлэлттэй байгаа нь дээрх хуулийн үзэл баримтлал бүрэн хангагдаж чадаагүй байна.

Сүүлийн 2 жилд авч үзвэл бүтээгдэхүүн экспортолсон боловч татварын албанд Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлан тайлагнаагүй 2022 онд 21, 2023 онд 44 аж ахуйн нэгж байна.

2022 онд ашигт малтмал экспортолсон боловч тайлагнаагүй ТЗ эзэмшигч /тн/

Д/д	Регистр	ААН нэр	АМ	2022 он
1	2874482	Баялаг жонш ХХК	Жонш	26,981.31
2	2036231	Шаширтрейд ХХК	Жонш	15,630.87
3	5853583	Ди Жи Ти энд Эм ХХК	Жонш	6,056.05
4	5581729	Си Жи Си Эм ХХК	Жонш	3,476.92
5	2057417	Наймган-Орд ХХК	Жонш	2,721.70
6	5237572	Мон минералс майнинг энд трейд	Жонш	1,809.83
7	5162696	Галзоо хан ХХК	Жонш	776.34
8	5076307	Ньюфлюорит ХХК	Жонш	63.22
9	5412153	Меланж	Нүүрс	57.95
		Нийт		57574.20

Эх сурвалж: ТЕГ, ГЕГ

2022 онд ашигт малтмал экспортолсон боловч тайлагнаагүй ТЗ-гүй этгээд (тн)

Д/д	Регистр	ААН нэр	АМ	2022 он
1	4187865	Дүүбэнхаус ХХК	Нүүрс	36,383.03
2	5517419	Хайрхантоб ХХК	Төмөр	24,480.20
3	6908365	Ундрах арвин уул ХХК	нүүрс	19,921.70
4	5547121	Рейт-Инвест ХХК	Төмөр	16,808.40
5	3635112	Амуу даймонд транс ХХК	Нүүрс	16,624.02
6	6658385	Феррум металл монголиа ХХК	Төмөр	14,059.45
7	5380499	ОТБАР ХХК	Нүүрс	9,850.60
8	6188117	Сүлд орд ХХК	Нүүрс	9,648.50
9	5544734	Галтмагнай трейд	Нүүрс	3,127.60
10	3371077	Үлэмжхүч транс ХХК	Боржин	52.92
11	6271286	Феллерс саплай ХХК	Давс	21.17
12	6883605	Френч партнер голд ХХК	Жонш	20.00
		Нийт тоо хэмжээ		150997.59

Эх сурвалж: ТЕГ, ГЕГ

2023 онд ашигт малтмал экспортолсон боловч тайлагнаагүй ТЗ эзэмшигч

Д/д	Регистр	ААН-ийн нэр	АМ	Тоо хэмжээ /тн/
1	2874482	Баялаг жонш ХХК	Жонш	22,602.78
2	5379334	Түшигт-Ээл ХХК	Жонш	20,060.46
3	2036231	Шаширтрейд ХХК	Жонш	11,295.33
4	5162696	Галзоо хан ХХК	Жонш	7,940.27
5	5567319	Фокусметал майнинг	Төмөр	6,745.22
6	5853583	Ди Жи Ти энд Эм ХХК	Жонш	4,922.69
7	6255671	Анхай лантан	Төмөр	3,146.00
8	5581729	Си Жи Си Эм ХХК	Жонш	1,700.54
9	2057417	Наймган-Орд ХХК	Жонш	679.20
10	5095719	Говьмастер ХХК	Жонш	185.65
11	5076307	Ньюфлюорит ХХК	Жонш	155.09
12	2849046	Тайхар орд ХХК	Жонш	131.54
13	6168825	Цэгц финанс	Жонш	69.70
14	2045931	Монлаа ХХК	Төмрийн хүдэр	29.80
		Нийт		79,664.27

Эх сурвалж: ТЕГ, ГЕГ

2023 онд ашигт малтмал экспортолсон боловч тайлагнаагүй ТЗ-гүй этгээд (тн)

Д/д	Регистр	ААН-ийн нэр	АМ	Тоо хэмжээ /тн/
1	3635112	Амуу даймонд транс ХХК	Нүүрс	71,380.72
2	6861288	КЭБД менежмент ХХК	Нүүрс	23,140.50
3	5517419	Хайрхантоб ХХК	Төмөр	21,538.17
4	6133193	Хубилай хаан инвест ХХК	Нүүрс	16,042.22
5	5547121	Рейт-Инвест ХХК	Төмөр	13,037.65
6	6908365	Ундрах арвин уул ХХК	Нүүрс	10,067.15
7	6741398	Шилмэл ойн жим ХХК	Нүүрс	9,619.50
8	6211887	Хишигтэн арвай ХХК	Нүүрс	9,375.86
9	5173396	Си Ти Ар ХХК	Нүүрс	6,695.80
10	3873005	Чандмань -Энх трейд ххк	Нүүрс	6,546.20
11	6775845	Таван тийш хүргэх зам ХХК	Нүүрс	6,407.50
12	6622577	Вигор трейд ХХК	Нүүрс	6,387.74
13	2607794	Стар мондата ХХК	Нүүрс	6,299.00
14	8327734	Истерн брайт сентури ХХК	Жонш	4,153.53
15	6983812	Булсара сара ХХК	Нүүрс	3,361.70
16	4202619	Арвижих азын хайрхан ХХК	Нүүрс	3,318.08
17	6722962	Айрон майнинг сүрвэй ХХК	Төмөр	3,257.50
18	6795803	Монтрак холдинг ХХК	Нүүрс	3,205.55
19	6938043	Прайм роу трейд ХХК	Нүүрс	3,144.10
20	4187865	Дүүбэнхаус ХХК	Нүүрс	3,130.30
21	4284879	Говь хасуй ХХК	Нүүрс	3,123.12
22	6270131	Мега майнд маркетерс ХХК	Нүүрс	3,069.12
23	6854753	Юни СОРА ХХК	Нүүрс	3,013.85
24	6961614	Чин төмөрт корпораци ХХК	Төмөр	2,968.40
25	8370796	Жи Эф Эн моунтайн майнинг индастри ХХК /ГХО/	Жонш	635.20
26	8377766	Ай Би Л Си тал монголиа майнинг ХХК	Нүүрс	399.45
27	4409094	Мон рос эко ХХК	Зэс	300.00
28	3072444	Моты ХХК	Жонш	35.00
29	6271286	Феллерс саплай ХХК	давс-Бусад	22.86
30	5881196	Их асралт трейд ХХК	давс-Бусад	22.07
		Нийт		243,697.85

Эх сурвалж: ТЕГ, ГЕГ

Эдгээр 2022, 2023 онд экспорт хийсэн боловч тайлагнаагүй аж ахуйн нэгжийн 14 нь ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, 30 нь тусгай зөвшөөрөлгүй экспортлогч байна. Эдгээр 14 тусгай зөвшөөрөлтэй этгээдийн 11 нь жоншны тусгай зөвшөөрөл эзэмшигч байх тул эдгээр жонш экспортолсон аж ахуйн нэгжийн 2022, 2023 онд ногдуулан тайлагнах байсан АМНАТ-ийг тооцож үзвэл:

Жонш олборлох тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тусгай зөвшөөрөлгүй жонш экспортлогчид АМНАТ ногдуулсан болон ногдуулаагүй мэдээлэл

Он	Экспортын хэмжээ /тн/	Ногдуулсан АМНАТ /сая.төг/	Тайлагнаагүй экспортын хэмжээ /тн/	Нөхөн ногдуулах АМНАТ /сая.төг/
2022	417,293	26,665,1	59,597	5,720.0
2023	1,109,787	69,994.8	28,139	3,063.4

Эх сурвалж: ТЕГ

2023 оны байдлаар бүтээгдэхүүн экспортолсон боловч татварын албанд АМНАТ-ийн тайлан тайлагнаагүй 44 аж ахуйн нэгж байна. Үүнээс жоншны экспорт

дийлэнх хувийг эзэлж байгаа бөгөөд нийт 8.8 тэрбум төгрөгийн АМНАТ тайлагнах, төлөхөөс зайлсхийсэн үйлдэл гэж үзэхээр байна.

Дээрх он дараалан ашигт малтмал экспортолсон боловч хуульд заасан хугацаанд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайланг татварын албанд тушаагаагүй, төлбөрийг хуулийн дагуу бүрэн ногдуулаагүй ахуйн нэгжүүдээс тусгай зөвшөөрөлтэй 2, тусгай зөвшөөрөлгүй 2 аж ахуйн мэдээлэл дараах байдалтай байна.

ТЕГ, ТЕГ-аас нотлох баримтаар ирүүлсэн мэдээллээс: (Баялаг жонш ХХК)

Ашигт малтмалын нэр	Хэмжих нэгж	2018	2019	2020	2021	2022	2023
Жоншны баяжмал	тн	1,951.5	1,262.6	206.2	134.5		
Жоншны хүдэр	тн	15,964.2	16,739.2	19,138.8	24,390.1	26,981.3	22,602.8
Нийт дүн	тн	17,915.7	18,001.8	19,345.0	24,524.5	26,981.3	22,602.8

АМНАТ-ийн тайлангийн ирцийн мэдээ

Он	Ирүүлбэл зохих тайлан	Ирүүлсэн тайлан	Хувь	"х" тайлантай эсэх	Ногдол
2019	1	1	100%	1	0
2020	1	1	100%	1	0
2021	1	1	100%	1	0
2022	1	1	100%	1	0
2023	1	1	100%	1	0


Хяналт, шалгалтад хамруулсан мэдээ (2022 он)

Шийдвэрийн төрөл	Хэмжих нэгж	Зөрчлийн дүн	Нөхөн татварын дүн	Торгуулийн дүн	Алдангийн дүн	Төлбөрийн дүн
Нөхөн татварын акт	сая.төг	128,331.6	6,085.7	1,825.7	1,017.7	8,929.1

Өрийн үлдэгдэл (2023.12.31)

Тайлангийн хэлбэр	Хэмжих нэгж	АМНАТ	Алданги, торгууль	Бүгд
Хяналт шалгалт	сая.төг	5,985.7	2,843.4	8,829.1
Тайлан	сая.төг	0.0	0.0	0.0
Нийт дүн	сая.төг	5,985.7	2,843.4	8,829.1

Харилцан хамаарал тогтоогдсон байдал



Харилцан хамаарал бүхий Ди Жи Ти энл Эм ХХК нь мөн адил он дараалан жонш экспотолсон боловч АМНАТ-ийг тайлагнаагүй, төлөөгүй байдалтай байна.

ГЕГ, ТЕГ-аас нотлох баримтаар ирүүлсэн мэдээлэл (Ди Жи Ти энд Эм ХХК)

Ашигт малтмалын нэр	Хэмжих нэгж	2018	2019	2020	2021	2022	2023
Жоншны баяжмал	тн	944.7					
Жоншны хүдэр	тн	14,912.1	10,649.7	7,980.8	8,171.8	6,056.1	4,922.7
Нийт дүн	тн	15,856.8	10,649.7	7,980.8	8,171.8	6,056.1	4,922.7

АМНАТ-ийн тайлангийн ирцийн мэдээ

Он	Ирүүлбэл зохих тайлан	Ирүүлсэн тайлан	Хувь	"х" тайлантай эсэх	Ногдол
2019	1	1	100%	1	0
2020	1	1	100%	1	0
2021	1	1	100%	1	0
2022	1	1	100%	1	0
2023	1	1	100%	1	0

Хяналт, шалгалтад хамруулсан мэдээ (2022 он)

Шийдвэрийн төрөл	Хэмжих нэгж	Зөрчлийн дүн	Нөхөн татварын дүн	Торгуулийн дүн	Алдангийн дүн	Төлбөрийн дүн
Нөхөн татварын акт	сая.төг	65,975.9	3,137.0	1,057.5	556.1	4,750.6

Өрийн үлдэгдэл (2023.12.31)

Тайлангийн хэлбэр	Хэмжих нэгж	АМНАТ	Алданги, торгууль	Бүгд
Хяналт шалгалт	сая төг	3,037.0	0.0	3,037.0
Тайлан	сая төг	0.0	0.0	0.0
Нийт дүн	сая төг	3,037.0	0.0	3,037.0

ГЕГ, ТЕГ-аас нотлох баримтаар ирүүлсэн мэдээлэл (Шаширтрейд ХХК)

Ашигт малтмалын нэр	Хэмжих нэгж	2018	2019	2020	2021	2022	2023
Жоншны хүдэр	тн	5,890.8	13,513.8	15,663.4	9,036.0	8,189.6	2,413.1
Жоншны баяжмал	тн				3,404.9	7,441.3	8,882.2
Нийт дүн	тн	5,890.8	13,513.8	15,663.4	12,440.9	15,630.9	11,295.3

АМНАТ-ийн тайлангийн ирцийн мэдээ

Он	Ирүүлбэл зохих тайлан	Ирүүлсэн тайлан	Хувь	"х" тайлантай эсэх	Ногдол (мян.төг)
2019	1	0	0%	0	0
2020	1	1	100%	0	43,544.2
2021	1	1	100%	0	32,144.0
2022	1	0	100%	1	0
2023	1	0	100%	1	0

Хяналт, шалгалтад хамруулсан мэдээ (2022 он)

Шийдвэрийн төрөл	Хэмжих нэгж	Зөрчлийн дүн	Нөхөн татварын дүн	Торгуулийн дүн	Алдангийн дүн	Төлбөрийн дүн
Нөхөн татварын акт	сая.төг	64,027.80	3,074.50	1,092.10	647.1	4,813.60

Өрийн үлдэгдэл (2023.12.31)

Тайлангийн хэлбэр	Хэмжих нэгж	АМНАТ	Алданги, торгууль	Бүгд
Хяналт шалгалт	сая.төг	3,437.0	1,739.1	5176.1
Тайлан	сая.төг	73.9	0	73.9
Нийт дүн	сая.төг	3,510.9	1,739.1	5,250.0

ГЕГ, ТЕГ-аас нотлох баримтаар ирүүлсэн мэдээлэл (Дүүбэнхаус ХХК)

Ашигт малтмалын нэр	Хэмжих нэгж	2018	2019	2020	2021	2022	2023
Нүүрс (боловсруулаагүй)	тн				51,652.9	13,508.2	
	тн					22,874.9	3,130.3
Нийт дүн	тн	0.0	0.0	0.0	51,652.9	36,383.0	3,130.3

АМНАТ-ийн тайлангийн ирцийн мэдээ

Он	Ирүүлбэл зохих тайлан	Ирүүлсэн тайлан	Хувь	"х" тайлантай эсэх	Ногдол
2021	1	0	0.00%	0	0
2022	1	0	0.00%	0	0
2023	1	0	0.00%	0	0

Хяналт, шалгалтад хамруулсан мэдээ

Шийдвэрийн төрөл	Хэмжих нэгж	Зөрчлийн дүн	Нөхөн татварын дүн	Торгуулийн дүн	Алдангийн дүн	Төлбөрийн дүн
Нөхөн татварын акт	сая.төг	0	0	0	0	0

Өрийн үлдэгдэл (2023.12.31)

Тайлангийн хэлбэр	Хэмжих нэгж	АМНАТ	Алданги, торгууль	Бүгд
Хяналт шалгалт	сая.төг	0	0	0
Тайлан	сая.төг	32.5	0	32.5
Нийт дүн	сая.төг	32.5	0	32.5

ГЕГ, ТЕГ-аас нотлох баримтаар ирүүлсэн мэдээллээс: (Хайрхантоб ХХК)

Ашигт малтмалын нэр	Хэмжих нэгж	2018	2019	2020	2021	2022	2023
Төмрийн хүдэр	тн	0.0	0.0	0.0	13,353	13,848	12,636
Төмрийн баяжмал	тн	0.0	0.0	0.0	3,050	10,632	8,902
Нийт дүн	тн	0.0	0.0	0.0	16,403.2	24,480.2	21,538.2

АМНАТ-ийн тайлангийн ирцийн мэдээ

Он	Ирүүлбэл зохих тайлан	Ирүүлсэн тайлан	Хувь	"х" тайлантай эсэх	Ногдол (сая төг)
2021	1	1	100%	0	256.8
2022 I	1	1	100%	1	0
2022 II	1	1	100%	0	739.9
2022 III	1	0	0%	0	0
2022 IV	1	0	0%	0	0
2023	1	0	0%	0	0

Хүснэгт-25 Хяналт, шалгалтад хамруулсан мэдээ

Шийдвэрийн төрөл	Хэмжих нэгж	Зөрчлийн дүн	Нөхөн татварын дүн	Торгуулийн дүн	Алдангийн дүн	Төлбөрийн дүн
Нөхөн татварын акт	сая.төг	0	0	0	0	0

Өрийн үлдэгдэл (2023.12.31)

Тайлангийн хэлбэр	Хэмжих нэгж	АМНАТ	Алданги, торгууль	Бүгд
Хяналт шалгалт	сая.төг	0	0	0
Тайлан	сая.төг	996.7	0	996.7

Нийт дүн	сая.төг	996.7	0	996.7
----------	---------	-------	---	-------

Дээрх нотлох баримтуудаас харахад ашигт малтмалын бүтээгдэхүүн экспортолсон боловч хуулийн дагуу тайлагнах, төлөхөөс зайлс хийсэн үйлдэл ажиглагдаж байна. Татварын алба эдгээр аж ахуйн нэгжүүд /Дүүбэнхаус ХХК, Хайрхантоб ХХК/-ийг бүрэн хяналт шалгалтад хамруулаагүй байна. Мөн дээрх аж ахуйн нэгжүүд татварын албаны хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчилд нөхөн ногдуулсан төлбөрийг төлж барагдуулаагүй байдалтай байна.

Үүсмэл ордоос олборлосон ашигт малтмалын бүтээгдэхүүнд ногдох ашигт малтмалын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

2001 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйл буюу Тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны төрөлд 2016 оны 11 дүгээр сарын 10-ний өдрийн хуулиар 15.10.22-т “үүсмэл орд ашиглах” гэж нэмсэн бөгөөд Ашигт малтмал, газрын тосны газар 2017 онд Ачит Ихт ХХК-д үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгосон байх бөгөөд тус компани нь ашигт малтмалын тухай хуулийн 47³ дугаар зүйлийн 47³.1-д “Үүсмэл ордоос олборлосон бүтээгдэхүүнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ тухайн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 2.5 хувь, энэ хуулийн 47.5-д заасан нэмэлт төлбөрийн хэмжээ 0 хувьтай тэнцүү байна” гэсэн заалтын дагуу тайлагнаж ирсэн байна.

2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр “Зөвшөөрлийн тухай хууль” шинэчлэн батлагдан 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль” хүчингүй болсон мөн Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Ашигт малтмалын асуудлаар Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 9.1.14-т “үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон үйл ажиллагааны журмыг батлах” гэсэн заалт, 26 дугаар зүйлийн 26.11.-т “Энэ хуулийн 26.10-д заасан гэрээ, үүсмэл ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн дүгнэлт, шийдвэрийг үндэслэн геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрлийг гурван жилийн хугацаатайгаар олгоно.” гэсэн заалтууд 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болж “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын үүсмэл ордыг худалдан авсан болон гэрээний үндсэн дээр ашиглагч 6 аж ахуйн нэгж ашигт малтмалын тухай хуулийн 47³ дугаар зүйлийн 47³.1-д заасны дагуу тайлагнах эрх зүйн орчин бүрдсэн байна.

2023 оны эхний 9 сарын байдлаар үүсмэл ордоос олборлон экспортолсон бүтээгдэхүүнд АМНАТ 47.3, 47.5 болон 47³.1 заалтаар тооцоолж үзэхэд 1 тонн катодын зэсд ногдох төлбөр 614.4 мянган төгрөгөөр буурсан байна.

АМТХ-ийн 47³ дугаар зүйлийн 47³.1-д заасан хувь хэмжээгээр тайлагнасан нөлөөлөл

АМТХ-ийн Заалт	Тоо хэмжээ /тонн/	Борлуулалтын үнэлгээ	АМНАТ	Нэмэлт АМНАТ	Нийт АМНАТ	Нэгж бүтээгдэхүүнд ногдох АМНАТ
47.3, 47.5	11,619.02	346,294,236.00	11,350,878.79	4,445,085.27	15,795,964.06	1,359.49
473.1	11,619.02	346,294,236.00	8,657,355.90	-	8,657,355.90	745.10

	АМНАТ-ийн зөрүү		2,693,522.89	4,445,085.27	7,138,608.16	614.39
--	-----------------	--	--------------	--------------	--------------	--------

Дагалдах ашигт малтмалын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3.3-т “энэ хуулийн 47.3.1, 47.3.2-т зааснаас бусад **бүх төрлийн ашигт малтмалын** нөөц ашигласны төлбөр тухайн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 5.0 хувь”, Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах төлөх журмын 2.8-д “Нүүрснээс бусад ашигт малтмалын бүтээгдэхүүнд АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээг лабораторийн шинжилгээний дүгнэлтээр тодорхойлсон агуулгын цэвэр хувь, хэмжээнд үндэслэн үндсэн болон **дагалдах металл, эрдэс бүтээгдэхүүн** тус бүрээр тооцно.”, 3.2-д “Ашигт малтмалын бүтээгдэхүүнд дагалдах металл болон эрдэс бүтээгдэхүүнд ашигт малтмалын нөөц ашигласны нэмэлт төлбөрийг Ашигт малтмалын тухай хуулийн 47.5 дахь хэсэгт заасан боловсруулалтын түвшний **“бүтээгдэхүүн”** ангиллын хувь хэмжээгээр тооцож ногдуулна.” гэж зохицуулсан байна.

Монгол Улсын хэмжээнд 2018-2023 онд алт, мөнгө, гянтболд, зэс, манган, төмөр, хар тугалга, цагаан тугалга, цайрын хүдэр, баяжмалд агуулагдах дагалдах ашигт малтмалд АМНАТ ногдуулалт дараах байдалтай байна.

Дагалдах ашигт малтмалд ногдуулсан АМНАТ (сая.төг)

Ашигт малтмалын төрөл	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
Алт	1,828.3				5.9	4.8
Гянтболд	0.0			6.1	16.8	9.8
Зэс	47,956.8	50,694.2	52,636.6	118,556.2	84,854.6	91,033.2
Манган					29.2	2.3
Мөнгө					5,383.2	4,674.8
Төмөр	719.8	538.3	1,795.8	7,036.1	6,051.1	9,958.5
Хар тугалга	0.0				13,124.9	10,329.6
Цагаан тугалга					3.7	7.3
Цайр	5,754.5	8,185.2	10,747.6	13,700.2	2,447.7	2,242.8
Дагалдах АМ-ын ногдол	56,259.5	59,417.7	65,180.1	139,298.7	111,917.2	118,263.2
Дагалдах агуулдаг АМ-ын ногдол	581,979.9	548,780.7	649,502.5	1,025,260.8	1,118,604.3	1,258,876.4
Дагалдах АМ-ын ногдлын эзлэх хувь	9.67%	10.83%	10.04%	13.59%	10.01%	9.39%

Эх сурвалж: ТЕГ

Дагалдах ашигт малтмалын АМНАТ-ийн ногдол нь алт, мөнгө, гянтболд, зэс, манган, төмөр, хар тугалга, цагаан тугалга, цайрын нийт хүдэр, баяжмалд ногдуулсан АМНАТ-ийн нийт дүнгийн дунджаар 10.6 хувийг эзэлж байна.


Энэхүү ногдуулалт нь гаалийн лабораторийн дүгнэлтээр илэрсэн хүдэр, баяжмалаас ялган авах боломжгүй, эдийн засгийн үр ашиггүй бүх төрлийн дагалдах ашигт малтмалд ногдуулж байгаа нь асуудал үүсгэдэг байна.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулалтад хяналт хэрэгжүүлсэн байдал

Татварын алба татварын ерөнхий хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-т заасны дагуу татвар төлөгч татварын хууль тогтоомжид заасны дагуу төлбөл зохих татварын ногдлоо бүрэн гүйцэд тодорхойлж, хугацаанд нь төлсөн эсэхийг хянан шалгадаг.


Татварын албаны Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, татвар төлөгчийн хууль даган мөрдөлтийг нэмэгдүүлэх зорилгоор Татварын ерөнхий хуулийн 35, 41 дүгээр зүйлд заасны дагуу эрсдэлийн үнэлгээг тооцоолон хяналт шалгалт хийсэн мэдээлэл дараах байдалтай байна.

Татварын хяналт шалгалтад хамруулсан татвар төлөгчийн тоо (2019-2023 он)




Эх сурвалж: ТEG

Татварын хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчилийн мэдээ,
тэрбум төгрөг (2019-2023 он)



Эх сурвалж: ТЕГ

Татварын хяналт шалгалтаар нөхөн ногдуулсан татвар,
алданги, торгууль (2019-2023 он)



Эх сурвалж: ТЕГ

Сүүлийн 5 жилд Татварын албаны хийсэн хяналт шалгалтын мэдээнээс харахад нийт хяналт шалгалтын 6.4 орчим хувь нь уул уурхайн компани байгаа бол шалгагдсан уул уурхайн компаниудын 24.5 хувьд нь АМНАТ-тэй холбоотой зөрчил илэрсэн байна.

Сүүлийн 2 жилд шалгасан уул уурхайн компанийн тоо өмнөх онуудаас 50 орчим хувиар нэмэгдсэн бөгөөд, 2022 онд Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (тухайн үеийн) -тай хамтран эрдэс баялгийн бүтээгдэхүүн экспортолсон боловч ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлан гаргаагүй 85 татвар төлөгчид тусгайлсан удирдамжтай шалгалт хийж нийт төлбөр ногдох суурь үнэлгээний 2.3 их наяд төгрөгийн зөрчил илрүүлэн 164.6 тэрбум төгрөгийн төлбөрийг нөхөн ногдуулсан байна.

Татварын хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчлийг мөнгөн дүнгээр авч үзвэл нийт хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчлийн дунджаар 30.4 хувь нь уул уурхайн салбарын аж ахуйн нэгжид илэрсэн бол ашигт малтмалын нөөц ашигласны төлбөртэй холбоотой зөрчил дунджаар нийт ногдуулсан төлбөрийн 20.2 хувийг тус тус эзэлж байна.

Татварын ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1-т заасны дагуу Татвар төлөгч нөхөн ногдуулалтын актыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хүлээн зөвшөөрөхгүй бол нөхөн ногдуулалтын актыг гардан авснаас хойш 30 хоногийн дотор энэ хуулийн 46.1-д заасан Маргаан таслах зөвлөлд гомдол гаргаж болно.

Татварын ерөнхий газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлд 2019-2023 онд АМНАТ-тэй холбоотой 37 маргаан хэлэлцэгдсэнээс 37 гомдлын нөхөн ногдуулалтыг хэвээр үлдээхээр шийдвэрлэсэн байна.

Маргаан таслах зөвлөлийн шийдвэр: /тэрбум.төг/

ААН /АМ төрлөөр/	Татвар төлөгчийн тоо	ТМТЗ-ийн хурлаар төлүүлэхээр шийдвэрлэсэн	
		Зөрчлийн дүн	Нийт төлбөр
Катодын зэс	1	91.4	4.8
Гянтболд	1	7.3	0.9
Жонш	19	1,316.0	101.6
Зэс	2	7,663.4	671.8
Нүүрс	6	848.7	52.5
Төмөр	8	528.0	23.3
Нийт	37	10,454.8	854.9

Эх сурвалж: ТЭГ

Эдгээрээс 19 татвар төлөгч буюу 50 орчим хувь нь жонш олборлогч, экспортлогч аж ахуйн нэгжүүдийн 1,316.0 тэрбум төгрөгийн зөрчилд ногдуулсан 101.6 тэрбум төгрөгийн төлбөр, зэсийн бүтээгдэхүүн экспортлогч 2 татвар төлөгчийн 7,663.4 тэрбум төгрөгийн зөрчилд ногдуулсан 671.8 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийн дүн 90 орчим хувийг эзэлж байна.

АМНАТ-тэй холбоотой маргаан таслах зөвлөлөөр шийдвэрлэгдсэн Татварын улсын байцаагчийн 5 актыг шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн байдалтай байна.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн өр, хураах үйл ажиллагаа

Татварын ерөнхий хуулийн 50 дугаар зүйлд зааснаар хугацаандаа төлөөгүй татвар, алданги, торгуулийг татварын өрд тооцно. Татвар төлөгчийн татварын тайлангаар болон нөхөн ногдуулалтын акт, шийтгэлийн хуудсаар тогтоосон татвар, алданги, торгуулиас татварын өр үүснэ.

Татвар төлөгчийн тайлангаар тодорхойлсон татварын хувьд татварын хууль, тогтоомжид зааснаар татвараа төлж, тайлагнасан байх ёстой өдрөөр, нөхөн ногдуулалтын акт, шийтгэлийн хуудсаар тогтоосон татвар, алданги, торгуулийн хувьд уг шийдвэрийг гардуулснаас хойш ажлын 15 өдөр, татварын хууль тогтоомжоор тайлагнадаггүй татварын хувьд татварын хууль тогтоомжоор татвараа төлсөн байх ёстой өдрөөс хойш өрд тооцно.

Татварын албаны уул уурхайн салбарын нийт өр, түүнд эзлэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн өрийн мэдээлэл дараах байдалтай байна.

Уул уурхайн салбарын нийт өр, түүнд эзлэх АМНАТ-ийн өр (2023.12.31)

Татварын төрлийн нэр	Тайлангийн өр	Хяналт, шалгалтын өр	Нийт дүн
		/ сая төгрөг /	
УУЛ УУРХАЙН САЛБАРЫН НИЙТ ӨР	2,007,464.8	1,335,507.5	3,342,972.3
Үүнээс: АМНАТ-ийн нийт өр	824,060.2	304,524.0	1,128,584.2
АМНАТ-Нэмэлт төлбөр	14,347.3	104,334.6	118,681.9
АМНАТ-Суутгасан	10.9		10.9
АМНАТ-Тусгай зөвшөөрөл эзэмшигч	688,784.8	175,889.8	864,674.6
АМНАТ-Тусгай зөвшөөрөлгүй татвар төлөгч	119,103.3	24,299.6	143,402.9
АМНАТ-Үүсмэл орд	1,813.8		1,813.8

Эх сурвалж: ТЕГ

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн нийт өрийн мэдээлэл 2023.12.31-ний байдлаар, сая төгрөгөөр /үүссэн оноор/

Тайлант он	АМНАТ-Тусгай зөвшөөрөлтэй	АМНАТ-Нэмэлт төлбөр	АМНАТ-үүсмэл орд	АМНАТ-Тусгай зөвшөөрөлгүй татвар төлөгч	Нийт дүн
2011	124.1	-			124.1
2012	999.5	3,557.55			4,557.05
2013	3,041.80	2,358.83			5,400.63
2014	9,954.92	494.18			10,449.09
2015	1,349.55	48.24			1,397.78
2016	2,439.99	66.59			2,506.58
2017	5,843.30	5,227.83			11,071.13
2018	13,723.33	290.52			14,013.85
2019	29,787.90	2,303.59		1,046.10	33,137.59
2020	42,599.00	354.71		4,008.70	46,962.41
2021	41,074.25	-	-	21,795.85	62,870.10
2022	135,414.26	78,855.74	-	41,236.27	255,506.27
2023	578,322.74	25,124.14	1,813.83	75,326.90	680,587.61
НИЙТ	864,674.64	118,681.92	1,813.83	143,413.82	1,128,584.20

Эх сурвалж: ТЕГ

Татварын албанд хуримтлагдсан АМНАТ-ийн өр 2011 оноос 2023 оны байдлаар 514 аж ахуйн нэгжид хамаарах нийт 1.1 их наяд төгрөг байгаагаас ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч 242 аж ахуйн нэгжийн өр 864.7 тэрбум төгрөг буюу 76.6 хувийг эзэлж байна. Мөн нийт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн өрийн 73 хувийг тайлангаар ногдуулсан өр эзэлж байна.

Татварын ерөнхий хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу татвар төлөгчийн өр барагдуулахтай холбоотой авч хэрэгжүүлсэн ажиллагаа дараах байдалтай байна.

Уул уурхайн салбарын татвар төлөгчийн татварын өр хураах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал. Үүнд:

- ▶ Татварын өртэй 1,557 /давхардсан тоогоор/ татвар төлөгчийн 3.8 их наяд төгрөгийн өрийн нэхэмжлэх;
- ▶ 302 татвар төлөгчийн 784.9 тэрбум төгрөгийн өрд банкн дахь данс битүүмжлэх;
- ▶ 6 татвар төлөгчийн 29.6 тэрбум төгрөгийн өрд эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааг тус тус хийсэн байна.

Ашигт малтмалын өртэй татвар төлөгчдөөс голлох ашигт малтмалын төрлөөр ангилан хамгийн өндөр өртэй, насжилт өндөртэй өртэй, хяналт шалгалтын өртэй гэсэн үзүүлэлтээр түүвэрлэн сонгогдсон аж ахуйн нэгжийн өрийн мэдээлэл дараах байдалтай байна. /2023.12.31-ний байдлаарх/

АМНАТ-ийн өрийн мэдээлэл /сая.төг/

Д/д	ТТ нэр	ТТД	АМ	Тайлангийн өр	Өрийн насжилт	Хяналт шалгалтын өр	ХШ-ын өр үүссэн огноо
1	МОЭНКО	5141583	Нүүрс	134,619.43	2022-2024 он	7,764.63	2023
2	Ихговь энерги	5522935	Нүүрс	25,584.03	2016-2024 он	-	
3	Алтайнхүдэр	5095549	Төмөр	63,713.08	2012-2022 он	11,674.65	2023
